



**СОЁЛЫН ЯАМ**



**Тайлангийн дугаар: 220019**

**ОЛОН УЛСАД НҮҮДЛИЙН ӨВ СОЁЛЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ  
ТӨРИЙН БОДЛОГО, АРГА ТУРШЛАГЫН СУДАЛГААНЫ  
ТАЙЛАН**

Захиалагч: Соёлын яам

Гүйцэтгэгч: ЮНЕСКО-ийн ивээл дор НСИСОУХ

Улаанбаатар хот

2022 он

*Энэхүү тайланг Монгол Улсын Соёлын Яамны захиалгаар ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн Соёл Иргэнилийг Судлах Олон Улсын Хүрээлэнгийн “ОЛОН УЛСАД НҮҮДЛИЙН ӨВ СОЁЛЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГО, АРГА ТУРШЛАГА СУДЛАХ” сэдэвт тойм судалгааны ажлын хүрээнд хийж гүйцэтгэв.*

Хянасан: И.Бямбабаатар (Доктор, НСИСОУХ)

Судалгааны багийн ахлагч: С.Мөнх-Очир (НСИСОУХ)

Судалгааны багийн гишүүд: Н.Гэрэлт (Доктор, НСИСОУХ ), Ч.Мөнхтуул (Доктор, НСИСОУХ), М.Пагмадулам (НСИСОУХ), Шахеразаде Кхан (Дадлагажигч оюутан, АНУ-ын Макалестер Коллеж)

Улаанбаатар хот  
2022 он

## АГУУЛГА

УДИРТГАЛ.....	3
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: МОНГОЛ УЛС БА НҮҮДЛИЙН СОЁЛ.....	15
1.1. Монгол Улсын төрөөс нүүдлийн соёлыг хадгалж хамгаалах, сурталчлах, дэлгэрүүлэх чиглэлд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа.....	15
ХОЁРДУГААР БҮЛЭГ: КАЗАХСТАН БА НҮҮДЛИЙН СОЁЛ.....	20
2.1. Эртний үндэстэн болохын баталгаа: Казахын нүүдлийн соёл.....	21
2.2. Казах үндэстэн, Казахстан үндэстний дундах нүүдлийн соёл.....	28
ГУРАВДУГААР БҮЛЭГ: КИРГИЗТАН БА НҮҮДЛИЙН СОЁЛ.....	37
3.1. Нүүдэлчин киргизүүдийн аж ахуйн тухай: Уламжлалт соёл, Исламын шашин хоёрыг жинлэх нь.....	37
3.2. Киргизстан дахь угсаатан хоорондын харилцаа ба нүүдлийн соёл.....	41
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ОХУ БА НҮҮДЛИЙН СОЁЛ.....	44
4.1. Алс Дорнодын жижиг үндэстнүүдийн соёл.....	44
4.2. Орос дахь нүүдлийн соёл: Уугуул иргэдийн амьжиргаа.....	48
ТАВДУГААР БҮЛЭГ: ТУРК БА НҮҮДЛИЙН СОЁЛ.....	51
5.1. Төв Азиас ирсэн нүүдэл ба өнөөгийн цөөнхийн соёл.....	51
5.2. Соёлын өвийн бодлого ба Исламын шашин.....	52
ЗУРГААДУГААР БҮЛЭГ: БНХАУ БА НҮҮДЛИЙН СОЁЛ.....	58
6.1. Эрдэм шинжилгээний талбар дахь “нүүдлийн соёл” ба “тал нутгийн соёл”.....	58
6.2. Хятад засгийн газар ба тал нутгийн наадмууд.....	65
ДҮГНЭЛТ: ТӨР БА НҮҮДЛИЙН СОЁЛ.....	72
НОМ ЗҮЙ.....	74
ХАВСРАЛТ.....	81

## УДИРТГАЛ

### Судалгааны үндэслэл


Аливаа ард түмний соёл нь тэдний эртнээс нааш амьдарч ирсэн газар орны газарзүйн байршил, уур амьсгал, экологи, хүрээлэн буй орчинтой салшгүй холбоотой тул аль нэг ард түмний соёлын тухай ярихад энэ талаар зайлшгүй авч үзэх шаардлагатай.

Төв Азийн өндөрлөгт орших Монголын уул талаар тариа ногоо халиурч байхаасаа илүү малын бэлчээрийн ургамал ургаж байх учиртай хөрс шороо юм санж. Эл хөрс нь хэдэн мянган түмэн жилийн турш бүтэж бүрэлдсэн атлаа асар эмзэг, хэврэг нимгэн бүтэцтэй тул зүй бусаар сэндийлбэл “хийн эзэн” дэлхийгээр нэг цацаж орших аюултай гэнэм. Чухам энэ л утгаар хөрс шороо, хад чулуу үл хөндөхийг цээрлэсэн үй олон “аюух дотог” зохион хэлэлцдэг ажээ. Чингэснээр монголчуудын итгэл бишрэл, зан заншил ардын билиг, аж ахуйн хэвшил нь өөр хооронд нь салган зааглаж болшгүй цул нэгдмэл зүйл болж байдаг. (Дулам 2013: 28)

Дэлхийн өнцөг булан бүрд аж төрөх бүхий л ард түмнүүдийн соёл нь тухай тухайн газар орныхоо онцлогт тааруулан эрхэлж ирсэн аж ахуйд суурилсан байдгийг Монголын жишээн дээр тайлбарласан байна. Үүнээс үзэхэд өөрсдийн соёлын тухай бий болгосон төсөөлөл нь тухайн ард түмний дунд бусад ард түмнээс өөрсдийгөө ялгаж харах тодорхой хэв шинж, үнэлэмжийг бий болгодог ба түүний гол хэрэглэгдэхүүн нь соёл байдаг аж. Энэ утгаараа аливаа ард түмнийг нэр бүхий тодорхой нэг угсаатан, үндэстэн гэж тодорхойлох гол шалгуур нь тэдний соёл болж байгаа юм (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ 2018: 36).

Хүн төрөлхтний түүхэнд улс орнуудын зүгээс өөрсдийн үндэсний соёл иргэншлийн тухай өгүүлэмжийг бий болгох явдал байсаар ирсэн. Монголыг ХХ зууныг хүртэл бүхий л түүхэндээ мал аж ахуй эрхлэгч, “нүүдэлчин” байсаар ирсэн цорын ганц улс гэж үзэж болох бөгөөд төр болон эрх баригчдын зүгээс суурин соёлтой бусад ард түмнээс ялгарах “нүүдэлчин”, “малчин” ижилсэлд суурилсан өөрсдийн гэсэн өвөрмөц соёл иргэншлийн тухай ойлголтыг төлөвшүүлсэн байна (Вумочир 2017: 35). Тэр ч үүднээсээ монголчуудын хувьд хөрш зэргэлдээ бусад ард түмнээс ялгарах гол онцлог нь “нүүдлийн соёл” болон “нүүдэлчин” гэх ижилсэл байсаар иржээ. Гэвч “нүүдэлчин” болон “нүүдлийн соёл” гэх өгүүлэмж нь зөвхөн Монгол улс, монгол угсаатных эсвэл мал аж ахуй эрхлэгч бүхий л ард

түмнийх гэж үзэхийн аль аль нь учир дутагдалтай юм<sup>1</sup>. Тухайлбал дэлхий дээр нүүдлийн мал аж ахуй болон мал аж ахуйн бусад хэлбэрүүдийг монголчуудтай адил өнөө хэр эрхэлж байгаа, эсвэл түүх, соёл, аж ахуйн хувьд түүнээс салшгүй холбоо хамааралтай олон ард түмэн бий. Нийт мал аж ахуй эрхлэгч ард түмний тухайд хамгийн өргөн хүрээндээ Хойд Африк, Баруун Ази, Африкийн Сахар, Төв Ази болон Европ тив зэрэг газар орнуудад тархсан “малчид”-ыг хамруулан авч үзэх боломжтой бол нүүдлийн мал аж ахуй эрхлэгчид нь Хойд Африк, Ойрх Дорнод болон Монголын малчид байна. (Мөнх-Эрдэнэ, Чулуунбат 2017, 63). Тиймээс дэлхий дээр нүүдлийн соёлын уламжлал бүхий олон ард түмэн байгаа бөгөөд Монголын тухайд тэдгээрийн нэгэн төлөөлөл гэж үзэх нь зүйн хэрэг юм.



<sup>1</sup> "Нүүдэлчид, нүүдлийн мал аж ахуйн түүхийг судалсан эрдэмтэн судлаачид материаллаг үйлдвэрлэлийн энэ салбар эдийн засгийн үндэс нь болж байсан 5 үндсэн голомт - нутаг манай дэлхийд бий гэж үздэг юм (4.11). Үүнд:

1. Сүргийн бүтцэд нь хонь, ямаа голлодог, уналга тээврийн мал нь тэмээ болох Умард Африк, Өмнөд Азийн нүүдэлчид; 2. Их төлөв үхэр өсгөдөг Сахарын цөлийн өмнөд хэсгээр нутагладаг Африкийн нуудэлчид; 3. Хонь, үхэр голлон өсгөдөг, уналга тээврийн хэрэгсэл нь адуу, үхэр бүхий Евроазийн нүүдэлчид; 4. Сүргийн дотор сарлаг чухал уурэг гуйцэтгэдэг Төвдийн өндөр уулсын нуудэлчид; 5. Умард Азийн Тундр Тайгын бүсэд цаа буга өсгөж амьдардаг бугат нуудэлчид юм. Төв Азийн, тухайлбал, монголын нүүдэлчид Евразийн нүүдэлчдэд хамрагдана. (Баянжаргал 2009, 15)

Өөрсдийгөө нүүдэлчин гэж нэрлэдэг улс, үндэстнүүд дундаас Монгол Улс нь өнөө хэр нүүдлийн мал аж ахуйн язгуур хэв шинжээ хадгалж үлдсэнээрээ бусад нүүдэлчин ард түмнээс ихээхэн онцлог бөгөөд Монгол болон Төв Азийн нүүдэлчид нь хөрш зэргэлдээх газар тариалан эрхлэгч, суурин соёлтой хятадуудын бичиж үлдээснээр “умардын нүүдэлчид”, “умардын зэрлэгүүд”<sup>2</sup> гэх мэт нэр томъёогоор олонтоо тэмдэглэгдэн үлдсэн байна. Тухайлбал Дотоод Ази<sup>3</sup> буюу зүүн хэсгээс Манжуур, Төв хэсгээрээ Монгол болон Ганьсу, Шаньси, Шэньси мужуудын умард хэсэг, баруун тийш зөвхөн Шинжаан гэлтгүй Алтайн нуруу, Минусын хотгор зэрэг Хятадын умард хязгаартай хил залгаа газар орнуудыг авч үздэг байжээ. Харин Төв Азийн тухайд энэ нэр томъёо нь Зөвлөлт Холбоот улсын үед төлөвшиж тогтсон Казах, Киргиз, Узбек, Туркмен, Тажикаас гадна эртнээс нааш Төв Азитай илүү холбоотой байсаар ирсэн БНХАУ-ын ШУӨЗО-ыг хамруулж авч үздэг байна (Di Cosmo 2002: 14).

Энэ мэтчилэн Дотоод Ази болон Төв Ази гэх нэр томъёонд хамаарагдах газар орнуудын талаар олон өөр тодорхойлолтууд байна. Ямартай ч эдгээр газар орнуудад эртнээс нааш нүүдэлчид эсвэл нүүдлийн соёлтой салшгүй холбоотой ард түмнүүд амьдарч ирсэн байх ба бие биетэйгээ түүхийн явцад улс төр, эдийн засаг, нийгэм соёлын харилцаатай байж ирсний дүнд нийт нүүдэлчин ард түмнүүд дундаас өөр хоорондоо олон шинжээр нийтлэг бүлгүүд болон газар орныг доорх газрын зурагт харуулсан байна.

---

<sup>2</sup>The modern Chinese term, wenming, refers to a condition of higher social development. Its antonyms are yeman (barbarian), cuye (rough), and culu (rude). The word is said to have appeared for the first time in Zhouyi, a historical document written in the dynasty of Zhou (1046–771 BC). The word, consisting of two single characters, wen and ming, respectively meaning writing and bright, was used in the sentence ‘见在田，天下文明’. It literally means ‘seeing a dragon in one’s field of heart (imagination), and his writing would be bright in the lands under heaven’. Here the word wenming refers to an advanced writing style that can express a kind of thought that one only achieves after cultivating one’s imagination. In later historical writings (such as the Hehuangyunbiao (贺黄云表) written in the Former Shu Period AD 907–925), the meaning of wenming has become ever more broad. The sentence ‘the customs of remote people [barbarian] should be tamed by wenming and brutal slaves should be threatened by military strategy’ shows that the word has shifted in meaning to indicate a means of exercising authority over other groups. (Bayar 2014: 440-441)

<sup>3</sup> Owen Lattimore has called the “Inner Asian frontiers of China,” I have adopted “Inner Asia” or “Inner Asian frontier” as a general term for the eastern part of the continental mass of Eurasia. In practice, it includes three geographical areas: in the east, Manchuria; in the center, Mongolia, including parts of Kansu, northern Shensi, and northern Shansi; and in the west, not only today’s Sinkiang but also the Minusinsk Basin and the northern part of the Altai Mountains (Di Cosmo 2002: 13)



Монголчуудын хувьд дэлхийн бусад ард түмнүүд дундаас ялгагдах гол онцлог шинж, “монгол соёл”-ын гол эх үүсвэр нь “нүүдлийн соёл” бөгөөд “нүүдэлчин” гэдгээрээ бахархдаг. Тиймдээ ч дэлхий нийтэд монголчуудыг “нүүдэлчин”, Монгол Улс “нүүдэлчдийн өлгий” (Myadar 2011) гэх дүр зургаар төсөөлдөг. Уламжлалт ойлголтоор улс гүрэн олон улсын тавцанд өөрийгөө гадаад бодлогоороо дамжуулан илэрхийлдэг ба тэрхүү гадаад бодлого нь үндэсний язгуур эрх ашиг буюу үндэсний ашиг сонирхол байдаг. (Баасанхүү нар 2019: 97) байна. Тэгвэл Монгол Улсын "Үндэсний язгуур ашиг сонирхол"-д *Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана*<sup>4</sup> гэж заасан байна. Энд заасан “монгол соёл” нь үндсэндээ “нүүдлийн соёл”-ын талаар өгүүлж байгаа юм. Тэгэхээр нэг ёсондоо нүүдлийн соёл нь Монгол Улсын гадаад бодлогоороо дамжуулж олон улсад өөрийгөө илэрхийлж буй нэгэн хэрэгсэл болж байгаа юм. Өмнө дурдсанчлан Монгол бол нүүдлийн соёлын уламжлал бүхий улсуудын нэгэн төлөөлөл болохоос биш цорын ганц нүүдлийн соёлт улс биш юм. Тиймээс Монголоос бусад нүүдлийн соёлын уламжлалтай улсуудын төр засгийн зүгээс нүүдлийн соёлын талаар ойлгох ойлголт харилцан адилгүй байх боломжтой юм. Тэр дундаа нүүдлийн соёлын уламжлалын хувьд Монголтой маш ойролцоо бусад улсуудын төрөөс нүүдлийн соёлыг хэрхэн томъёолж, төрийн бодлогодоо ямар байдлаар тусгаж, гадаад, дотоод бодлогодоо хэрхэн ашигладаг, түүндээ үндэслэн ямар үйл ажиллагаа хэрэгжүүлдэг талаар судлах нь олон талын ач холбогдолтой сэдэв юм.

<sup>4</sup> "ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ - Legalinfo.mn." <https://legalinfo.mn/mn/detail/18>.

Монгол улс XXI зуунд нүүдэлчин ахуйн язгуур хэв шинжээ хадгалж, өвлөн уламжлагч төдийгүй нийт нүүдлийн соёлт ард түмний нэгэн төлөөлөл болохын хувьд нүүдэлчдийн өв соёлыг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх нь Монгол Улсын төрийн зайлшгүй хийх ёстой ажил юм. Тийм ч учраас Монгол улс энэ чиглэлд тодорхой хүчин чармайлт гаргасаар ирсэн. Тухайлбал, Соёлын Өвийн Тухай Хуулийг анх 2001 онд баталж, 2014 онд шинэчилсэн бөгөөд соёлын өвийн тухай олон улсын хэд хэдэн гэрээ, конвенцод нэгдсэнээс дурдвал Соёлын олон төрөл зүйлийн тухай ЮНЕСКО-ын түгээмэл тунхаглал, Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц, Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенцод заасан нь Монгол улс нүүдэлчдийн өв соёлыг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх эрх зүйн орчныг аль хэдийн бүрдүүлснийг харж болно. Цаашлаад Монгол улсын Засгийн Газар болон олон улсын байгууллагуудын харьяанд салбар салбарын шинжлэх ухааны судалгаа шинжилгээнд тулгуурлаж соёлын өвийг судлах, сэргээн засварлах, баримтжуулах, олон нийтэд сурталчлахад чиглэсэн институтүүдийн үйл ажиллагааны туршлага, түүх ч арвин. Энэ ч үүднээсээ Монгол улсын тухайд энэ талын бодлого боловсруулалт, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэлтийн тухайд туршлагагүй улс биш юм.

Гэвч дээрх туршлагаудын цар хүрээ нь ихэвчлэн Монгол улсын дотоод руу чиглэсэн шинжтэй байгаа бөгөөд 2020 онд УИХ-аас “Алсын Хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан ба үүнд “Нүүдлийн соёл иргэншилт монгол” гэсэн зорилгыг тусгайлан зааж, 2030 он хүртэл нүүдлийн өв соёл, ёс уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, цаашлаад 2041-2050 онд нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох зэрэг зорилтуудыг тус тус дэвшүүлсэн нь нүүдэлчдийн өв соёлыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөж, бусад улсууд руу чиглүүлж байгаагийн илрэл юм. Тиймээс энэ зорилтуудыг биелүүлж, түүний хүрээнд боловсруулах бодлого, авч хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн чанарыг сайжруулахад өөрийн улсын соёлыг олон улсад амжилттай түгээн дэлгэрүүлж, сурталчилж буй улсуудын туршлагыг судлах зайлшгүй шаардлага тулгараад байна.

### **Судлагдсан байдлын тойм**

1990 он хүртэл Төв Азийн бүс нутаг дахь нүүдлийн соёлын тухай гол төлөв ЗХУ-д тэргүүтэй социалист улсуудын судлаачид этнографийн судалгаа хийж байсан бол 1990 оноос хойш барууны судлаачид тус бүс нутгийг судлах ажил идэвхэжсэн байна. (Newton 2001). Энэ нь барууны судлаачдын хувьд судалгаа хийх шинэ орон зай болж байсан бөгөөд (Smith et al., 1998), эдгээрээс дурдвал нүүдэлчдийн:

- түүх-угсаатан (Sela and Levi 2009; Muhlfrid and Sokolovski 2012),
- шашин суртахуун, зан үйл (Ханн 2006; Рэй Роуз 2012; Liv 2011; Khalid 2007; Mc Brien 2006; Фатих 2011; Kehl-Bodrogi 2006; Clarke 2009),



- улс төрийн тогтолцоо, нийгмийн байгуулал (Roy 2000; Kandiyoti 2020; Comings 2010; Adams 2010; Smith et al 1998; Finke 2006; Rasuly Paleczek 2005; Liv 2011; Marceline 2013; Beyer et al 2013; Finke and Sancar 2012; Schatz 2004; Gullette 2010),
- эдийн засаг, аж ахуйн хэвшлийн (Alexander 2004; Trevisani 2010; Khazanov 2013; Nazpary 2001; Shreeves 2002; Rasanayagam 2011; Kandiyoti 2003; Essenova 2006; Specter 2008; Kaiser 2005; Werner 2004; Marsden 2012) талаар илүүтэй судалсан байна.

Эдгээрээс үзэхэд төрөөс нүүдлийн соёлын талаар баримталж буй бодлого, үйл ажиллагааны тухай судалгаа маш цөөхөн байна.

Бүс нутгийн хэмжээнд нүүдэлчдийн асуудлыг цогцоор авч үзсэн бүтээл нь 1991-1995 оны хооронд Кембрижийн их сургууль (Кэролайн Хамфри, Дэвид Снийт)-аас хэрэгжүүлсэн “Өвөр Азийн хүрээлэн буй орчин, соёл, уламжлалын сахин хамгаалал” сэдэвт судалгааны төсөл байна. Тус судалгаагаар Монгол улс, БНХАУ-ын Өвөр Монгол, Шинжаан-Уйгур болон ОХУ-ын Буриад, Тува зэрэг газруудад нүүдэлчдийн асуудлыг судалсан нь бүс нутгийн хэмжээнд харьцуулан судалсан цөөхөн ажлын нэг болжээ.

Турк дэх мал аж ахуйн талаар Даффи “Нүүдэлчдийн нутаг” номдоо Францын Засгийн газраас Газар дундын тэнгис хавийн, тухайлбал Алжир, Анатолий дахь нүүдлийн мал аж ахуйн бэлчээр нутгуудыг ойн аж ахуй болгон “хөгжүүлэх” оролдлогын талаар бичиж, нүүдлийн болон суурин аж ахуй хоорондын зөрчил улс төртэй хэрхэн холбогдог талаар тайлбарласан байна (Duffy 2019). Харин өнөөгийн Турк улсын Засгийн газраас гадаад харилцаа, дипломат ажиллагаандаа поп болон элитийн соёлыг ашиглаж, бусад улсуудтай харилцаагаа бэхжүүлэх, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх замаар ашиг сонирхлоо гадаадад сурталчилж буй талаар Доннэли онцлон өгүүлсэн байна (Donelli 2019).

Харин Зөөлөн хүч, Соёлын давамгайллын тухай хийгдсэн судалгаанууд нь гол төлөв АНУ, ИБУИНВУ, ЕХ, БНСУ, Япон зэрэг зөөлөн хүчний индекс өндөр улсуудын жишээг улс төр, геополитикийн үүднээс судалсан жишээ олон байгаагаас БНХАУ, ОХУ-ыг оролцуулж, харьцуулсан хэд хэдэн судалгаа байна (Hurrell 2006; Lee 2002; Meyer 1996, 2007; Nye 2004; Pamment 2013; Puppin 2017; Robotham 2017; Seong-Hun 2018; Sidiropoulos 2014; Surowiec 2017; Tsygankov 2013; Wolff, 2015; Viswanathan 2019; Yilmaz 2013; Zamorano 2016)

### **Судалгааны зорилго**

Тус судалгааны ажлын үндсэн зорилго бол Дотоод Азийн нүүдлийн соёлын уламжлал бүхий улс орнууд, тухайлбал Монгол, Бүгд Найрамдах Казахстан Улс, Киргизийн Бүгд Найрамдах Улс, Бүгд Найрамдах Турк Улс, мөн хүн амынх нь тодорхой хэсгийг нүүдэлчид бүрдүүлдэг Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрөөс нүүдлийн соёлыг хэрхэн харж, ойлгож, томъёолж, төрийн бодлогодоо хэрхэн тусгаж,

үндэсний ижилслээ бүтээх, хадгалан хамгаалах, сурталчилж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн ямар үйл ажиллагаа явуулдаг талаар харьцуулан судлах юм.

### **Судалгааны ач холбогдол: онолын болон практик**

Уг судалгаа нь Монгол улсын зүгээс нүүдлийн соёлыг судлах цар хүрээг бүс нутагт өргөжүүлж, нүүдлийн соёлын уламжлал бүхий Төв Азийн бүс нутаг руу чиглэж судалж буйгаараа нүүдлийн соёлыг ихэвчлэн Монгол улсын хэмжээнд, эсвэл хилийн гаднах монгол угсаатнуудын хүрээгээр хязгаарлалгүй илүү өргөн хүрээнд авч үзэж байгаагаараа онцлогтой юм. Цаашлаад нүүдлийн соёлыг ямар нэгэн байдлаар дээрх бүс нутгийн аль нэг улс, үндэстэн өмчлөх (Цэцэнцолмон 2012) хандлагад шүүмжлэлтэй хандаж байгаа юм. Мөн нүүдэлчдийг “зэрлэг”, “бүдүүлэг”, “мунхаг” эсвэл “тэнүүлчин” мэтээр тайлбарладаг нийгмийн хувьслын үзэлд шүүмжлэлтэй хандаж, харин түүний эсрэгээр нүүдэлчид өөрсдийн соёлоо хэрхэн харж, ойлгож, үнэлдэг мэдлэг дээр тулгуурласан үзэл хандлагыг судлахыг зорьж буйгаараа онцлог болно. Цаашлаад Монгол Улсын зүгээс нүүдлийн соёлыг олон улсад сурталчлахад чиглэсэн төрийн бодлого, арга туршлагыг Бүгд Найрамдах Казахстан улс, Киргизийн Бүгд Найрамдах Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс зэрэг нүүдлийн соёлын уламжлал бүхий бусад улсуудын арга туршлагатай харьцуулж, давуу болон сул талд үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой юм.

### **Судалгааны асуудал ба нэр томьёо**

Тус судалгааны ажлаар дараах асуултуудад хариулахыг оролдлоо.

1. “Нүүдлийн соёл”, “нүүдлийн соёл иргэншил” хэмээх нэр томьёо, ойлголтын талаар;
2. Нүүдлийн соёлын уламжлалтай улсуудын төрөөс нүүдлийн соёлыг хэрхэн ойлгож, томъёолдог. Түүнд үзүүлэх гадаад, дотоод улс төр, нийгэм соёлын нөлөө;
3. Түүнд чиглэсэн ямар бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлж ирсэн;
4. Монгол Улсын Засгийн газраас нүүдлийн өв соёлыг түгээн дэлгэрүүлэх чиглэлд баримталж ирсэн бодлого, авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд;
5. Нүүдлийн соёлын уламжлалтай Бүгд Найрамдах Казахстан улс, Киргизийн Бүгд Найрамдах Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас нүүдлийн өв соёлыг түгээн дэлгэрүүлэх чиглэлд баримталж ирсэн бодлого, авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд;
6. Тэдгээрийг хооронд нь харьцуулсан дүн шинжилгээнд тулгуурлан давуу болон сул талд үнэлэлт дүгнэлт өгөх.

### **Судалгааны онолын өнцөг**

-Нүүдлийн соёлыг үзэх колоничлолын үеийн үзэл, хандлага

Юуны түрүүнд суурин болон нүүдлийн соёлын ялгаатай байдал, малчин, тариачин ард түмэн бие биеэ хэрхэн харж, үнэлж ирсэн талаар авч үзье. Суурьшмал соёл иргэншилт улс орны түүхчдийн бүтээлд нүүдлийн мал аж ахуйг “зэрлэг бүдүүлэг” гэх тул умардын нүүдэлчдийг “зэрлэгүүд” хэмээн нэрлэж заншсан нь хойт хойтын олон зуунд ч өөрчлөгдөлгүй уламжлан иржээ (Дулам 2013: 25). Суурин болон нүүдлийн соёлууд хоорондын үл ойлголцол зөрчилдөөн эдгээр аж ахуйн хэвшлүүд үүсэж, өөр хоорондоо харилцаж эхэлсэн цагаас эхлэн бий болжээ.

Тариачин хүний бодлоор хүн байна гэдэг бол бийр янтаа нийлүүлэн шүлэг бичих, газар боловсруулах явдал бөгөөд өөр юу ч хийдэг хүнийг зэрлэг гэж үзнэ. Энэ нь махбодын тухай тэдний уламжлалт үзэл баримтлалаас ч харагддаг. Хятадын соёлд хүчтэй, өндөр биетэй хүнийг таалж үздэггүй...Уламжлалт Күнзийн ёсны соёлд биеийн хөдөлмөрийг дорд үздэг байв. Хойд нутгийн бэлчээрийн мал аж ахуйтай нүүдэлчдийн захирагчидтай энэ хандлагаасаа болж зөрчилддөг байжээ. (Булаг 2016: 174)

Зөвхөн монгол, хятадын жишээн дээр л гэхэд эртнээс нааш хөрш зэргэлдээ аж төрж ирсэн тул тус тусын нүүдлийн болон суурин соёлын онцлогт тулгуурлан бие биеэ харж, үнэлэх шалгуур, хэмжүүр нь бусад олон шалтгаануудтай холбоотойгоор хоорондоо зөрчилдсөн байдлаар төлөвшиж ирсэн байна. Тухайлбал хятадууд монголчуудыг мал амьтантай харьцдаг, бичиг үсэггүй, хот суурингүй гэх мэт өөрсдийн суурьшмал соёлын үнэт зүйлийг шалгуур болгон “зэрлэг”, “бүдүүлэг” гэж үздэг талаар дээр дурдсан. Харин нүүдлийн соёлын үнэлэмж, хэм хэмжүүрээр харвал хятадууд нь нүүдэллэх боломжгүй, нэг газраа бөөнөөрөө шавж амьдардаг, мал амьтны иддэг өвс, ногоо иддэг, эрэмгий дайчин чанаргүй гэх мэтээр мөн л монголчуудаас дор байдлаар ойлгогдох юм. Төрт улсууд өөр хоорондоо харилцаж эхэлсэн эрт цагаас эхлэн улс хоорондын харилцаанд соёл иргэншлийн нөлөө хүчтэй байсаар ирсэн билээ. Олон улсын харилцаан дахь хамгийн чухал асуудал болох дайн ба энхийн асуудал, бүрэн эрхт улс хоорондын харилцаа, түншлэл, эвсэл, дайсагнал, худалдаа зэрэгт их бага хэмжээгээр ямагт соёл иргэншлийн нөлөө байсаар ирсэн (Баасанхүү нар 2019: 62). Энэ мэт соёлын ялгаатай байдал нь цаашлаад улс хоорондын зөрчилд ч мөн тодорхой хэмжээнд нөлөөлдөг ба бие биеэсээ ялгаатай аж ахуйн хэвшил бүхий хөрш ард түмнүүд бие биеийнхээ соёлын талаар таагүй төсөөлөлтэй байдгийг харуулж байна.

Нүүдэлчин байх нь “зэрлэг” “бүдүүлэг”-т тооцогдох энэ үзэл нүүдлийн соёл болон суурин соёлын ялгаанаас гадна улс төрийн агуулга бүхий ориентализм<sup>5</sup>-ын жишээ болж,

---

<sup>5</sup> XVII зууны сүүл үест загалмайтны шашинт Европт заналхийлж байсан Оттоманы эзэнт гүрний байдал Исламын шашинтнуудыг сөргөөр харах түүхэн нөхцөл болсон билээ. Энэ бүхний үр дүнд Исламын шашинтнуудыг алан хядагчид, эвдэн бусниулагчид, ад чөтгөрийн, буруу номын зэрлэг

Европын эзэнт гүрнүүдийн “дорныхон”-ыг харах колоничлолын үзэл санаанд ч мөн тусгалаа олсон байдаг. Европчууд дэлхийн бусад улсаас эдийн засгийн хөгжлөөр нэг шат түрүүнд явж ирсэн байдал нь эргээд Өрнөдийн соёл иргэншилтэй бусад соёл иргэншлийг харьцуулах, түүнээс дорд тавих шалтгаан болсон гэж үзэж болно (Баасанхүү нар 2019: 63). Энэ мэтээр Европчуудын өөрсдийн соёлын үнэлэмж, хэм хэмжүүрээр бусад соёлуудыг шүүн тунгааж байсан үзэл нь цаашдаа шинжлэх ухаанд нэвтэрч, нүүдлийн соёлыг илүү “боловсронгүй” бөгөөд шинжлэх ухааны үүднээс зэрлэг, бүдүүлэг гэж томъёолох болжээ<sup>6</sup>. Тухайлбал Английн антропологич Эдвард Тайлор хүн төрөлхтний соёлыг хүй нэгдлийн үеэс өнөө үе хүртэл хөгжиж байгаа бөгөөд “хүй нэгдэл, зэрлэг үе, мал аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр” гэхчлэн хөгжиж байгаа (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ 2018: 20) гэж тодорхойлсноор бол тухайн үедээ аж үйлдвэр хөгжсөн байсан Европын ард түмний соёлоос нүүдлийн соёл нь 2 үе шатаар доор ангилагдаж байна. Харин Америкийн антропологич Левис Хенри Морган Эртний нийгэм бүтээлдээ хүний нийгмийг зэрлэг (savage), бүдүүлэг (barbarian), иргэншсэн (civilized) гэж ангилж<sup>7</sup>, тухай бүрд нь тодорхой шалгууруудыг тавьсны дагуу бол нүүдэлчид мөн л “зэрлэг” эсвэл “бүдүүлэг” болж байгаа юм.

Эдгээрт тулгуурлан эртнээс нааш нүүдлийн соёл нь өөрийн онцлог болон мал аж ахуйн өвөрмөц шинж чанараараа суурин иргэншилт ард түмний сэтгэлгээнд зэрлэг бүдүүлэг гэж үзэгдсээр ирсэн гэж үзэх боломжтой юм. Европын улсууд дэлхийн бусад бүс нутгууд дахь улс үндэстнүүдийг эзлэн түрэмгийлж байсан колоничлолын үе, мөн аж үйлдвэржилт зэрэгтэй холбоотойгоор өөрсдийнхөө нийгэм соёлын үнэлэмжээр хэмжүүр тогтоож, түүндээ үндэслэн бусад ард түмнийг доод, өөрсдийгөө дээд гэж үзэх хандлагыг төлөвшүүлж байсан. Тэдгээр онол, хандлагын үзэл санаагаар нүүдэлчид, нүүдлийн соёл нь мөн л зэрлэг бүдүүлэг, “иргэншээгүй”, “эртний”, “хоцрогдмол” гэх мэтээр үзэгддэг байжээ.

---

бүдүүлэгүүд гэж үзэх үндэс болжээ. Энэ нь улсаар даамжирж зөвхөн Исламын шашинтнууд төдийгүй дорныхон зэрлэг бүдүүлэг гэсэн ухагдахуун болон хөгжсөн байдаг. Учир нь дорныхон бүгдээрээ адилхан гэдэг Кромерийн учир зүйн сэтгэлгээгээр бол дорныхон Исламынхан зэрлэг бол дорныхон бүгдээрээ зэрлэг болж таарна (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ 2018, 190).

<sup>6</sup> XIX зууны дунд үеэс эхлэн үеийн антропологийн онолын хандлага нь Ч.Дарвины хувьслын онолоос санаа авсан европ төвт нийгмийн хувьслын онол (social evolutionism) байсан юм. Өөрөөр хэлбэл антропологи нь хүний нийгэм, соёлыг байгалийн ухааны арга маягаар судлах гэсэн бусад нийгмийн ухаантай адилхан хандлагатай байжээ (Мөнх-Эрдэнэ, Чулуунбат 2017, 17). Нэг ёсондоо Ч.Дарвины биологийн олон төрөл зүйл нь байгалийн шалгарал, дасан зохицох чадварын үр дүнд хувьсан хөгждөг талаар тайлбарласан байгалийн ухааны загвараар хүний нийгэм, соёлыг тайлбарлаж байсан бөгөөд (Barnard 2020, 48-50), (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ 2018, 4-5) гол төлөөлөгчид нь Эдвард Тайлор, Эмиль Дуркхэйм болон Левис Хенри Морган нар ажээ.

<sup>7</sup> 1. Зэрлэгийн доод үе: хамгийн эртний хүнээс эхлээд гал олж, загас агнах болсон үе хүртэлх

2. Зэрлэгийн дунд үе: гал олж, загас агнах болсон үеэс нум сум бий болсон үе

3. Зэрлэгийн дээд үе: нум сум бий болсон үеэс шавар ваар, сав суулга бий болсон үе

Ингээд ваар бий болсон үеийг зэрлэг болон бүдүүлэг үе хоёрын зааг гэжээ.

1. Бүдүүлэгийн доод үе: ваар хийж эхэлсэн үеэс эхлээд мал гаршуулж тариалан эрхэлж эхэлсэн үе

2. Бүдүүлэгийн дунд үе: мал аж ахуй, газар тариалангаас төмрийн үе

3. Бүдүүлэгийн дээд үе: төмрийн үеэс цагаан толгой, бичиг үсэг бий болсон үе (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ 2018, 28)

-Нүүдлийн соёлыг үзэх орчин үеийн судалгааны онол, сэтгэлгээ

Өмнөх хэсэгт дурдсанчлан нийгэм, хүмүүнлэгийн ухаанууд, ялангуяа антропологид нүүдлийн соёл нь евроцентрист, колонишлолын үзэл санаагаар анх нэвтэрч байсан бол антропологийн шинжлэх ухаан хөгжихийн хэрээр дараа дараагийн онолч, судлаачдын үзэл санаагаар ямартай ч эрдэм шинжилгээний хүрээнд “зэрлэг”, “бүдүүлэг”, “хоцрогдмол” гэх ойлголтуудаас хөндийрч эхэлжээ. Нийгэм/соёлын хувьслын онолчдын байгалийн шинжлэх ухааны загвараар нийгэм, соёлыг тайлбарласан онолуудыг шүүмжилж, аливаа нийгэм соёлыг хөндлөнгийн өнцгөөс бус холбогдох тухайн ард түмний өөрсдийнх нь ойлголт, үнэлэмжээр харах хандлага хүч түрэн гарч ирсэн байна. Тухайлбал, Америкийн антропологич Франц Боас соёлыг хувьслын онолчид шиг хүн төрөлхтнийг нэг соёлтой гэж үзэлгүй олон соёлтой, соёл бүр адил бус гэх өнцгөөс харж, өөр өөрийн хүрээлэн буй орчиндоо утга төгөлдөр болдог гэж үзсэн.

Соёл бол аль нэгэн бүлэг хүмүүсийн түүхэнд өвөрмөц бүтээл гэдэг түүний санаа цаашлаад онол арга зүйн өөр нэгэн чиг баримжааг дархалж өгсөн соёлын харьцангуй (Cultural relativism) байдлын тухай юм. Соёл гэдэг нэгэнтээ өвөрмөц буюу энд тэнд өөр байдаг гэж үзвэл түүнийг харьцуулж, жишин хэмжиж хөгжлийн дээр доор шатанд байгаа мэтээр дүгнэж цэгнэж болохгүй зүйл гэсэн санаа байдаг. (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ 2018: 34-36)

Энэ нь нэг ёсондоо нүүдлийн соёлын жинхэнэ утга агуулгыг нүүдэлчдийн өөрсдийнх нь үнэлэмж, хэм хэмжүүрээр тодорхойлох нь зүйтэй гэсэн санаа болж байгаа юм. Мөн Английн антропологич Бронислав Малиновски соёлын үүрэг, үйл ажиллагааны<sup>8</sup> талаар тайлбарлахдаа домын жишээг авсан нь аливаа соёл нь тухайн ард түмний өмнө гүйцэтгэх үүрэгтэй гэж үзсэн байна.

Дом гэдэг бол зүгээр нэг мухар сүсгийн төдий зүйл биш харин соёлын үүрэг, үйл ажиллагааны нэг жишээ юм. Дом гэдэг бол дайснаа дарах, өөрийгөө хамгаалах, ургац арвин байлгах, хүүхэд эндэхгүй төрөх гэхчилэнгийн маш олон төрлийн үр дүнтэй соёлын үүрэг үйл ажиллагаа юм. Байгаль цаг агаар, тэнгэр одон эрхэс, халуун хүйтэн зэрэг нь хүний гараар

---

<sup>8</sup> Үүрэг, үйл ажиллагаа гэдэг нь хүний зан авирын хамгийн энгийн бөгөөд өгүүлэмж багатай зүйл болж таарах ажээ. Нэн тэргүүнээ түүний хувьд үүрэг, үйл ажиллагаа гэдэг нь хүний зан авирын хамгийн энгийн бүрэлдүүлэгч хэсэг бөгөөд энэ нь органик хэрэгцээг хамгийн тохиромжтой үйлдлээр хангаж байгааг хэлнэ гэжээ. Соёл гэдэг бол түүний тодорхойлолсноор олон зүйлийн нийлбэрээс бүрдсэн цогцолбор зүйл бөгөөд энэ цогцолборын олон эд эс хоорондын холбоог антропологич судалдаг байна. Харин тэд хоорондоо үүрэг, үйл ажиллагаагаар холбогддог байна. (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ 2018, 92)

хувирган өөрчилж болохгүй зүйлс бөгөөд харин эртний хүнийхээр бол домоор жолоодож болох зүйлс байдаг. Үүнийг Малиновски эртний хүмүүс өвчин эмгэг анагаах шинжлэх ухааны мэдлэг дутмаг байснаас үүдэн дом бий болсон гээд “өвчтэй хүн зөвхөн эдгэрэхийг л хүсэх бөгөөд ямар нэгэн ид шид ч хамаагүй тохиолдохыг хүсэх нь аажимдаа домд итгэх байдлыг бий болгосон” /Malinowski 1945: 198-199/ (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ 2018: 94)

Энэ жишээ нь нүүдлийн соёлыг суурин болон бусад соёлын үүднээс “зэрлэг”, “бүдүүлэг” гэж үзэхэд нөлөөлж буй тодорхой элемент бүр нь нүүдэлчдийн өөрсдийн үзэл, сэтгэлгээгээр тайлбарлагдах утга агуулга бүхий тодорхой үүрэгтэй байдгийг харуулна.

Нүүдлийн соёлыг өмнө нь ихэвчлэн түүх-угсаатан, улс төр, аж ахуй, эдийн засаг, шашин шүтлэг зэрэг салбар ухаанууд судалж байгаа бол сүүлийн үед гол төлөв даяаршлын эрин үед нүүдэлчин хэвээр байгаа ард түмнүүд рүү чиглэсэн судалгаанууд ихээр хийгдэх болсонтой холбоотойгоор олон нийтийн зүгээс ч тэр нүүдэлчдийг харж, хүлээж авах хандлага ч мөн өөрчлөгдөж байгаа гэж үзэж болох юм. Сүүлийн жилүүдэд ялангуяа Монгол болон Дотоод Азийн нүүдэлчдийн талаар судалж буй судалгаанууд, ялангуяа Монгол судлаачид өмнө дурдсан евроцентрист үзлийг шүүмжилж, ХХ зууны 2-р хагасаас түүнийг сэргүүлэн “соёл иргэншил” гэсэн нэр томъёог нүүдлийн соёлтой холбон тайлбарлах болсон (Bumochir, Chih-Yu 2014) бөгөөд түүний нэгэн илрэл нь “нүүдлийн соёл иргэншил” гэх нэр томъёо байна.

Аж ахуйн хэвшлийн хувьдаа нэг нь газартай, нөгөө нь мал амьтантай харьцдагаараа ялгарахаас бус энэ хоёрыг дээр, доор гэх, “зэрлэг” юм уу, “соёлтой” хэмээн сэргөцүүлэн хэлэлцэх нь утга учиргүй гэдгийг зөвхөн орчин үеийн шинжлэх ухаан л ойлгуулж өгчээ...Нүүдлийн мал аж ахуйг үүсгэн хөгжүүлж, түүнтэй холбоотой соёл суртлыг бүтээсэн явдал нь монгол нүүдлийн соёл иргэншлийн зангилаа асуудал юм. Нүүдлийн мал аж ахуйн соёлтойгоо уялдан гарсан гэр сууц, хувцас өмсгөл, гоёл чимэглэл, идээ ундааны соёл, шүтлэг бишрэл, дуу хуур, урлагийн бусад зүйл цөм нэгдэн цогцолжээ. (Дулам 2013: 25-40)

Үүнээс гадна Социализмын үед буюу 1970-аад оны эхнээс “нүүдлийн соёл иргэншил”-ын талаар ойлголтыг хэрхэн бий болгож, хэлбэржүүлсэн талаар (Tsetsentsolmon 2014) өгүүлснээс үзэхэд тухайн үеийн төр засаг болон ЮНЕСКО-ын зүгээс ч мөн дэмжиж байжээ.

Эдгээрээс үзэхэд орчин үед нүүдлийн соёлыг харж, хүлээж авч, ойлгох хандлага нь шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний хүрээнд зэрлэг бүдүүлэг, хоцрогдмол гэхээсээ

илүүтэй соёлын олон талт байдлын нэгэн төлөөлөл, даяаршиж буй дэлхий ертөнцөд өөрийн өвөрмөц хэв шинжээ хадгалсаар байгаа ахуйн хэвшлийн нэг хэлбэр болох байдлаар үнэлэгдэж байна.

### **Судалгааны арга зүй**

Тус судалгаа нь сонгож авсан улсуудын засгийн газраас нүүдлийн өв соёлыг хэрхэн ойлгож, түүнд хэдий хэмжээний ач холбогдол өгч, түүнийг сурталчилж түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн ямар үйл ажиллагаа хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг судлах тул судалгааны үндсэн материал нь баримт бичиг, тайлан мэдээнүүд байна. Тиймээс судалгааг гүйцэтгэх үндсэн арга зүй нь тус улсуудын засгийн газруудаас гаргасан хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүд, олон улсын байгууллага, төрийн байгууллагуудын тайлан мэдээ, мөн тэдгээртэй холбоотой шинжлэх ухааны бүтээлүүдийг цуглуулж анализ хийх буюу баримт бичгийн дүн шинжилгээ байна. Эдгээр материалуудыг гол төлөв интернэт эх сурвалжаас монгол, англи, орос, турк, хятад хэлээр баримт мэдээ цуглуулж дүн шинжилгээ хийсэн.

### **Судалгааны бүтэц**

Тус судалгаа нь удиртгал, 6 бүлэг, дүгнэлт, хавсралт, ном зүй гэсэн хэсгээс бүтнэ. Нэгдүгээр бүлэгт Монгол Улсын Засгийн газраас нүүдлийн соёлын тухайд авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг тоймлон авч үзсэн. Хоёрдугаар бүлэгт Казахстан дахь нүүдлийн мал аж ахуй эрхлэлтийн түүх, нүүдлийн соёлын тухай ойлголтоос гадна өдгөө үндэстэн байгуулах, үндэсний ижилслийг бэхжүүлэхдээ нүүдлийн соёлыг хэрхэн ашиглаж байгаа талаар Засгийн газрын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд нь хэрхэн туссан байгааг задлан шинжилсэн болно. Гуравдугаар бүлэгтээ Киргизстан улс дахь бэлчээрийн мал аж ахуй эрхлэлтийн өнөөгийн байдал, түүнтэй холбоотойгоор нүүдлийн соёл тус улсад ямар байдлаар ойлгогддог талаар, мөн тухайн улсын төрөөс нүүдлийн соёлын тухайд баримтлах бодлогыг Исламын шашны уламжлал болон угсаатнууд хоорондын харилцаатай холбож тайлбарлав. Дөрөвдүгээрт бүлэгт ОХУ-ын хязгаар нутгууд дахь орос бус угсаатнууд, тэр дундаа уугуул иргэдийг үе үеийн засаглалууд хэрхэн тодорхойлж ирсэн талаар, мөн уугуул иргэдийн аж ахуйг хамгаалах чиглэлд ямар үйл ажиллагаа хэрэгжүүлдэг талаар судаллаа. Тавдугаар бүлэгт өнөөгийн БНТУ дахь нүүдэлчин иргэдийн улс төр, нийгэм, эдийн засгийн ямар нөхцөлд аж төрдөг, ямар байр суурь эзэлдэг талаар болон тус улс дахь соёлын өвийн тухай хууль эрх зүй, бодлогын зохицуулалтад анализ хийсэн. Зургаадугаар бүлэгт БНХАУ-ын Засгийн газраас нүүдэлчдийн соёлыг дотоод, гадаад олон нийтэд ямар үзэл баримтлалаар сурталчилж буй, мөн түүндээ үндэслэн ямар үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа талаар наадмын жишээн дээр тайлбарлав.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: МОНГОЛ УЛС БА НҮҮДЛИЙН СОЁЛ

### 1.1. Монгол Улсын төрөөс нүүдлийн соёлыг хадгалж хамгаалах, сурталчлах, дэлгэрүүлэх чиглэлд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа

Монгол Улс тусгаар тогтносон улс болохынхоо хувьд Орос, Хятад гэсэн хүчирхэг хөрш улсууд болон Төв Азийн улсуудын дэргэд өөрсдийн гэсэн өвөрмөц иргэншлийг бий болгох шаардлагатай байсан тул иргэншил болон соёлынхоо аль алийг нь “нүүдлийн” гэсэн нэр томъёогоор тодорхойлсон (Bumochir, Chih-Yu 2014: 418). Тухайлбал Монгол Улсын Үндсэн хууль<sup>9</sup>-д “төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж” хэмээн заасны “соёлын уламжлал” гэсэн нь монголчуудын уламжлалт нүүдлийн соёлын талаар өгүүлж байгаа хэрэг юм. Цаашлаад зөвхөн Үндсэн Хууль төдийгүй Соёлын тухай хуулиас гадна бусад<sup>10</sup> олон салбарын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүд дэх “монголын соёл”, “уламжлалт соёл” болон “үндэсний соёл” гэсэн бүхий л заалтууд нь мөн л “нүүдлийн соёл” гэсэн агуулгатай гэж үзэх боломжтой юм. Бүрэн эрхт улсын хувьд оршин тогтнохтой учир холбогдолтой зорилгыг үндсэн зорилго, бусдыг нь үндсэн бус зорилго гэнэ. Үндсэн зорилго амжилтгүй хэрэгжвэл тухайн улс аюултай байдалд орно. Ихэнх улсын хувьд урт хугацааны болон хэтийн сонирхол үндсэн зорилгод тусдаг. Тиймээс үүнийг гадаад бодлогын номлол болон аюулгүй байдлын үзэл баримтлал болгон мөрддөг (Баасанхүү нар 2019: 85). Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал-д “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн”<sup>11</sup> хэмээн заасан нь Монгол Улсын төрөөс нүүдлийн соёлыг онцгойлон чухалчилж үзэж байгаагийн томоохон илрэл болох бөгөөд нэг ёсондоо нүүдлийн соёлгүйгээр монгол үндэстэн оршин тогтнохгүй гэсэн утгыг илэрхийлж байна. 2020 онд Соёлын Яамыг шинээр байгуулагдсан явдлыг миний уулзсан тус Яамны төлөөлөгч “Том дүр зургаар харвал Үндэсний аюулгүй байдлыг соёл талаас нь хангаж, сайжруулах боломж бүрдсэн” явдал хэмээн тодорхойлсон юм. Үүнтэй холбоотойгоор Монгол улсын Соёлын тухай хууль тэргүүтэй эрх зүйн болон Улсын Их Хурал, Засгийн Газраас гаргасан хөгжлийн баримт бичгүүдэд “нүүдлийн соёл”, “нүүдлийн соёл иргэншил” гэх мэт нэрээр томъёологдсон хэд хэдэн зүйл заалтууд нэмэгдсэн байгаа нь нүүдлийн илүүтэй ач холбогдол өгч эхэлсний илрэл гэж үзэх боломжтой юм. Тухайлбал анх 1996 онд баталж, 2002 онд шинэчлэн найруулсан Соёлын тухай хуульд “нүүдлийн соёл” эсвэл “нүүдлийн соёл иргэншил” гэсэн нэр томъёонуудыг хэрэглээгүй байсан бол 2021 оны 07-р

<sup>9</sup> "МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ - Legalinfo.mn." <https://legalinfo.mn/mn/detail/367>

<sup>10</sup> "...10.3.Бүх шатны боловсролын хөтөлбөрт монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний төлөвшил, хөгжил, гэр бүл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл, суралцагчийн гүйцэтгэх сайн дурын үйл ажиллагааны төрөл, агуулгыг заавал тусгаж, музей, номын сан, кино зэрэг соёл, урлаг, спортын байгууллагын боломжийг ашиглахаар зохион байгуулна..." БОЛОВСРОЛЫН ТУХАЙ - Legalinfo.mn." <https://legalinfo.mn/mn/detail/9020>.

<sup>11</sup> "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал ...."

<https://legalinfo.mn/mn/detail/6163>.



сарын 02-нд баталсан Үндсэн Хуулийн шинэчилсэн найруулгад шууд хэрэглэхээр болж, 2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлжээ.

## МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬ<sup>12</sup>

/2021 оны шинэчилсэн найруулга/

8 дугаар зүйл. Төрөөс тусгайлан дэмжлэг үзүүлэх соёлын үйл ажиллагааны чиглэл

8.1. Байгаль орчин, уламжлалт ахуйтайгаа харилцан шүтэлцсэн нүүдлийн соёл иргэншлийн онцлогийг хадгалсан орон зай, газар нутгийг тогтоох, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

8.2. Нүүдлийн соёл иргэншлийн дурсгалт газарт уламжлалт ахуйг хамгаалах тааламжтай нөхцөлийг бүрдүүлж, хуульд зааснаас бусад дэглэмийг тогтоох, уламжлалт ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.

Дээрх заалтуудын утга агуулга нь үндсэндээ ард иргэдийг нүүдлийн мал аж ахуй эрхлэх таатай нөхцөл боломжоор хангах замаар нүүдлийн соёлыг хадгалж хамгаалахад соёлын салбарын зүгээс дэмжлэг үзүүлнэ гэсэн байна. Аливаа хууль эрх зүйгээр зохицуулагдсан төрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл явц нь Урт хугацааны хөгжлийн бодлого стратеги, Улсын Их Хурлаас гаргасан тогтоол, Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэгч яамны стратеги, хэрэгжүүлэгч агентлагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө гэсэн шат дараатай хэрэгждэг байна (Ч.Цэцэгбаатар 2022, Ярилцлага). Тэгэхээр одоогийн байдлаар “Алсын Хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын Их Хурлын Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Соёлын Яамны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, Соёлын яамны харьяа байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг үе шаттай аливаа бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Тиймээс эдгээр баримт бичгүүдэд нүүдлийн соёлын тухай хэрхэн туссаныг авч үзье.

“Алсын Хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг<sup>13</sup>

<sup>12</sup> "СОЁЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ - Legalinfo.mn."

<https://legalinfo.mn/mn/detail/16230709374521>.

<sup>13</sup> "АЛСЫН ХАРАА 2050 МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ...."  
<http://nda.gov.mn/backend/files/%D0%90%D0%9B%D0%A1%D0%AB%D0%9D%20%D0%A5%D0%90%D0%A0%D0%90%D0%90%202050%20%D0%9C%D0%9E%D0%9D%D0%93%D0%9E%D0%9B%20%D0%A3%D0%9B%D0%A1%D0%AB%D0%9D%20%D0%A3%D0%A0%D0%A2%20%D0%A5%D0%A3%D0%93%D0%90%D0%A6%D0%90%D0%90%D0%9D%D0%AB%20%D0%A5%D3%A8%D0%93%D0%96%D0%9B%D0%98%D0%99%D0%9D%20%D0%91%D0%9E%D0%94%D0%9B%D0%9E%D0%93%D0%9E.pdf>.

## Зорилт 1: Үндэсний нэгдмэл үнэт зүйл

- *Зорилт 1.2: /Нүүдлийн соёл иргэншилт монгол/ Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно.*

I үе шат (2020-2030): Өв соёлоо дээдлэгч соёлын дархлаа бүхий монгол хүн  
“Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх үе”

II үе шат (2031-2040): Үндэсний ижилсэл бүхий Азийн Монгол  
“Монголчуудын үндэсний ижилсэл бэхжиж, нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох үе”

III үе шат (2041-2050): Нэгдмэл үнэт зүйлсийг бүтээгч нүүдлийн соёл иргэншилт дэлхийн монгол

“Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох үе”

Эдгээр үе шатуудыг биелүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаанууд нь үндсэндээ Монгол Улсын дотоодод нүүдлийн соёлд суурилсан үндэсний ижилсэлд тулгуурлан ард түмний оюун санааны хувьд нэгтгэхэд чиглэсэн байхаас гадна нүүдлийн соёлыг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх тухай агуулгатай байна.

- Нүүдлийн соёлд суурилсан үндэсний ижилсэл: 1.2.6. *Үндэсний ижилсэл, соёлын дархлаатай монгол хүнийг бэлтгэхэд чиглэсэн өв соёлын өргөө, соёлын төвүүд, үндэсний спортын дугуйлангуудын үйл ажиллагааг дэмжих ба Соёлын биет бус өв, язгуур урлагийн шавь сургалтыг бий болгосон бүлэг, хамт олон, өвлөн уламжлагчдыг дэмжиж, урамшуулах тогтолцоог бий болгоно.*
- Нүүдлийн соёлыг түгээн дэлгэрүүлэх: 1.2.8. *“Дэлхийн нүүдлийн соёл, иргэншлийн голомт” байгууллагыг байгуулах, Дэлхийн нүүдэлчдийн төв болох цогц хөтөлбөрийг төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлнэ.*

Үүнээс үзэхэд Монгол Улсын төр засгаас хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үйл ажиллагаанууд нь нүүдлийн соёлын ижилсэлд суурилсан оюун санааны нэгдмэл байдлыг бий болгоход түүнийг дотооддоо ч, гадаадад ч тэр түгээн дэлгэрүүлэх нь зүйтэй гэсэн үзэл хандлагатай байна. Ингэхдээ дээр дурдсанаар салбар бүрийн хүчийг дайчилж, илүүтэй анхаарал хандуулан ажиллах талаар ярьж байгаа нь ч мөн тус бодлогын баримт бичигт гүйцэтгэх үйл ажиллагаа болж тусжээ. Түүнчлэн “1.2.11. *Соёлын үйлдвэрлэл, соёлын бүтээлч аялал жуулчлалыг Монголын нүүдлийн соёлын онцлогт тохируулан нутагшуулж, үндэсний загвартай болох, үндэсний үнэт зүйлийг бүтээх, хадгалах, хамгаалах, аялал*

жуулчлалын эргэлтэд оруулахад зориулсан мэдээллийн систем, цахим технологи нэвтрүүлнэ” гэсэн үйл ажиллагаа нь дараах баримтууд дээр ч мөн тусгагдсан байна.

Монгол Улсын Их Хурлын Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай 2020 оны 08 сарын 28 өдрийн тогтоол<sup>14</sup>

Зорилго 1. Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ.

1.1.2. үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгоно.

### Нүүдлийн соёл иргэншилт Монгол

Зорилт 1.2. Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ:

1.2.1. өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг төлөвшүүлж, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх цогц арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ.

1.2.2. нүүдлийн соёл, иргэншлийн судалгааны төв байгуулах ажлыг эхлүүлсэн байна.

1.2.3. үндэсний сор бүтээл, брэнд, үндэсний шинэлэг бүтээл зэргийг монгол үндэсний нүүдлийн соёлын онцлогт тохируулан бүтээнэ.

1.2.4. хүүхдийн соёлын өв, хөгжлийн төвийг байгуулах ажлыг эхлүүлнэ.

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР<sup>15</sup>

2.6. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно.

2.6.3.2. олон улсад өрсөлдөх чадвар бүхий соёл урлагийн чадварлаг хүний нөөцийг бэлтгэж, ажлын байраар хангах тогтолцоог сэргээнэ.

2.6.3.3. үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, кино урлаг, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулна.

2.6.3.4. нүүдлийн соёл иргэншлийн суурь дээр тулгуурласан мэргэжлийн урлагийг хөгжүүлж, бүс нутаг, олон улсад өрсөлдөх чадвар бүхий монгол брэндийг бий болгож соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ.

<sup>14</sup> "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн ...."

<https://legalinfo.mn/mn/detail/15584/2/211215>.

<sup>15</sup> "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ... - Legalinfo.mn."

<https://legalinfo.mn/mn/detail/15804>.

Дээрх баримт бичгүүдэд тусгагдсанаар нүүдлийн соёлыг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаануудаас гадна түүнд тулгуурласан “соёлын бүтээлч үйлдвэрлэл” болон “бүтээлч эдийн засаг”-ийн тухай нийтлэг тусгагдсан байна. Түүнчлэн ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Миний бие, Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөртөө “Соёлын бүтээлч үйлдвэрлэл”-ийг дэмжин, Монгол туургатны өв соёлыг дэлхийг таниулах соёл, урлагийн Монгол брэндийг хөгжүүлэхээр тусгасан. Манай улс байгалийн өвөрмөц дүр төрх, баялаг өв соёлын онцлогоо шингээсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах бүрэн боломжтой бөгөөд энэ нь монгол соёлоо дэлхий нийтэд сурталчлан таниулах өргөн боломжийг нээж өгч байна.”<sup>16</sup> хэмээн онцолсноос Монгол Улсын төрөөс энэ үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулж байгааг илэрхийлж байна.

Тэгэхээр Монгол улсын төрөөс одоо хэрэгжүүлэхээр төлөвлөж буй соёлын бодлогод нүүдлийн соёлын онцлог, элементүүдийг эдийн засгийн өгөөжтэй байдлаар олон улсад таниулахад чиглэсэн үйл ажиллагааг ихээхэн эрчимжүүлж байгааг харж болно. Өөрөөр хэлбэл дээр дурдсан бодлогын баримт бичгүүд дэх “соёлын бүтээлч үйлдвэрлэл” гэсэн бодлого, үйл ажиллагаа нь Монгол улс дэлхийн бусад улсуудаас ялгарах соёлын нөөц буюу нүүдлийн соёлын онцлог, элементүүдэд тулгуурлан эдийн засгаа хөгжүүлэх арга замыг эрэлхийлж байна.

---

<sup>16</sup> "У.Хүрэлсүх: Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн ...." 30 Nov. 2021, <https://montsame.mn/mn/read/282639>.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ: КАЗАХСТАН БА НҮҮДЛИЙН СОЁЛ

Ширин Алднер Зөвлөлтөөс өмнөх үеийн Казахын ижилслийг бүрдүүлэгч 4 хүчин зүйлийг нэрлэсэн нь: газар нутагтайгаа холбогдох байдал, Исламын шашин, Түрэг угсаа соёл, нүүдлийн соёлын өв байна (Allworth 1994). Үүний зэрэгцээ Казахстан ЗХУ-ын бүрэлдэхүүнээс гарч, тусгаар тогтносон хэдий ч тус улс дахь нүүдэлчдийн улс төрийн хандлага, үзэл бодолд Зөвлөлтийн нөлөө, мөн орчин үеийн угсаатны бодлого хэсэгтээ л нөлөөтэй хэвээр байжээ (Nichols 2001: 863-974). Тус улсын төрөөс нийтлэг “Казахстаны ижилсэл”-ийг бий болгох үүднээс нүүдэлчдийн ижилслийг хэл, шашин, иргэний харьяалал зэрэг бүх нийтийг хамарсан бусад хүчин зүйлсийн хамт, шууд бусаар ашигладаг тул үндэсний үзлийг бүрдүүлэгч нэгэн хүчин зүйл болдог хэдий ч төрийн бодлогын түвшинд тийм ч өндөр байр суурь эзэлдэггүй. Нүүдлийн соёлын талаар хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдэд хангалттай хэмжээнд дурдаагүй байдлыг “казахчлах” үйл явц, хэл, шашин, иргэний харьяалалтай холбоотой зохицуулалтууд, мөн тус улсад үүсээд буй угсаатны хурцадмал байдалтай холбож тайлбарлах боломжтой.

Нэгдүгээрт, 1991 онд Казахстан улс тусгаар тогтносноос хойш казахуудын нүүдэлчидтэй холбоотой үндэсний ижилсэл нэлээд анхаарлын төвд байж ирсэн хэдий ч нүүдэлчдийн талаар сөрөг үзэл хандлагын нөлөөнд автаж явсаар, өнөө үед ирэхэд үл нийцэх түүхэн уламжлал төдий хэмээн үнэлэгдсээр байгааг дурдах нь зүйтэй (Ferret 2016; 2018). Олон судлаачдын тэмдэглэн үлдээснээр Казахстаны нүүдэлчдийн орчин үеийн хэлбэрийн талаарх болон угсаатны зүйн судалгаа дутмаг байгаа, мөн төрийн хувьсал хөгжлийн дагуу нүүдлийн мал аж ахуй нь суурин амьдралын хэв маягт шилжих жамтай, өнгөрсөн үеийн соёл иргэншил хэмээн үзэх үзэл давамгайл байна (Abdam 2016; Ferret 2016, 2019; Nichols 2001; (Karin & Chebotarev 2002).

Бүгд Найрамдах Казахстан Улсын малчдын соёл, уламжлалын асуудлыг хөндсөн хамгийн анхны бодлогын баримт бичгүүд нь Хувьчлалын тухай хууль (1991), Түүх, соёлын өвийг хамгаалах тухай хууль (1992)-ууд бөгөөд эдгээрийн дараагаар Соёлын тухай хууль (1996), “Бүгд Найрамдах Казахстан Улс дахь аялал жуулчлалын үйл ажиллагааны тухай” хууль (2001), “Бүгд Найрамдах Казахстан Улсын соёлын бодлогын үзэл баримтлал”-ын тухай Ерөнхийлөгчийн 939-р захирамж (2014)-ууд тус тус батлагджээ.

“Хувьчлалын тухай хууль” (1991)-ийн эх, түүний шинэчилсэн найруулгууд болон бусад голлох хууль тогтоомжуудад чөлөөт зах зээлийн эдийн засаг руу шилжихийн тулд хувийн өмчийг бий болгох эрх зүйн үндсийг бий болгож өгчээ (Jermakowicz et al. 1996). Хувьчлалын эдийн засагт шилжиж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлын хүрээнд мал аж ахуйн салбарыг дэмжих төрийн дэмжлэг суларснаар малын тоо толгой эрс цөөрч, нүүдэлчдийн шилжилт хөдөлгөөн буурсан байна (Ferret 2018; Robinson et al. 2000; Robinson&Milner-Gulland 2003). Энэ тухайд Сабирова (2001), Алимаев, Бэйнке нар (2007) нар зах зээлийн шинэчлэлийн явцад хөдөө аж ахуй эрхлэгчдийн нэр дээр бүртгэлтэй газрын

хувь буурч, улсын нөөц газрын хэмжээ нэмэгдсэнээр төрөөс газрыг хянах боломжоо хадгалж үлдсэн аж. Үүнээс үзэхэд нүүдэлчин ахуйг соёлын өвөөс гадна аялал жуулчлал, энтертаймент, байгаль хамгааллын бүтээгдэхүүн болох талаас нь “дүр төрх- бүтээх” (Zhanarstanova & Nechaeva 2015) гэсэн нэр томъёогоор илэрхийлж байгаа нь ажиглагдаж байна.

## **2.1. Эртний үндэстэн болохын баталгаа: Казахын нүүдлийн соёл**

Бүгд Найрамдах Казахстан улс нь эртнээс нааш нүүдэлчид нутаглаж ирсэн тул нүүдлийн соёлын уламжлал бүхий улсуудын нэгэн төлөөлөл юм. 2022 оны байдлаар 19.1 саяд хүрсэн<sup>17</sup> тус улсын хүн амын дийлэнхийг казах үндэстэн эзлэх бөгөөд бусад олон угсаатнуудаас хамгийн олон тоотой нь орос, украин, герман, узбек, уйгур, солонгосчууд эзэлнэ. (Nazpary 2002: 28) Өмнөд хэсгээрээ хээр, цөлөрхөг хээрийн бүслүүр, умард хэсгээрээ ойт хээрийн бүслүүр голлосон өнөөгийн Казахстаны нутаг дэвсгэрт эртнээс нааш, олон зууны туршид скиф, хүннү, харлуг, түрэг, монгол зэрэг нүүдэлчид нутагласаар ирсэн байна. Өнөөгийн Казахстаны нутаг болон тэндхийн нүүдэлчин аймгууд Монголын эзэнт гүрний задралаас хойш Зүчийн угсааны алтан ургийн хант улсуудын мэдэлд явсаар XV зууны үеийн Казахыг хант улсаас эхлэн нийтлэг нүүдлийн мал аж ахуй эрхлэх байдал, хэл соёл, улс төр тэргүүтэй олон хүчин зүйлсийн дүнд хувьд “казахын ижилсэл” төлөвшиж эхэлсэн байна. (Pavlovic 2003: 31-40) Нэг талаас байгаль цаг уур, газарзүйн орчин нөхцөлийн хувьд нүүдлийн мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой газар орон болох байдал, нөгөө талаас түүхийн явцад нүүдэлчин аймаг, улсуудтай идэвхтэй харилцаатай байж ирсэн зэрэгтэй холбоотойгоор өнөөгийн Казахстаны газар нутаг, түүх, соёл, хүн ам нь нүүдлийн соёлоос салшгүй хамааралтай. Түүний зэрэгцээ нүүдлийн мал аж эрхлэх байдал, түүнд тулгуурласан соёлын нийтлэг шинжүүд нь ч мөн өнөөгийн казах угсаатан бүрэлдэн төлөвших үйл явцад нөлөөлөхүйц үүрэг гүйцэтгэжээ.

XIX зууны дунд үеэс Оросын эзэнт гүрний нөлөөнд орж эхэлснээр эдийн засагт мал аж ахуйгаас илүүтэй газар тариалан эрхлэхийг дэмжих болж, өмнөх үетэй харьцуулбал харьцангуй олон тооны казах малчид суурин газарт амьдрах болсонтой холбоотойгоор нүүдлийн ахуйгаас холдож эхэлжээ. Тухайлбал 1916 оноос эхлэн умард хэсгийн үржил шим сайтай нутгууд руу үлэмж тооны орос иргэд шилжин суурьших үйл явц эрчимжиж, улмаар тухайн бүс нутгийн хүн амын дийлэнхийг тариачин оросууд бүрдүүлэх болов. 1917 оны Октябрын хувьсгалын үеэр казахууд Алаш Ордын Засгийн Газрыг байгуулж, Оросоос тусгаарлах оролдлого хийсэн боловч большевекүүдэд дарагдсанаар Зөвлөлт засгийн нөлөөнд орсон байна. Үүнтэй холбоотойгоор 1920-иод онд бүхэл орныг хамарсан өлсгөлөнгөөс үүдэн олон тооны малчин казах иргэд ойр хавийн бусад улсууд руу нүүж, 1930-аад оноос эхлэн малчдыг хамтралжуулах, суурьшуулах бодлогын хүрээнд малыг нь хүртэл хурааж эхэлжээ (Nazpary 2002: 29). Зөвлөлт Холбоот Улсын эрх баригчдын авч

---

<sup>17</sup> "Kazakhstan Population (2022) - Worldometer." <https://www.worldometers.info/world-population/kazakhstan-population/>

хэрэгжүүлсэн хамтралжуулах, суурьшуулах бодлогын үр дүнд 1933 он гэхэд Казахстаны хөдөө нутгуудад үндсэндээ нүүдлийн мал аж ахуй эрхлэх айл өрх байхгүй болж, зарим судлаачдын үзэж буйгаар XX зууны II хагас гэхэд тодорхой тооны мал аж ахуй эрхлэгч казахууд “хагас нүүдлийн мал аж ахуй” буюу отрын шинжтэй мал аж ахуйн эрхлэх болсон. Орон нутагт хоолны соёл тэргүүтэй нүүдлийн соёлын элементүүд тодорхой хэмжээнд хадгалагдан үлдэж, ард иргэдийн дунд байгальтай харьцах хандлага, гэр бүлийн бат бөх харилцаа зэрэг уламжлалт сэтгэлгээ зэрэг тодорхой хэмжээнд уламжлагдсан боловч нүүдлийн соёл үндсэндээ шахагджээ (Tiberghien, Xie 2018: 5-6). Ингэснээр Зөвлөлт Холбоот Улсын үеийн Казахстанд нүүдэлчин бус Зөвлөлт загварын үндэстэн байгуулах үйл явц өрнөж 1990 онтой золгожээ. (Isaacs 2018: 47-50) Үүнээс үзэхэд XX эхэн хүртэл өнөөгийн Казахстан болон казахуудын хувьд эдийн засаг, аж ахуй, соёл нь нүүдлийн мал аж ахуйд суурилж байсан бол Оросын эзэнт гүрэн болон Зөвлөлт Холбоот улсын төрийн бодлогоор шахагдаж, Казахстанд 1930-аад оны эхээр үндсэндээ эцэслэсэн байна. Ийнхүү хот сууринд суух болсноор өдөр тутмын нүүдэлчин ахуйгаас хөндийрсөн тэргүүтэй хэд хэдэн шалтгаануудын улмаас Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байх үед казахуудын уламжлалт ёс заншил, хэл, соёл ихээр алдагдсан (Амангүл 2019: 81) байна. Түүнчлэн нүүдлийн соёлын чиглэлээр судалгаа хийдэг судлаачид Казахстанд нүүдлийн соёлын уламжлал өөрчлөгдсөн тул өнөө хэр тус “улсын тухай тодорхой дүр төрх”-ийг олж харахад хэцүү ч гэж үздэг (Tiberghien, Xie 2018: 5).

1989 оны байдлаар Казахстаны хүн ам 17 сая байснаас 40 хувь нь казах угсаатан байсан бол бөгөөд Дэлхийн 2 Дайнаас хойш Зөвлөлт Холбоот Улсаас тус улсын хүн амд эзлэх европ иргэдийн тоог системтэйгээр нэмэх бодлого баримталж байжээ. Казахстаны тухайд хэдий улсын нэр нь казах угсаатны нэрээр нэрлэгдсэн боловч хүн амын дийлэнхийг оросууд эзэлдэг байсан (Pavlovic 2003: 48) төдийгүй уламжлалт соёлоос гадна казах хэл ихээхэн шахагдаж байсныг доорх баримтаас харж болох юм.

“Хэлний асуудал ямар ч тохиолдолд худал хуурмаг амлалт, өөрийн өчүүхэн зорилгод ашиглах хэрэгсэл болох ёсгүй. Хуулийг хүчингүй болгосноор Казахстан тайван байх болно гэж итгэдэг хүн байна гэж үү? Мөхөж мэдэх байдалд орсон казах хэлийг аврах цаг болсныг атгаг үзэлгүй хүн болгон ойлгохгүй байна гэж үү? Манай өвөг дээдсээс уламжлан ирсэн казах хэл мөхөх ёсгүй. Сайн дураар хэлгүй болох хүсэлтэй хүн байна гэж үү дээ? Бидний хэлний бодлого, бидний боловсруулсан хэлний хууль казах, орос хоёр хэл болон цөөнх үндэстнүүдийн хэл адилхан хөгжих бололцоог олгох ёстой.”

1992 оны 11-р сарын 11-12-ны өдрүүдэд болсон орон нутгийн захиргаад болон зөвлөлүүдийн тэргүүн нарын зөвлөгөөн дээр хэлсэн үгнээс (Назарбаев 2010: 50)

1991 онд Зөвлөлт Холбоот Улсаас тусгаар тогтносныхоо дараагаар ерөнхийлөгч Нурсултан Назарбаевын санаачилгаар оралман буюу дэлхий даяар тархан суурьшсан казахуудыг Бүгд Найрамдах Казахстан Улсад ирж амьдрахыг уриалсан бодлого хэрэгжүүлсэн байна.(Кобландин 2017: 170) 1991 онд шинээр тусгаар тогтносон Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн Газраас авч хэрэгжүүлсэн шилжилт хөдөлгөөний бодлогын хүрээнд 1991-2005 оны хооронд Узбекистанаас 285.409, Монголоос 71507, Туркменистанаас 41.787, Хятадаас 22.117, Оросоос 18.632, мөн бусад Тажикистан, Иран, Киргизстан, Туркменистан, Афганистан, Пакистан болон Зүүн Европын улсууд, Израйл, Дани зэрэг улсуудаас олон тооны оралманчууд Казахстан руу нүүж суурьшжээ (UNDP 2006: 13).

Засгийн газраас “хүн ам зүйн цогц бодлого” баримталсны зорилго нь нийт хүн амд казах угсаатны хэмжээг нэмэгдүүлэхийн тулд хилийн чанадад амьдардаг казах хэлтэй элэг нэгтнүүдийг “түүхэн эх нутагт” (БНКаЗУ-д) нь буцаан суурьшуулах (repatriation) явдал байлаа. Казах угсаатнуудыг түүхэн эх нутагт нь эргүүлэн татах бодлого нь хуучин ЗХУ-ын үед шилжин явсан орос хэлээр ярьдаг казах угсаатнууд руу биш, харин зэргэлдээх болон гадаад орнуудад амьдардаг казах хэлээр сайн ярьдаг, уламжлалт соёл, ёс заншлаа хадгалан авч үлдсэн казах угсаатнуудыг БНКаЗУ-д буцаан суурьшуулахад чиглэгджээ. (Амангүл 2019: 81-82)

Өмнөх хэсэгт өгүүлсэн Зөвлөлт Холбоот Улсын бодлогын дагуу 1930-аад онд нүүдлийн мал аж ахуйгаас бүр мөсөн хөндийрч, хот тосгодод суурьших болсон болон орос тэргүүтэй казах бус угсаатнуудыг олноор шилжүүлэн суурьшуулсантай холбоотойгоор 1990 оны үе гэхэд Казахстаны казахууд ерөнхийдөө нүүдлийн мал аж ахуйд суурилсан уламжлалт соёл, ёс заншил төдийгүй казах хэлээ хүртэл мартахад хүрсэн байжээ. Тиймээс Бүгд Найрамдах Казахстан Улс тусгаар тогтносон даруйдаа хил залгаа улсуудад амьдарч байсан казах иргэдийг ирж нэгдэхийг уриалсан нь нэг талаас казах үндэстний нэрээр байгуулагдсан тусгаар тогтносон улс болохын хувьд хүн амын дунд эзлэх казах иргэдийн тоог өсгөхийг хичээсэн байна. Үүний зэрэгцээ дээр дурдсанчлан “*зэргэлдээх болон гадаад орнуудад амьдардаг казах хэлээр сайн ярьдаг, уламжлалт соёл, ёс заншлаа хадгалан авч үлдсэн казах угсаатнууд*”-ыг “түүхэн эх нутаг”-таа ирэхийг уриалж, өөрсдийн мартаж эхэлж байсан хэл соёлоо сэргээх<sup>18</sup> зорилгыг бас давхар агуулж байсныг харж болох юм.

<sup>18</sup>Соёлын өв” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад түүхэн дурсгалт үнэт зүйлсийг эх орондоо эргүүлэн авч ирж, олон тооны хөшөө дурсгалыг сэргээн засварлаж, хаа сайгүй археологийн болон угсаатан зүйн эрэл хайгуул хийж буй нь казах үндэстний нэгэн үед үрж гээгдүүлсэн өөрийн гэсэн өвөрмөц байдлын үндэс болсон үндэснийхээ уламжлал, ёс заншил, соёлоо сэргээж, хэл, уран зохиол, дуу, хөгжим, аман зохиолын гоо сайхныг сэргээн босгосоор байна. (Кобландин 2017: 170-171)



Нүүж ирсэн оралманчууд казахууд нь Казахстаны казахуудтай харьцуулахад казах хэл төдийгүй уламжлалт соёл, зан заншлаа илүү хадгалсан байсан тул ялангуяа Казахстаны төв хэсгийн Жамбыл, Мангыстау, Алматы, Кызылорда зэрэг социализмын үед оросжсон хотуудад суурьшихад ихээхэн сорилттой тулж байсан (UNDP 2006: 23). Тухайлбал Монголын казахуудын хувьд улс төр, соёлын хувьд харьцангуй биеэ даасан байдалтай байсан тул казах хэлээр сайн ярьдаг (Bargus, Werner 2010: 212) төдийгүй нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг байсантай холбоотойгоор социализмын үед ч тэр шашин шүтэх хяналт нь “Сталинизм”-аас хол (Baatar 2002: 92) байж, нүүдлийн ахуйтай ойр байсны хувьд “казах” соёл, ахуй, ёс уламжлалаа хадгалж авч үлдсэн. Монголын казахуудын уламжлалт хэл, соёлоо сайтар хадгалж, авч үлдсэн талаар миний уулзсан респондент дараах байдлаар өгүүлсэн юм.

Монголын ба Казахстаны казахууд, ер нь Шинжааны казахууд ч тэр нэг л үндэстэн учраас түүхэн уг сурвалжийн хувьд хэл, соёл, ёс заншлын хувьд ямар ч ялгаа байхгүй, харин ХХ зууны 20-иод оноос хилийн зурвас татагдаж, хоёр өөр гүрний харьяалалд хамрагдаж хуваагдсанаас хойш орчин суугаа тус тусынхаа улс үндэстний соёлоос нэвчиж орж ирсэн элементүүд аль алинд нь бий. Ялангуяа орос соёл казахстанчуудад арай илүү нэвчиж, казах суурь соёлыг түрэх хандлага хааяа байдаг учраас сүүлийн жилүүдэд эргэж казахуудын түүхэн уламжлалт соёлыг эрчимтэй сэргээхээр ажиллаж байх шиг байна. Орос Хятад доторх үндэстний цөөнхүүдэд их үндэстний дарамт үзүүлэн нөлөөлж ирсэн бол Монгол улс доторх казахууд тийм дарамтыг үзээгүй. Үүнд хэд хэдэн хүчин зүйлс нөлөөлсөн байх, тухайлбал:

1. Монголчуудад нийтлэг байдаг уужуу ухаан, тайван зан чанар,
2. Монгол ба казахуудын соёлын өв, үндэс уг сурвалж ижил төстэй байсан тул эрс ялгарч, бие биедээ харшлах зүйл бага байсан төдийгүй харин ч бие биеэсээ сурч, баяжуулах нөлөө үзүүлсэн байж болох юм.
3. Хятадын ба Казахстаны казахууд Монголын казахуудтай шууд хил залгаж оршиж байгаа тул хоорондоо урлаг, соёл, боловсролын талаар тасралтгүй харилцаатай байсан явдал,

4. Казах үндэстний хэл, соёл, түүх, заншлыг хүндэтгэж ирсэн Монголын төрийн зөв бодлоготой холбоотой гэж үзэж байна. (К.Улыкпан 2022, Ярилцлага)

Тэгэхээр оралманы бодлого нь нэг талаас хүн ам, нөгөө талаас соёлын хувьд жинхэнэ утгаар Казахстан улс болоход чиглэсэн бодлого болох бөгөөд нүүж ирсэн оралманчууд нь тус улсын хүн амд эзлэх казах угсаатны тоог нэмэхээс гадна уламжлалт соёлоо сайн хадгалж байсны хувьд “түүхэн эх нутаг”-аа *казахжуулах*<sup>19</sup> учиртай байжээ. Өөрөөр хэлбэл Казахстаны төрөөс нүүдлийн мал аж ахуй болон түүнтэй холбогдох уламжлалт соёлоосоо холдож хөндийрсөн байсан өөрсдийнхөө соёлыг оралмануудаар сэлгэх нь тус бодлогын нэгэн томоохон ач холбогдол байсан ба түүнийх нь гол хэрэглэгдэхүүн нь оралмануудын дунд сайтар хадгалагдсан казахын уламжлалт соёл буюу нүүдлийн соёл байв.

Зөвлөлт Холбоот Улс задарч, Казахстан тусгаар тогтносныхоо дараа юун түрүүнд гудамж, талбайн орос нэрүүдийг Аблай Хан, Желтоксан, Сейфулин, Курмангазы зэрэг казахын түүхэн зүтгэлтнүүд болон онцгой үйл явдлуудын нэрээр сольж, казах угсаатан болон казахын түүхийг илүү Зөвлөлтөөс өмнөх үеийнхээ түүх рүү эргэн харсан шинжтэйгээр, ялангуяа “нүүдэлчин” гэх ойлголттой холбож эхэлсэн (Isaacs 2018: 54). Тухайлбал тусгаар тогтносон даруйдаа Казахстан улсын казахуудаас гаралтай улс гэдгийг тодотгох зорилгоор төрийн дуулал, төрийн сүлд, төрийн далбаа зэргээ бүтээсэн нь Төв Азийн бусад улсуудаасаа ихээхэн өвөрмөц, ялгаатай байлаа. Узбекистан, Туркменистан улсуудаас ялгаатай нь Казахстан улс төрийн далбаандаа шашны бэлгэ тэмдэг, дүрслэл ашиглаагүй нь “үндэстний үзэл санааг төлөвшүүлэхдээ шашныг ашиглах”-аас татгалзсан (Melich, Adibayeva 2013: 269) байх ба оронд нь казах гэрийн тооно, талын бүргэдийг дүрсэлсэн байдаг. Төв Азийн нүүдэлчдийн аж ахуй, соёлын салшгүй нэг хэсэг болсон гэрийн тооныг төрийн далбаа төдийгүй төрийн сүлдэндээ дүрсэлсэн нь Казахстан улс, түүний доторх ард түмэн нүүдлийн соёлтой салшгүй холбоотой болохыг илэрхийлж буй хэрэг юм.

---

<sup>19</sup>Энэхүү шилжилт хөдөлгөөний бодлого нь хүн амын угсаатны бүтцийг тэнцвэржүүлэх, үндэстний нийтлэг шинжийг хадгалах хамгаалах, уламжлалт хэл соёлоо сэргээх замаар, шинээр улс байгуулах, улс үндэстэн оршин тогнох үндсийг бэхжүүлэх, үндэстний дархлааг бий болгоход чухал үүргийг гүйцэтгэжээ (Амангүл 2019: 96)



Өнөөгийн Казахстан улсын газар нутагт Хүрлийн үеэс нүүдэлчид нутаглаж ирснийг түүх гэрчлэх ба тэд өөрсдийн гэсэн сүлдтэй байжээ. Тэр сүлдний хэлбэр дүрс нь “Тамга” гэж тайлагдах ба энэ нэрийг хожмоо Түрэгийн хант улсын үед анх ашиглаж байв... БНКазУ-ын төрийн сүлд дугуй хэлбэртэй байдаг нь Их Талын нүүдэлчдийн үнэлэмжээр амьдрал болон үүрд мөнхийн утгыг илэрхийлнэ. Шанырак /казах гэрийн тооно/ нь Казахстаны бүх ард түмний гэрийг илтгэх бол уяк/казах гэрийн унь/ нь ард түмнийг төлөөлдөг бөгөөд уяк нь шаныраkyг түшиж тогтвортой байлгадгийн адилаар иргэн нэг бүрийн сайн сайхнаас Казахстаны хөгжил хамаарна гэсэн утгыг агуулдаг<sup>20</sup>.

Шинэ тутам тусгаар тогтносон Бүгд Найрамдах Казахстан Улс гадаад, дотоод бүхий л хэргийн хүрээндээ аль нэг гадаад улсын оролцоогүйгээр цаашид бие дааж оршин тогтнох болсон тул өөрсдийн улс, үндэстнийг шинээр бүтээж, ингэхдээ Зөвлөлт Холбоот Улс, Хаант Оросоос ч өмнөх үеийн Төв Азийн түүхэнд “казах” гэсэн нэр тодорч гарч ирсэн, цаашлаад Түрэг болон эртний нүүдэлчдийн үе рүү эргэн харж эхэлжээ. Тухайлбал анхны ерөнхийлөгч Нурсултан Назарбаев “Хэн болохоо мэдсэн цагт л сая давуу талаа ойлгодгийг мартаж

<sup>20</sup> "National Emblem of Kazakhstan — Official website of the President ...."  
[https://www.akorda.kz/en/state\\_symbols/kazakhstan\\_emblem](https://www.akorda.kz/en/state_symbols/kazakhstan_emblem).

болохгүй ажээ. Дэлхийн соёл иргэншлүүдийн уулзвар дээр зуу зуун жил оршиж байсан ард түмний үр сад билээ бид. Их Тал бол элдэв олон соёл, хэл, арми, шашин, эд агуурс, үзэл санааны учран сүлэлдэж байдаг уулзвар газар байлаа. Энэ тал мянга мянган жилийн турш ард түмнүүдийг үүсгэн бойжуулагч байсан бол өнөөгийн XXI зуунд онцгой чанартай хүнийг төлөвшүүлэг, шинэ соргог үзэл санааг үүсгэгч байх ёстой. Ген-ээр бидэнд дамжин өвлөгдсөн тал газрын сэтгэх чадвар даяарчлалын хамаг сайн чанарыг тусган шингээх нь лавтай. Нүүдэлчид аливаа шинэ соргог бүхнийг эзэмших гайхамшигтай чадвартай байлаа. Эхлээд харахад тийм ч зохистой бус тэдний нүүдэл суудал байгальтайгаа, түүний үзэгдэл, хувирлуудтай гайхалтай сайхан зохицсон байлаа” (Назарбаев 2010, 292) хэмээн нүүдлийн соёлын давуу тал, ач холбогдлын талаар өгүүлсэн байна. Казах хэлнээс гадна “үндэстэн бүтээх” ажлын хүрээнд өмнө нүүдэлчин, дайчин байсныг харуулах, XVIII зууны үед Ойрад монголчуудтай тэмцэлдэж байсан тухай агуулгатай Sardar (2003), Nomad (2005), Zhauzhurek Myn Bala (2011) зэрэг хэд хэдэн киног засгийн газрын санхүүжилтээр бүтээсэн (Isaacs 2018: 17). Түүнчлэн Бүгд Найрамдах Казахстан Улсын Соёлын Бодлогын тухай үзэл баримтлалд нэмэлтээр гаргасан Ерөнхийлөгч Н.А.Назарбаевын гаргасан 2014 оны 11-р сарын 04-ний өдрийн 939 тоот зарлигт кино урлагаар дамжуулж өөрийн улсын соёлыг олон улсад сурталчлах соёлын дипломат ажиллагааны<sup>21</sup> тухай зорилтдоо дараах байдлаар өгүүлсэн байна.

Түүх, соёлоо шинэчилж, дэлхийн орон зайд нэгтгэх хамгийн үр дүнтэй арга зам бол кино урлаг, кино урлагийг хөгжүүлэх, дэлхийн тэргүүлэгч кино компани, телевизүүдийг хамтын ажиллагаанд татан оролцуулах явдал юм<sup>22</sup>.

Тэгэхээр нүүдлийн соёл нь Засгийн газрын хувьд ижилсэл бүтээх гол хэрэгсэл болж байгаагаас (Tiberghien, Xie 2018: 7) гадна Казахстан улс дэлхийн газрын зураг дээр урьд хожид байгаагүй, эсвэл Зөвлөлт Холбоот Улс нуран унаснаар түүнээс тусгаар тогтносон “шинэ улс” гэх ойлголтоос зайлсхийж, улс үндэстнээ аль болох урт удаан жилийн түүхтэй гэсэн ойлголтыг түгээх сонирхлынх нь илрэл гэж үзэж болох юм. Үүний хүрээнд соёлын хувьд Зөвлөлт загварын оросжсон эсвэл зүүн европжуу угсаатан бус, Төв Азийн нүүдэлчин угсаатан болох, түүхийн хувьд наанадаж Казахын хант улсаас эхэлсэн өөрсдийн гэсэн

---

<sup>21</sup> ХБНГУ-ын Берлин хотноо төвтэй Соёлын дипломат ажиллагааны хүрээлэн “Соёлын дипломат ажиллагаа гэдэг бол улсуудын харилцааг бэхжүүлэх, нийгэм-соёлын хамтын ажиллагааг бататгах буюу үндэсний эрх ашгаа хөхиүлэн дэмжих зорилгоор үзэл санаа, үнэт зүйл, уламжлал болон соёлын бусад аспектийн солилцоон дээр үндэслэдэг буюу тэдгээрийг ашиглан явуулдаг үйл ажиллагаа мөн” гэж тодорхойлсон (Баасанхүү et al. 2019: 155)

<sup>22</sup> “On the Concept of cultural policy of the Republic of Kazakhstan.”  
<https://adilet.zan.kz/eng/docs/U1400000939>.

түүхийг сэргээн таниулах шаардлага тулгарч байсны аль алинд нь *казахуудын уламжлалт соёл буюу нүүдлийн соёл*<sup>23</sup> чухал үүрэгтэй байна.

## 2.2. Казах үндэстэн, Казахстан үндэстний дундах нүүдлийн соёл

Юун түрүүнд шинэ тутам тусгаар тогтносон Казахстан улсын үндэстэн бүтээхтэй холбоотой асуудал, тэр дундаа “казах” үндэстэн бүтээх болон “казахстан” үндэстэн бүтээх гэсэн 2 ойлголтын зааг ялгааг товч байдлаар тусгах нь зүйтэй болов уу. Өмнө хэсэгт дурдсан оралманы бодлого болон уламжлалт соёлын өвийг сэргээх тухай бодлогууд нь ихэвчлэн Казахстаны уугуул казахууд болон гадаад улсуудаас ирсэн казахууд буюу казах угсаатан руу чиглэсэн казах үндэсний хэл, соёлыг сэргээх, түүнд суурилсан үндэсний үзлийг бүтээх. Нөгөө нь Казахстан улсын хүн амыг бүрдүүлж буй угсаатнуудыг нийтэд нь хамарсан “олон угсаатнаас бүрдсэн улс”-ын иргэн төвтэй үндэстний үзэл гэсэн 2 чиглэлээр бодлого хэрэгжүүлж байна (Melich, Adibayeva 2013: 4-7), (Melich, Adibayeva 2013: 269-270).

Зөвлөлт Холбоот Улсын задралаар Казахстан улс тусгаар тогтнол, тогтвортой байдлаа хадгалахын тулд хүн амыг нь бүрдүүлэгч олон угсаатны бүлгүүдийн дунд нийтлэг үндэсний онцлогийг хөгжүүлэх шаардлагатай болжээ (Zhanarstanova & Nechaeva 2015; Kanter 1993). Тиймээс Ерөнхийлөгчийн зүгээс угсаатан хоорондын эв найрамдлыг бий болгож, зөрчил мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэхийн ач холбогдлыг ухуулж байсан бөгөөд энэ үзэл санаа нь Үндсэн Хууль (1993, 1995), Үндэсний эв нэгдлийн үзэл баримтлал (2008)-д тусгалаа олсон байна. Тэгэхээр тус улсын төрөөс үндэсний хэмжээнд тусгаар тогтносон төрт ёсыг бий болгохын тулд үндсэрхэг үзлийг улс төр- үзэл суртлын хэрэгсэл болгон ашиглаж байгаа бөгөөд үүнийг “казахчлах” (Abdam 2016; Karin & Chebotarev 2002; Lee 2002) хэмээн тодорхойлж байна.

Казахчлах гэсэн энэхүү үндэсний хэмжээний бодлого нь Казах үндэстнийг сэргээн хөгжүүлэхэд чиглэсэн байна. Казахстан улсын төрөөс тус улсын хүн амыг бүрдүүлэгч олон угсаатнууд дундаас төр- баригч Казах үндэстний голлох байр суурийг бататган хадгалах зорилгоор казахчлах бодлогыг нийгэм, улс төрийн бүхий л хүрээнд хэрэгжүүлдэг байна. Энэ нь ч Үндэсний эв нэгдлийн үзэл баримтлал (2008)-ын “Бидний үндэсний эв нэгдлийн тулгуур багана бол гагцхүү Казахстан улсынхаа ирээдүйн сайн сайхны төлөө гарал угсаа үл хамааран, нэг нэгэнтэйгээ үлэмж хэмжээний найрсаг харилцаатай байх явдал юм”, “Бидний аугаа их зорилго хоорондоо эвлэлдэн нэгдэж, Агуу Үндэстэн болох юм” зэрэг тунхагуудад тод томруун тусжээ. Үүний зэрэгцээ Казахстан улсын нийт ард түмний эв нэгдлийг хангахад казахууд голлох үүрэг гүйцэтгэх хэрэгтэй аж. “Казахстан”<sup>24</sup> (Zhanarstanova &

<sup>23</sup> "Казахстаны казахууд өөрсдийн уламжлалт соёлоо гарцаагүй нүүдлийн соёл, нүүдэлчин амьдралаас урган гарч, үеэс үед уламжлагдаж, баяжиж ирсэн соёл гэж үздэг. Харин нүүдлийн хольцоо нь үгүй шижир шиг цэвэр соёл суурьшлын сүүдэрт дарагдан, цаг хугацаа өнгөрөхийн хэрээр бүдгэрч эхэлж байгаад Казахстаны нийгэм, соёл судлаачид санаа зовниж, ярьж бичсэн, засаг төрдөө сануулсан зохиол туурвилууд цөөнгүй бий. (Ярилцлага)

<sup>24</sup> "National unity doctrine." <https://assembly.kz/en/prochee/national-unity-doctrine>.

Nechaeva 2015) хэмээх ижилслийг бүрдүүлж төлөвшүүлэхийн тулд угсаатан нэг бүрийн онцлог шинж бус, нийт хүн амын дундах нийтлэг шинжүүдийг чухалчилсан байна (Ferret 2016). Тиймээс зарим тодорхой угсаатны бүлгүүдийн нүүдлийн өв соёлын тухайд төр улсын түвшний асуудал биш болжээ.

Энд Казахстан үндэстэн гэх ойлголт нь “цаасан дээр” бичигдсэн бодлого төдий бус, “ард иргэдийг нэгтгэсэн жинхэнэ бодлого” гэдгийг дурдах нь зүйтэй. 2010 оны янз бүрийн бүс нутаг, угсаатнуудыг хамруулсан судалгаанаас харахад нийт оролцогчдын 53% нь Казахстан улсыг бүгд найрамдах улс, харин түүний доторх олон үндэстнүүд нийлж, нэг Казахстан үндэстнийг бүрдүүлдэг гэж хардаг ажээ (Mukhamedzhanov & Zhusupova 2010; Zhanarstanova & Nechaeva 2015). Тус улсын хүн амын 75 гаруй хувь нь улсынхаа төрөөс хэрэгжүүлж буй үндэсний бодлогыг нэлээд сайн хэмээн үздэг байна. Олон нийтийн санаа бодол нь дээр өгүүлсэнчлэн эерэг байгаа хэдий ч төр засаг шууд “казахчлах” бодлого хэрэгжүүлж буйгаа хүлээн зөвшөөрөх нь юу л бол (Abdam 2016).

-Хэл, шашин, иргэншлийн зохицуулалт

Бүгд Найрамдах Казахстан Улс үндэсний онцлогийг улс төрийн хүрээнд хэрхэн бий болгож буй талаар судалсан олон судалгаа байдаг (Abdam 2016; Kanter 1993). 1993, 1995 оны Үндсэн хуулиудад үндэсний үндсэн ижилслийг төлөвшүүлэхээс гадна үг хэлэх, жагсаал цуглаан зохион байгуулах, зарим хэлээр ярих, мөн төр засгийн хэмжээнд угсаатны шинж чанарыг ил тод хэлбэржүүлэхээс хамгаалсан шашны зарим зан үйл үйлдэх эрх, эрх чөлөөг баталсан байна (Abdam 2016; Dyatlenko 2007). Хэлний бодлогын стратегийг “ихэвчлэн төрөөс боловсруулж, хэрэгжүүлдэг ч хэлний хэрэглээний нөхцөл байдал нь тус улсын дотоод чиг хандлага, үйл явдлуудтай холбоотой байдаг тул мэдээж зүгээр нэг сонголт төдий бус юм”. Түүнчлэн хэл бол төрийн бодлогыг хэрэгжүүлэх төдийгүй “угсаатан хоорондын босоо тэнхлэг дэх ялгамжааг хэвтээ тэнхлэгт нэгтгэх” хэрэгсэл болдгийг дурдах нь зүйтэй. Бүгд Найрамдах Казахстан Улсын тухайд хэл, түүнтэй холбоотой асуудлуудыг Үндсэн хууль (1995), “Бүгд Найрамдах Казахстан Улс дахь хэлнүүдийн тухай” 151-I хууль (1997), Хэлний бодлогын үзэл баримтлал (1996), Хэлний үүрэг, үйл ажиллагаа, хөгжлийн тухай Ерөнхийлөгчийн тунхаг (1998) зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд тусгажээ.

Үндсэн хууль (1995)-д зааснаар Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн хэл нь казах хэл байна. Гэсэн хэдий ч “төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудад орос хэлийг казах хэлний мөн адил албан ёсоор эрх тэгш хэрэглэнэ”<sup>25</sup> (Zhanarstanova & Nechaeva 2015). “Хэлний тухай хууль” (1997)-д “Казахстан улсын нийт ард иргэд аливаа хэлээр суралцах, түүнийг хөгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ”<sup>26</sup> хэмээн зүйлчилж

<sup>25</sup> "The Constitution — Official website of the President of the Republic ...."  
[https://www.akorda.kz/en/official\\_documents/constitution](https://www.akorda.kz/en/official_documents/constitution).

<sup>26</sup> "The Constitution — Official website of the President of the Republic ...."  
[https://www.akorda.kz/en/official\\_documents/constitution](https://www.akorda.kz/en/official_documents/constitution).

заасны дагуу иргэн бүр өөрийн унаган хэлээрээ ярих, мөн аливаа харилцаа холбоо, өсгөн хүмүүжүүлэх, сурч боловсрох, бүтээл туурвил гаргахдаа өөрийн хүссэн хэлээ сонгон ашиглах, мөн “үндэстний бүлгүүд ойр суурьшсан газруудад аливаа үйл ажиллагаа явуулахад тэдний хэлийг ашиглах” эрх зүйн орчныг бүрдүүлсэн нь бусад угсаатнуудын хэл ч мөн адил төрөөс халамж, хамгаалал хүртдэгийг харуулж байна (Zhanarstanova & Nechaeva 2015). Хэл, түүнтэй холбоотой асуудлаар иргэдийн эрхийг зөрчиж болохгүй гэсэн заалтыг хуульд тусгасан нь казахчлалын тухай элдэв яриа, орос хэлээр ярьдаг хүн амыг зарим талаар ялгаварлан гадуурхаж буйтай холбоотой юм. 1993 оны Үндсэн хуулиар баталсан хэлний бодлого, түүнээс үүдэн улс төрийн байдал нь доройтсонд орос иргэд дургүйцэж, Казахстанас Орос руу чиглэсэн олон тооны орос иргэдийн урсгал өрнөжээ (Abdam 2016; Lee 2002; Smagulov 2010; Kanaryanov & Zhanarstanova 2012).

Казахстан улсын Засгийн газраас “Шилжилт хөдөлгөөний тухай хууль” (1993), “Иргэншлийн тухай хууль” (1991), Ерөнхийлөгчийн “Бүгд Найрамдах Казахстан Улс дахь гадаад иргэдийн эрх зүйн статусын тухай” (1995), “Бүгд Найрамдах Казахстан Улсад гадаад иргэд болон улс төрийн харьяалалгүй хүмүүст орогнол олгох журмын тухай” (1996), “Казахстан улсын иргэншилтэй холбоотой асуудлыг хэлэлцэх дарааллын тухай” (1996) зэрэг тунхаг, эрх зүйн баримт бичгүүдэд шилжилт хөдөлгөөнтэй холбоотой зохицуулалтуудыг тус тус тусган баталжээ.

“Шилжилт хөдөлгөөний тухай” хуулиар шинэ тутам тусгаар тогтносон Казахстан улс шилжих хөдөлгөөний бодлогынхоо гол үндсийг тавьжээ (Abdam 2016). Тус хуулийн дагуу түүхэн эх орондоо буцаж ирсэн олон олон казах диаспора болон Казахстанд төрсөн боловч түүхэн үйл явдал (хэлмэгдүүлэлт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт)-ын улмаас эх орноо орхин нүүсэн иргэдэд дүрвэгчийн статус олгох, тэднээс бусдыг нь цагаач хэмээн ангилахаар зүйлчилсэн байна. Энэ талаар Абдам (2016) Казахстаны төрөөс эдгээр гурван бүлгийн аль алинд нь оршин суух таатай нөхцөлийг бүрдүүлсэн байна хэмээн үзжээ (Abdam 2016).

Ялангуяа Казахын Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Улсын Сайд нарын танхимын “Нүүлгэн шилжүүлэх журам, нөхцөлийн тухай” 711-р захирамжид казахуудыг бусад улсуудаас нутаг буцаан татах ажлыг нарийвчлан тусгажээ. Тус хуулиар бусад улсуудаас аж ахуйн нэгдэл, фермүүдэд ажиллахаар ирсэн “уугуул” иргэдэд тэтгэмж олгох тухай заасан байна. Энэ нь “Орос хэлтнүүд тус улсаас бусад улс руу цагаачилж байсантай холбоотойгоор хурцаар тавигдаж байсан ажиллах хүчний дутагдлыг нөхөх үйл явц байв” (Abdam 2016; Smagulov 2010). Улсын хэмжээнд казахууд угсаатны цөөнх байсан бол энэхүү шилжилт хөдөлгөөн болон бусад олон хүчин зүйлсийн үр дүнд олонх болсон байна.

Хэл, шилжилт хөдөлгөөний бодлогоос гадна төрийн зохицуулалт шашны үйл ажиллагаа, холбоод, шашны нөлөөллийн бусад хэлбэрүүд рүү чиглэж байв. Николс (2001)-ийн үзсэнээр Исламын шашин нь “нүүдэлчин казахуудын дунд тийм ч гүн суугаагүй байна.



Казахуудын уламжлалт хэв хуульд Исламын шашны фикх, Шариатын ёс тодорхой хэмжээнд нэвчсэн байдаг ч Казахстаны хууль ёсны өвийн голлох хэсгийг Исламын шашин тодорхойлдоггүй” аж (Nichols 2001; Lee 2002). Сүүлийн үед “тус улсын хууль ёсонд үл нийцэх янз бүрийн урсгалын шашны байгууллагуудын үйл ажиллагаа, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр казахуудын сэтгэхүйд харь Исламын шашны итгэл үнэмшлийг түгээх, Исламын халифат улс байгуулах болон бусад тэрс үзэл санаагаар шашныг улс төржүүлэх” зэрэг гаднын хүчин зүйлс Казахстан дахь уламжлалт Исламын шашны урсгалд нөлөөлөх болжээ (Satrovic 2018).

Казахстан Улсын Ерөнхийлөгчөөс ард иргэддээ хандаж хэлсэн үгэндээ “Бид тусгаар тогтнолын энэ 16 жилийн хугацаанд олон нийтийн тогтвортой байдал, олон угсаатнууд эв найрамдалтай зэрэгцэн орших, Казахстаны ижилсэл, Казахстаны эх оронч үзлээ төлөвшүүлэх загварыг хэрэгжүүлж чадсан... Бид үүгээрээ бахархах нь зүй ёсны хэрэг бөгөөд цаашид улам бататгах ёстой юм” хэмээн онцолжээ (Karin & Chebotarev 2002). 2005 онд “Экстремизмтэй тэмцэх тухай”, “Бүгд Найрамдах Казахстан Улсын экстремизмтэй тэмцэх тухай зарим хууль зүйн актад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиудыг баталсан байна. Одоогийн байдлаар аливаа экстремист үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь үр дүнтэй хэрэгжиж байгаа аж (Satrovic 2018). Түүнээс хэдэн жилийн дараа батлагдсан Шашны үйл ажиллагаа, шашны холбоодын тухай хууль (2011) нь олон улсын хүний эрхийн байгууллагуудын зүгээс бүртгэлжүүлэлт шаардаж, шашны эд зүйлсийг хязгаарлаж, олон нийтийн газруудад шашны үйл ажиллагааг хориглож буйгаараа шашны эрх чөлөөнд хэт халдаж байна гэсэн шүүмжлэлтэй тулсаар ирсэн байна (Brady 2015; Smagulov 2010). Тухайлбал, АНУ-ын Олон улсын шашны эрх чөлөөний комиссын 2013 оны тайланд тус хуулийг “дарангуйлагч” гэж тодорхойлж, “2012 онд бүртгүүлсэн шашны байгууллагуудын тоо огцом буурах” болсон шалтгаан гэж дүгнэжээ<sup>27</sup> (Brady 2015).

Түүнчлэн Казахстанд нүүдэлчид чухам ямар байр суурь эзэлдэг нь тодорхойгүй байгаа хэдий ч үндэсний эв найрамдлыг хадгалахын тулд хийж буй иргэншил, хэл, шашин шүтлэгтэй холбоотой зохицуулалтууд нь цөөнх бүлгүүдийн эрх чөлөөг хязгаарлахаас буцахгүй шинжтэй байгааг харж болно (Zhanarstanova & Nechaeva, 2015; Abdam 2016; Karin & Chebotarev 2002). Эсрэгээрээ төр угсаатны цөөнх бүлгүүдийн эсэргүүцэлтэй тулсан тохиолдолд эдгээр хуулиудаа эргэн татахад бэлэн байна.

-Төрийн хэрэг дэх угсаатны цөөнхийн төлөөлөл.

Үнэн хэрэгтээ Казахстан Улсыг олон соёлт нийгэм биш боловч хоёр соёлт нийгэм гэж тодорхойлох нь илүү тохиромжтой юм. ЗХУ-ын уналтаас хойш голлох угсаатнууд нь казах, оросууд байв (Lee 2002; Karin & Chebotarev 2002; Канарьянов & Zhanarstanova 2012). Тэр ч үүднээсээ хэд хэдэн судлаачид уйгур, узбек, татар болон бусад угсаатны цөөнх

---

<sup>27</sup> "KAZAKHSTAN - US Commission on International Religious Freedom."  
<https://www.uscifr.gov/sites/default/files/resources/Kazakhstan%202013.pdf>.



бүлгүүдийн төрийн хэрэгт оролцох төлөөллийн талаар авч үзсэн байна (Smagulov 2010; Zhanarstanova & Nechaeva 2015).

Казахстан Улсын “Улс төрийн намуудын тухай” хууль (2002)-аар “улс төрийн намыг аль нэг мэргэжил, арьс өнгө, иргэний харьяалал, гарал угсаа, шашны үндсэн дээр байгуулахгүй”<sup>28</sup> хэмээн заасан байдаг. Энэ нь нэг талаар аль нэг угсаатны бүлэг улс төрийн тавцанд ноёлох нөхцөл бүрдэхээс урьдчилан сэргийлж байгаа, нөгөө талаар төрийн хэрэг дэх угсаатны цөөнхүүдийн нөлөөг хязгаарлаж байгааг илтгэж байна.

Жанарстанова, Нечаева нар (2015)-ын үзсэнээр Казахстан улсын боловсон хүчний бодлогын сул талыг илрүүлэхийн тулд үндэсний нөхцөл байдалд байнгын хяналт, дүн шинжилгээ хийж байх шаардлагатай байна (Zhanarstanova & Nechaeva 2015). Энэ талаар хийсэн асуулгад оролцогчдын ихэнх нь өөрсдийн угсаатны төлөөлөл төрийн байгууллагуудад хангалттай хэмжээнд ажилладаггүй гэж үзсэн бөгөөд тэр дундаас ялангуяа уйгур, узбек, чеченүүд өөрсдийн төлөөллийг төрийн байгууллагуудад хамгийн бага ажилладаг гэж үздэг гэсэн үр дүн гарсан байна (Mukhamedzhanov & Zhusupova 2010). Засгийн газрын удирдах түвшний голлох албан тушаалтнууд (Сайд, Дэд сайд, тэдгээрийн туслахууд)-ын 80-аас илүү хувийг титуляр казах угсаатны төлөөлөл бүрдүүлдэг буюу казахууд төрийн аппаратад ноёлдог ажээ (Shkol'nik et al.). Гэвч төрийн эрх мэдлийг казахууд атгаж буй нь ялгаварлан гадуурхалт гэхээсээ илүүтэй чанаргүй боловсон хүчин, авлига хээл хахууль, ажилд ороход албан бус танилын хүрээ нөлөөлөх байдал зэрэг бусад хүчин зүйлстэй холбоотой гэж үздэг (Zhanarstanova & Nechaeva 2015; Nichols 2001). “Стратеги” сангаас хийсэн судалгаанаас казахстанчууд ажилд орох гол шалгуурыг мэргэжлийн ур чадвар (32%), ураг төрөл, гэр бүлийн холбоо сүлбээ (27%), багаар ажиллах, хөгжүүлэх чадвар (25%), төрсөн газар, нутаг усны ижилсэл (15%), албан тушаал худалдаж авах (13%) хэмээн үздэг гэсэн үр дүн гарсан байна (Zhanarstanova & Nechaeva 2015; Tatilya 2013).

Ерөнхийлөгч Назарбаевын санаачилгаар 1995 онд угсаатны төлөөллийн асуудлыг зохицуулах Казахстан Улсын Ардын Ассамблейг байгуулжээ (Zhanarstanova & Nechaeva 2015; Abdam 2016; Канаруанов & Zhanarstanova 2012). Тус байгууллага нь угтаа бол Казахстан улс дахь олон угсаатны хэл, соёлын өвөрмөц байдлыг хамгаалж, хөгжүүлэх зорилгоор Ерөнхийлөгчийн дэргэд зөвлөх статустай байгуулагдсан. Харин одоо бол иргэний төдийгүй бүхий л улсын хэмжээнд үндэсний төрийн бодлого, эдийн засгийн асуудалд оролцоотой байгууллага болон өргөжжээ (Smagulov 2010; Abdam 2016). Казахстанд угсаатанд суурилсан улс төрийн нам байхгүй байгаа ч эрх баригчдын зүгээс улс төрийн хүрээнд угсаатны цөөнхүүдийн ашиг сонирхлыг төлөөлөх нөхцөлийг бүрдүүлэхээр оролдож байна (Канаруанов & Zhanarstanova 2012). Уг тогтолцоо нь Парламент дахь угсаатны тэгш хуваарилалтыг хангах, угсаатныхаа төлөөлөл гишүүнийг нэр дэвшүүлэх боломжийн хувьд хязгаарлагдмал цөөнх угсаатныг чадавхжуулах зорилготой юм. Гэсэн

---

<sup>28</sup> "On Political Parties - "Adilet" LIS - Әділет." <https://adilet.zan.kz/eng/docs/Z020000344>.

хэдий ч хоёр танхимын аль алинд нь казахууд давамгайлсан байх буюу нийт 47 сенаторын 10, Мажилисийн 107 гишүүний 27-г л казах бус/титуляр бус угсаатнууд бүрдүүлж байна (Zhanarstanova & Nechaeva 2015).

Энд “цөөнх бүлгүүд” болон “нүүдэлчид” гэсэн ойлголтууд нь адил бус утгатай гэдгийг дурдах нь зүйтэй. Феррэт (2016) Казахстан Улсын хүн амын дундаас “нүүдлийн өв соёлыг уламжлагч цорын ганц” угсаатан нь казахууд байсан гэж үзжээ (Ferret 2016). Одоогийн байдлаар тус улсын хүн амын дийлэнх буюу 53 хувь (Smagulov 2010), Засгийн газарт хамгийн их төлөөлөлтэй буюу 80 хувийг эзэлдэг (Zhanarstanova & Nechaeva 2015) тул нүүдлийн соёлыг цөөнх бүлэгт хамааруулж тодорхойлох нь учир дутагдалтай юм. Нөгөө талаар “Казахстанд өдгөө нүүдэлчид байгаа хэдий ч хүн амд эзлэх хувь нь маш бага юм” (Ferret 2016). Нүүдэлчин ахуй, зан үйл нь соёлын хувьд ялгаатай бөгөөд нүүдэлчдийн ижилсэл, амьдралын хэв маяг нь нийгэмд өөр өөр орон зайг эзэлдэг. Төрөөс орчин үеийнхний зан үйл, газар ашиглалтаас илүүтэй нүүдэлчдийн соёл, үндэсний дүр төрхийг харгалзан үздэг нь энэ ялгааг илэрхийлж болох юм.

-Төрийн баримт бичгүүдийг судалсан явц, баримт бичгийн дүн шинжилгээ

Энэ хэсэгт Казахстан улсын Засгийн Газраас баталсан соёлын тухай хууль эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдээс шууд нүүдлийн соёлын тухайд болон нүүдлийн соёлын агуулга бүхий бодлого, үйл ажиллагаануудад анализ хийнэ.

### БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН СОЁЛЫН БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ<sup>29</sup>:

3-р зүйл. Бүгд Найрамдах Казахстан Улсын соёлын салбарын  
төрийн бодлогын үндсэн зарчим.

Соёлын салбарт Бүгд Найрамдах Казахстан Улсын төрөөс бодлого хэрэгжүүлэхдээ дараах зарчмуудыг баримтална:

5. Казах үндэсний соёлын бүрэн бүтэн байдлыг хадгалах, харилцан баяжуулах нэг хүчин зүйл бол гадаадад оршин суугаа иргэдтэй соёлын харилцааг хөгжүүлэх,

6. Казах түмэн, угсаатны диаспорагийн түүхэн өвийг хадгалах, нийгмийн бүтээлч чадавхыг хөгжүүлэх, залгамж холбоог хангахад чиглэсэн эрх зүйн баталгааг бий болгох,

11-р зүйл. Соёлын салбарт иргэдийн хүлээх үүрэг  
Иргэд дараах үүргийг хүлээнэ:

<sup>29</sup> "Law No. 207 of December 15, 2006, on Culture (as amended up to ...." <https://wipolex-res.wipo.int/edocs/lexdocs/laws/en/kz/kz083en.pdf>.

1. Бүгд Найрамдах Казахстан улсын соёлын салбарын хууль тогтоомжийг дагаж мөрдөх,
2. Казах ард түмний үндэсний соёл, ёс заншил, уламжлал болон угсаатны бүлгүүд, төрийн болон бусад хэлийг хүндэтгэх.

Казахстан улсын Соёлын тухай хууль тэргүүтэй баримт бичгүүдэд ерөнхийдөө нүүдлийн соёл (көшпенді) гэхээсээ илүүтэй “казахын уламжлалт хэл соёл, зан заншил, уламжлал”-тай холбоотой заалтууд орсон байна. Үүнээс “нүүдлийн соёл” гэж шууд нэр зааж оруулсан заалтууд байхгүй байгаа ч өмнөх хэсэгт өгүүлсэн бусад баримтуудад үндэслэн казахын үндэсний эсвэл уламжлалт соёл гэдэг нь нүүдлийн соёлын элементүүдийн тухай өгүүлж байгаа гэж үзэх боломжтой юм.

### БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬ<sup>30</sup>

#### 11-р зүйл. Боловсролын тогтолцооны үүрэг

Боловсролын тогтолцооны үүрэг нь:

3. иргэний эх оронч үзлийг төлөвшүүлэх, төрөлх Бүгд Найрамдах Казахстан Улсаа хайрлах, төрийн бэлгэдэл болон төрийн хэл, үндэсний уламжлалаа хүндэтгэх, Үндсэн хуулийн эсрэг, нийгэмд харшлах аливаа жагсаалыг тэсвэрлэхгүй байх;
5. дотоодын болон дэлхийн соёлын ололтыг үйл ажиллагаандаа тусгах; казах болон БНКазУлсын бусад ард түмний түүх, ёс заншил, уламжлалыг судлах; төрийн хэл, орос хэл болон гадаад хэлийг эзэмших хэмээн заасан нь тус улс боловсролын системдээ мөн л нүүдлийн соёлын утга агуулга бүхий казах соёл, уламжлалын талаар мэдлэг, хандлагыг төлөвшүүлэхээр заасан байна.

“Өвөрмөц орчинд мэндэлсэн өрсөлдөх чадвартай хувь хүн юуны өмнө ард түмнийхээ уламжлалт соёлыг мэддэг, төрөлх хэлээ төгс эзэмшсэн байх ёстой. Үндэснийхээ хэл, соёлын өв уламжлалд тулгуурласан боловсролоос олж авсан мэдлэг чадвар бүхий хувь хүн бүхний уусган ижилсүүлдэг даяарчлалын нөлөөнөөс өөрийн өвөрмөц онцлогийг хамгаалан хадгалж чадна” (Назарбаев 2010: 292)

Үндэснийхээ уламжлалт соёлын талаар мэдлэгтэй байхын ач холбогдлыг тайлбарласан энэ үзэл санаа нь тус улсын Боловсролын тухай хуульд тусгалаа олжээ.

---

<sup>30</sup> "On Education - "Adilet" LIS - Әділет." <https://adilet.zan.kz/eng/docs/Z070000319>.

БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2014 ОНЫ 11-Р САРЫН 04-НИЙ  
ӨДРИЙН 939 ТООТ ЗАРЛИГ<sup>31</sup> аас

“Уламжлал болон соёл гэдэг нь үндэстний генетикийн  
код юм”

Нурсултан Абишевич Назарбаев

4.6 Орчин үеийн соёлын кластер хөгжил<sup>32</sup>

Соёлын болон аялал жуулчлалын кластерууд:

-“Евразийн төв-Астана”

Нурсултан хот болон түүний эргэн тойронд нүүдэлчдийн  
язгуур соёл, үндэстний болон дэлхийн хөгжим, бүжиг, театрын  
урлагийн сор бүтээлүүдийг дотоодын уран бүтээлчид тайзнаа  
толилуулах 2017 ЭКСПО-г зохион байгуулна.

-“Казахстаны соёлын чөлөөт бүс-Алматы”

-“Байгаль дэлхий, нүүдлийн соёлын нэгдэл”\*

Казахстаны умард хэсгээр газарзүйн өвөрмөц тогтоц бүхий  
байгалийн үзэсгэлэнт газрууд, уул нурууд, ой мод, гол нуурууд  
бий. Ирээдүйд энэ бүс нутгийг ЮНЕСКО-ийн байгалийн өвд  
бүртгүүлж, байгалийн болон соёлын өвийн хосолмол бүс  
болгоно.

-“Жемчужина Алтай”

-“Их Торгоны Замын сэргэн мандал”

-“Каспийн үүд”

Дээр өгүүлсэн “Байгаль дэлхий болон нүүдлийн соёлын нэгдэл” үйл ажиллагааны зорилтын  
тухайд нүүдлийн соёлын онцлог, хэв шинжийг байгалийн үзэсгэлэнт газруудтай хослуулсан  
аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар өгүүлсэн байгааг харж байна. Өөрөөр хэлбэл Казахстан  
улсын Засгийн газраас уламжлалт нүүдлийн мал аж ахуй болон түүнтэй холбоотой соёлын  
элементүүдэд түшиглэсэн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн үйл  
ажиллагааг хэрэгжүүлж байгаа бөгөөд аялал жуулчлалын салбар дахь энэ туршлагыг  
Тибергиен болон Шиэ нар “neo-nomadic tourism culture” буюу “шинэ нүүдлийн аялал  
жуулчлалын соёл” (Tiberghien, Xie 2018) гэж үзсэн байна. Түүнчлэн тэдний үзсэнээр энэ  
төрлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх нь орон нутгийн хөгжилд эдийн засаг, дэд бүтцийн  
хувьд томоохон хөрөнгө оруулалт болох төдийгүй хот, тосгодод нүүдлийн соёлыг сэргээхэд

<sup>31</sup> "On the Concept of cultural policy of the Republic of Kazakhstan."

<https://adilet.zan.kz/eng/docs/U140000939>.

<sup>32</sup> Энэ талаар Ерөнхийлөгч Н.А.Назарбаевийн 2012 оны 12-р сарын 14-ний өдөр танилцуулсан  
“Казахстан 2050” стратегит туссаны дагуу хэрэгжүүлж эхэлсэн байна. “...Казахын соёлын хөгжилд  
шинэ түлхэц, эрч хүч өгөх хэрэгтэй байна. Соёлын талаар баримтлах бодлогын үзэл баримтлалыг  
урт хугацаагаар боловсруулах нь чухал. Үүнд казахчуудын өрсөлдөх чадвар бүхий соёлын  
кластерын хөгжилд чиглэгдсэн арга хэмжээг товлох шаардлага урган гарч байна...”

чухал нөлөөтэй (Tiberghien, Xie 2018: 7) гэсэнтэй миний бие санал нийлж байна. Үүнээс үзэхэд энэ төрлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нүүдлийн соёл гол хэрэгсэл нь болж өгч байгаа бөгөөд энэ нь эргээд өмнөх хэсэгт өгүүлсэн уламжлалаа сэргээх, ижилсэл бий болгох зэрэг бодлогуудын хэрэгжилтэд ч нөлөөлөх байдлаар эдгээр нь өөр хоорондоо харилцан уялдаж байгаа юм. Өөрөөр хэлбэл Казахстан улсын Засгийн Газраас нүүдлийн соёлын өвийг хадгалж хамгаалах, олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг эдийн засгийн үр өгөөжтэй байдлаар соёл төдийгүй аялал жуулчлалын салбартаа хэрэгжүүлж байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ: КИРГИЗТАН БА НҮҮДЛИЙН СОЁЛ

### **3.1. Нүүдэлчин киргизүүдийн аж ахуйн тухай: Уламжлалт соёл, Исламын шашин хоёрыг жинлэх нь**

Киргизстан улс 1995 онд “Олон улсын Манас жил” үйл ажиллагаанд ихээхэн хүчин чармайлт гаргаж зохион байгуулсан. ЮНЕСКО-ийн зүгээс энэ үйл явдлыг “Дэлхийн соёлын чухал үйл явдал боллоо” хэмээн үнэлсэн бөгөөд тус сүр дуулиантай ёслолын арга хэмжээний үеэр Ерөнхийлөгч Акаев дэлхийн анхны гурван давхар гэр /yurt/-ээс Манас баатрын яруу алдрыг алдаршуулж тунхаглав. Эверетт-Хит (2003) Киргизийн нүүдэлчдийн хэв маяг, уламжлалын тухай өгүүлэхдээ энэ арга хэмжээнд зориулж 8 сая ам.доллар зарцуулснаас үндэсний туульсыг сурталчил хад хэр их ач холбогдол өгч байгааг харж болно гэсэн байна (Everett-Heath 2003). Энэхүү “Олон улсын Манас жил”, мөн “Дэлхийн нүүдэлчдийн наадам” зэрэг арга хэмжээ нь өнөөгийн Киргизстанд нүүдэлчдийн соёлын өвийг хэрхэн хүндэтгэн дээдэлж буйн илрэл бөгөөд төрөөс үндэсний онцлогийг сурталчилж, сэргээн хөгжүүлэхийн зэрэгцээ аялал жуулчлал, эдийн засгийн салбарыг хөгжүүлэх нэн тэргүүний чиглэл болж байна.

Гэвч Киргизстан дахь нүүдлийн өв соёл, түүний өнөөгийн нийгэмд ямар үүрэг гүйцэтгэж буй талаар судалсан судлаачдын саналууд харилцан адилгүй байна. Тухайлбал, Анарбаев (2021) дараах байдлаар авч үзжээ. “Зөвлөлт нийгэмчлэлийн хамгийн том золиос нь нүүдэлчин ахуй байв. Киргиз дахь нүүдэлчдийн соёл, итгэл үнэмшлийн тогтолцоо нуран унаж, үндсэндээ хуурамч шинэ өвийн зохиомол нэгэн элемент болон хувирч, хүмүүсийн сэтгэл хөдлөл төдий болж үлдсэн байна. Нийгмийн дарамт шахалт ижилслийг өдөөгч бусад хүчин зүйлсэд бараг л нөлөөлөөгүй бөгөөд овог, аймаг, бүс нутгийн үзэл өнөө хэр хүчтэй хэвээр байна” (Anarbaev 2021).

Харин Турдумамбетовын өгүүлснээр “тус улсын уугуул хүн ам болох Киргизүүд нь устан үгүй болж буй нүүдэлчин ахуйн өвлөн уламжлагчид учраас жуулчдын сонирхлыг ихээхэн татдаг (Turdumambetov 2014; Vaas 1996). Зөвлөлт Холбоот Улс унаснаар Төв Азийн Бүгд найрамдах улсууд улс төрийн хувьд тусгаар тогтнож, нүүдлийн мал аж ахуй сэргэж эхэлсэн. 1990-ээд оноос хойш өрнөсөн эдийн засгийн хямралтай холбоотойгоор ажилгүйчүүд хөдөө тосгод дахь өрхийн аж ахуйдаа эргэн шингэж байсан нь нүүдэлчдийн аж ахуйн ач холбогдол өсөхөд нөлөөлсөн байна (Kradin 2002). Киргиз дэх нүүдлийн соёлын байр суурь Зөвлөлтөөс өмнөх үеийнхтэй харьцуулахад ихээхэн хумигдсан нь тодорхой хэдий ч нэг талаас ард түмний дунд эргэн сэргэж буй язгуур соёл, нөгөө талаас устан үгүй болж буй сэтгэл мэдрэмжийн хуурамч дүр зураг гэж үзэх үзлүүд хоорондоо зөрчилдөөнтэй байна.

Киргизстан улсын Соёлын тухай хууль (1992), Түүхэн өвийн хадгалалт, ашиглалтын тухай хууль (1999), Аялал жуулчлалын тухай хууль (1999), Уламжлалт мэдлэгийг хамгаалах

тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичгүүдээс харахад бодлогын хувьд соёлын өв болон аялал жуулчлалтай олон талаар холбогдсон байна (Kradin 2002). Тус улсын аялал жуулчлалын салбарыг Жениш (2017) хууль эрх зүйн зохицуулалтын хувьд “нэлээд уян хатан” боловч “хуучирсан/ зохих ёсоор хэрэгжээгүй” хэмээн тодорхойлж, 1999 онд батлагдсан Аялал жуулчлалын тухай хууль үеэ өнгөрөөсөн, мөн аялал жуулчлалын салбарын өөрчлөлт, шинэчлэлтэд зохицож хэрэгжихгүй байгаа талаар өгүүлсэн (Jenish 2017). Ямартай ч “Салбарын хууль эрх зүйн орчныг ардчилснаар ихээхэн ахиц дэвшил гарсан” бөгөөд “Киргиз улс нь байгаль, соёл, түүхийн аялал жуулчлалын асар их нөөцтэй” билээ (Jenish 2017; Turdumambetov 2014).

Бэлчээрийн мал аж ахуй нь Киргизстаны аялал жуулчлалын салбар дахь соёлын бүтээгдэхүүн болохоос гадна тус улсын эдийн засагт түүхэн чухал үүрэг гүйцэтгэжээ. Зөвлөлт Холбоот Улс задран унасны дараагаар улсын хөдөө аж ахуйн дэд бүтэц, байгууламжуудын дампуурал, зах зээлийн хомсдол, эдийн засаг дахь хөдөө аж ахуйн салбарын хувьчлал зэрэг хүчин зүйлсийн улмаас мал аж ахуйн салбар томоохон уналтад орж, малын тоо огцом буурсан байна. Гэсэн хэдий ч Киргизстан улсын эдийн засагт мал аж ахуй үнэмлэхүй байр суурь эзэлсээр байгаа төдийгүй хөдөө орон нутгийн иргэдийн орлогын гол эх үүсвэр хэвээр байна (Anarbaev 2021). Бэлчээрийн газар ашиглалтын тухайд баримталж буй тодорхой бодлого, тэдгээрийн соёлын үр нөлөөг дараах хэсэгт илүү дэлгэрэнгүй тайлбарласан болно.

-Газар ашиглалт, уламжлалт мэдлэгийн хадгалалт хамгаалалт

1990 онд Зөвлөлт Холбоот Улс задран унаснаар Киргизийн нийгэм дэх шашин, соёлын нөлөө төдийгүй газар ашиглалттай холбоотой ихээхэн өөрчлөлтийг дагуулжээ. Шинэ тутам тусгаар тогтносон Киргиз улс газар тариалангийн салбартаа томоохон шинэчлэл хийж, Зөвлөлтийн үеийн нэгдэл, улсын мэдэлд байсан газар, мал, тоног төхөөрөмж, машин механизмыг орон нутгийн ард иргэдэд хуваарилж тараасан байна<sup>33</sup>. Өнөөгийн Киргизстан улсын хөдөө орон нутагт амьдарч буй нийт ард иргэдийн гуравны хоёрынх нь эдийн засагт хөдөө аж ахуй чухал үүрэг гүйцэтгэх ба мал аж ахуй, газар тариалан, ан, ой, загасны аж ахуй нийлээд тус улсын ДНБ-ий бараг 14%-ийг, хөдөлмөр эрхлэлтийн 30 орчим хувийг бүрдүүлдэг байна (Anarbaev 2021). НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ)-аас Төв Азийн улсуудаас хамгийн анх Киргизстан улс газар өмчлөх тухай асуудлаар 1998 онд бүх нийтийн санал асуулгын үндсэн дээр Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулсан нь олон улсын тусламж авах, эдийн засаг, газрын шинэчлэл хийх нөхцөлийг бүрдүүлсэн хэмээн үзжээ (Craver 2016; Mathieu-Petric 2005; Gleason 1997). Уг бүх нийтийн санал асуулгын үр дүнд оруулсан Үндсэн Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр газар нь төрийн болон нутгийн захиргааны мэдэлд байхаас гадна хувь хүн өмчилж болох эрх зүйн нөхцөлийг илт тусгасан байна. Тухайлбал, “Газрыг... Киргиз улсын ард иргэдийн аж

<sup>33</sup> "FAO Country Programming Framework in Kyrgyz Republic 2015-2017." 29 Jan. 2015, <https://www.fao.org/3/a-au213e.pdf>.

амьдрал, үйл ажиллагааны эх үүсвэр болгон ашиглаж, төрийн зүгээс онцгойлон хамгаална... Газрыг хууль эрх зүйн хүрээнд хувийн, нутгийн захиргааны нэгжийн болон бусад хэлбэрээр өмчилж болно” хэмээн заасан байна (Younas 2017).

Киргизстан улсын нийт нутаг дэвсгэрийн 45%-ийг бэлчээр болгон ашиглах боломжтой (Ludi 2003) бөгөөд 1990-ээд оны сүүл үеэс эхлэн бэлчээр түрээслэх хууль эрх зүйн орчин бүрджээ. Гэвч шинээр бий болсон дээрх тогтолцоо нь малчдын хувьд бодит байдал дээр яг таг дагаж мөрдөхөд ихээхэн ярвигтай тул хэрэгжилт сул бөгөөд зарим талаар малчид төвөгшөөх нөхцөлийг бүрдүүлж байна (Kerven et al. 2011). Бэлчээр түрээслэх эрх зүйн орчныг илүү хялбаршуулах үүднээс Бэлчээрийн тухай хууль (2009)-ийг баталж, бэлчээрийг төрийн шууд удирдлага буюу төв, бүс, мужийн захиргаанаас шууд тосгоны түвшний мал аж ахуйн нийгэмлэгүүдэд шилжүүлэх боломжтой болов (Craver 2016). Түүнчлэн энэхүү хуулиар бэлчээрийг үндэсний эрдэнэ хэмээн зүйлчилж, хувийн өмч болгон авахыг хоригложээ. Эдгээр мал аж ахуйн нийгэмлэгүүд нь донор байгууллагуудын дэмжлэгтэйгээр анхан шатны сургалтад хамрагдсан ч тогтвортой бэлчээрийн менежмент, хяналт зэрэг асуудлууд байсаар байна<sup>34</sup> (Craver 2016).

Киргизийн Бүгд Найрамдах Улсын “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” (2011) хуулиар тусгай хамгаалалттай газар нутгийг аялал жуулчлалын салбарт ашиглах дүрэм, журмыг баталжээ. Тухайлбал, тусгай хамгаалалттай газар нутгийг экологийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох, түүний тогтвортой үйл ажиллагааг хангахад орон нутгийн иргэдийг татан оролцуулах, мөн тухайн нутгийн байгаль, түүх, соёлын дурсгалт газруудтай танилцах зорилгоор ашиглах боломжтой. ТХГН-т аялал жуулчлалын зориулалтаар эко аяллын маршрут гаргах, зам, зогсоол барих, тодорхой бүсэд тусгай объект, музей, задгай үзэсгэлэн байрлуулахыг зөвшөөрдөг байна. Тус улсад шим мандлын 1, улсын хамгаалалтын 10 бүс, байгалийн цогцолборт газар 10, нөөц газар 68 буюу нийт нутаг дэвсгэрийн 6 хувийг эзлэх хэд хэдэн тусгай хамгаалалттай газар нутаг байна (Beksultanova et al. 2021).

Одоогийн байдлаар Киргизстан дахь уугуул иргэд газар өмчлөх талаар тухайлсан хууль тогтоомж байхгүй байна. Тус улсын хүн амыг газар нутгаа оюун санааны төдийгүй түүхэн чухал ач холбогдолтой хэмээн үздэг олон угсаатны бүлэг, хэд хэдэн уугуул иргэд бүрдүүлдэг. Энэ талаар Юунас (2017) Киргиз улс хууль эрх зүйн системдээ эдгээр иргэдийн эрх ашгийг ч мөн авч үзэх шаардлагатай гэж үзжээ (Younas 2017).

Орчин үеийн Киргизстаны нийгэмд нүүдэл, нүүдлийн соёлыг ойлгож, хүлээж авах байдал хэтдээ ихээхэн буруу төлөвших хандлагатай байгаа гэж үзэж болно. Тухайлбал, өнгөрсөн, одоо аль ч үед “зан заншил”, “уламжлал”-д хэт найдаж, бодит нийгмийн харилцаа алдагдсанаар бэлчээр, газар ашиглалтын шинэчлэл бүтэлгүйтэж иржээ (Jacquesson 2010).

---

<sup>34</sup> "FAO Country Programming Framework in Kyrgyz Republic 2015-2017." 29 Jan. 2015, <https://www.fao.org/3/a-au213e.pdf>.



Ёс заншил, уламжлалд хэт их ач холбогдол өгөх явдал тус улсын нийгмийн өөр нэгэн тусгал болсон шашин шүтлэгийн орчинд ч мөн илэрдэг учраас нүүдэлчдийн соёлын үүргийг түүний хөгжилтэй харьцуулж авч үзэхэд ихээхэн дөхөм болдог байна.

-Шашны болон уламжлалт эрх зүйн тогтолцоо

Грегорий Глисоны өгүүлснээр “Исламын шашин бол Төв Азийн уугуул иргэдийн оюун санаа, зүрх сэтгэл, сэтгэлгээ” боловч тэр Исламын шашин нь түүний үзэж буйгаар “Улс төрийн бус соёлын Исламын шашин” аж (Gleason 1997). Глисоны энэ үзэл санааг Коннери (2000) шүүмжлэхдээ Төв Ази дахь Исламын шашны ярвигтай асуудлууд дундаас зөвхөн нэгээхэн хэсгийг нь авч үзсэн хэмээдэг байна (Connelly 2000). Жишээлбэл, Узбекистан дахь Исламын шашин бол аль эртний Самарканд, Бухарын соёлын үеэс эхтэй илүү эртний уламжлал болох бөгөөд узбекүүд суурьшмал голдуу байсан нь ислам шашинт ард түмнүүдтэй байнгын харилцаатай байх нөхцөлийг бүрдүүлсэн. Харин Киргизийн тухайд XIX зууныг хүртэл Исламын шашинд бүрэн ороогүй байв. 70 жилийн турш Зөвлөлтийн шашингүй үзлийн нөлөөгөөр Исламын шашныг итгэл үнэмшлийн бус соёлын уламжлал төдийд авч үзэж байсан хэдий ч ЗХУ унаснаар шинээр тусгаар тогтносон Төв Азийн улсуудын удирдагчид эргээд ижилсэл болоод хууль ёсны гол үндэс хэмээн хүлээн зөвшөөрсөн юм. Тиймээс Исламын шашныг хэдий нүүдлийн соёл, зан үйлтэй адилтгаж үздэггүй боловч түүнтэй энэ тэнцүү үндэсний ижилслийг өдөөгч өөр нэгэн чухал хүчин зүйл болгодог байна.

Киргизстан дахь Исламын шашныг нийгэм, соёл, улс төр, газарзүй зэрэг олон янзын хүчин зүйлс нөхцөлдүүлдэг тул нэлээд өргөн хүрээний бүтэцтэй. Үүний нэгэн жишээ нь 2004 онд батлагдсан “Аксакалын тухай хууль”-д үндэслэн Бишкект байгуулагдсан “Аксакал”-ын шүүх юм. Энэ төрлийн шүүхүүд нь өмнө нь ерөнхийлөгчийн тунхаг (1995)-аар хөдөө орон нутгуудад байгуулагдаж байжээ (Beyer 2007). Бэйер (2007, 2015), Акташ (2021) нар аксакалын шүүхийг уламжлалт соёлын зан зүйлийн хэлбэрийг орчин үеийн нөхцөлд нийцүүлсэн орон нутгийн шинжтэй хууль дүрэм, бодлого болох талаас нь авч үзсэн байна (Beyer 2007, 2015; Aktaş 2021). Ерөнхийлөгч Акаевын үндэстэн бүтээх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс аксакалын шүүхүүдийг дэмжсэн явдал нь орчин үеийн нөхцөлд тун тохиромжтой төдийгүй “Киргизийн ард түмний хувьд эцэг өвгөдтэйгөө нягт холбоотой байж, уламжлал, ёс заншлынхаа ач холбогдлыг ойлгоход дөхөм болгож байгаа аж” (Beyer 2015). Тэрээр улс төрийн өвөрмөц байдал, ижилслийг бий болгох үүднээс аксакалуудаар дамжуулан нийгэм, цаг үеийн тулгамдсан асуудлууд байгаа талаар олон нийтэд уриалж байв (Parkin 1996).

Хот суурин газрууд дахь энэ төрлийн шүүхүүд нь хөдөө орон нутгуудтай харьцуулахад орон нутгийн өөрөө удирдах засаглалд харьяалагддагаараа зохион байгуулалтын хувьд ялгаатай. Тухайлбал, Бишкек хот нь дотроо засаг захиргааны дөрвөн дэд дүүрэгтэй, тэдгээр нь тус тусын аксакалын шүүхтэй бөгөөд гишүүдийг нь тухайн

дүүргүүдээс гурван жилийн хугацаатай томилдог байна. Аксакал шүүх нь харьяалагдах дүүргийнхээ дэргэд байгуулагдсан нутгийн зөвлөлөөр дамжуулан үйл ажиллагаагаа дүүргийн шүүхэд тайлагнана. Харин *аксакал* цолын тухайд Киргизийн өмнөд нутгуудад өдий хэр цагаан сахалтай, хөгшин эрэгтэй хүн хэвээр байгаа бол, хойд нутгуудад киргиз ч биш эмэгтэй хүн байх тохиолдол цөөнгүй байна (Beyer 2007).

Хойд нутгуудад өөрсдийнхөө нийгмийг орчин үеийн, шашнаас ангид хэмээн тодорхойлж байгаа бол энэ тодорхойлолт нь өмнөд хэсэгт тохиромжгүй гэж хэлж болно. Коннери (2000)-ийн өгүүлснээр Киргизстаны өмнөд хэсэг нь “Зөвлөлт засгийн дор 70 жил замнахад харагдах байдлаасаа ч огт өөрчлөгдөөгүй, орчин үеийн аж үйлдвэржилт нэвтрээгүй” байна (Connery 2000). Энэ бүс нутгийн иргэдийн овгийн бүтцэд Исламын шашны уламжлал ч сайн нийцдэг байна. Ард иргэдийн дунд “Зөвлөлтийн үеэс гадна өөрчлөн байгуулагчдын үйл ажиллагааны дүнд амьдрал нь мэдэгдэхүйц ахиж дээшилсэн зүйлгүй тул улс төрчдөд итгэх итгэл огт байдаггүй” (Connery 2000). Орон нутгийн шашны тэргүүнүүд тосгоны болон гэр бүлийн асуудлуудаар барахгүй ард иргэдийн амьжиргаагаа залгуулах асуудалд ч хүртэл оролцоотой байдаг аж. Иймд “Шашин уламжлалт үзэлтнүүдийг өөрчлөн байгуулагчдын эсрэг, зах хязгаарыг төвтэй, умардыг өмнөдтэй эсрэгцүүлэн турхирч байна” хэмээн тэрээр дүгнэжээ. Тиймээс нийгэм, улс төр, газарзүйн асуудлаас үүдэн бүс нутгуудад үүсээд буй хурцадмал байдал нь үндэстний бодлого, нөөц бололцоо хязгаарлагдмал зэргээс шалтгаалж шашны хэт туйлшрал, улс хоорондын мөргөлдөөн, үндэстэн хоорондын зөрчилдөөн үүсэхэд хүргэсэн нь халуун сэдэв болоод байна.

### **3.2. Киргизстан дахь угсаатан хоорондын харилцаа ба нүүдлийн соёл**

Угсаатны бүлгүүд хоорондын харилцааны тухайд Казахстан, Киргизстан улсууд дахь нөхцөл байдал төстэй боловч дагуулах үр дагаврын хувьд харилцан адилгүй байна. 1989 онд Зөвлөлтийн Бүгд Найрамдах Киргизстан Улсын Засгийн газраас хэлний бодлого нэвтрүүлж, орос дарга, мэргэжилтнүүдийг туслах болон ажилтнуудтайгаа ойлголцох хэмжээний киргиз хэл сурахыг шаардаж эхэлсэн байна (Connery 2000). Тусгаар тогтносныхоо дараагаар Засгийн газрын зүгээс дээрх бодлогыг үргэлжлүүлэн, хэлний тухай хуулийг дэмжиж байсан боловч 2000 он хүртэл батлалгүй сунжруулжээ. Тухайн үед нөхцөл байдал хэвийн байсан боловч цаашид киргиз угсаатныг хэт сурталчилсан тогтолцоо бий болж шахагдах вий гэсэн айдастай нүүр тулсан олон тооны орос болон киргиз бус бусад угсаатнууд Киргизстаныг орхин нүүсэн байдаг. Тиймээс эдгээр өндөр боловсролтой, ур чадвар сайтай ажиллах хүчин нэн шаардлагатай байсан Киргизийн эдийн засагт тэдгээр орос мэргэжилтнүүд явснаар ихээхэн хохирол учирсан байна (Connery 2000). Энэ нь өмнө өгүүлсэн 1990-ээд оны үеийн Казахстан дахь хэлний бодлого, Казах төвт үндэстний бодлогыг орос болон бусад үндэстний цөөнхүүд хэрхэн санаа зовнин хүлээж авч байсан дүр зурагтай ихээхэн төсөөтэй юм.

Хэдий тийм ч угсаатнууд хоорондын харилцаа, эв найрамдалтай зэрэгцэн оршин тогтнох сайн загвар бүхий орчин нөхцөлийг бүрдүүлсэн Казахстанас ялгаатай нь Киргизстанд угсаатан хоорондын зөрчилтэй холбоотой хэд хэдэн үйл явдал болж өрнөжээ. Цөөнхийн Эрхийн Олон Улсын Бүлэг (Minority Rights Group International [MRGI])-ийн Киргизстан дахь угсаатны цөөнх, уугуул иргэдийн талаарх тайлан (2015)-д дурдсанаар 2010 оны 6-р сард тус улсын өмнөд хэсэгт өрнөсөн киргиз, узбек угсаатнууд хоорондын сөргөлдөөний дүнд олон зуун хүний амь үрэгдсэн үйл явдал нь Киргизстан улсын Засгийн Газраас угсаатнууд хоорондоо эв найрамдалтай зэрэгцэн орших нөхцөлийг бүрдүүлсэн үндэсний хэмжээний арга хэмжээ авах шаардлага нүүрлээд буйг хүлээн зөвшөөрч, анхаарал хандуулах цаг ирснийг харуулсан байна. Үндэсний эв нэгдэл, угсаатан хоорондын харилцааг хөгжүүлэх тухай үзэл баримтлал (2013) нь ард иргэдийн нийтлэг ижилслийг дэмжих, олон хэлний боловсролыг хөгжүүлж, нийт иргэдийн дунд албан ёсны киргиз хэлний мэдлэгийг дээшлүүлэхийн зэрэгцээ бусад хэлнүүдийг ч мөн дэмжиж, угсаатны цөөнхүүд ямар нэг ялгаварлан гадуурхалтаас ангид өөрсдийн хэл соёлыг хадгалж байхад чиглэжээ. Энэхүү үзэл баримтлалыг 2010 оноос хойш ард иргэдээс дэмжлэг авахын тулд угсаатны улс төр ашиглаж тоглолт хийдэг үндсэрхэг үзэлт улс төрчдийн эсрэг ерөнхийлөгчийн эвслийнхний авч хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээ хэмээн үздэг байна. Харин Ерөнхийлөгчийн Тамгын газрын Үндэстэн, шашны бодлого, иргэний нийгэмтэй харилцах хэлтэс, Үндэстэн хоорондын харилцааны газрууд нь орон нутагт зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгохоор ажиллаж байна. Цөөнхийн Эрхийн Олон Улсын Бүлэг [MRGI] (2015)-ээс бодлогын түвшинд ахиц дэвшил гарч байгаа ч хэрэгжилт сул байгаа бөгөөд угсаатан хоорондын харилцааны талаарх бодлого боловсруулалт төдийгүй төрийн алба, хууль сахиулах байгууллагуудад угсаатны цөөнхийн төлөөлөл хангалттай хэмжээнд байхгүй байна хэмээн үнэлж байгаа аж.

Киргиз, узбекүүдийн хооронд өрнөсөн угсаатан хоорондын зөрчилдөөн нь Киргизстаны өмнөд хэсэг дэх нөхцөл байдлыг цаашид улам төвөгтэй болгох хандлагатай байна. Узбекистаны хилийн ойролцоох Ош хотын хүн амын 44%-ийг узбек, 41%-ийг киргиз, үлдсэн 15%-ийг бусад угсаатнууд эзэлдэг боловч хотын захиргааны ажилтнуудын ердөө 10% нь л узбекүүд байдаг аж. 2010 оны хэрэг явдлаас хойш олон тооны узбек иргэд ажил мэргэжил, нийгмийн боломж бололцоогоо таатай хэвээр хадгалахын тулд өөрсдийгөө киргиз угсаатан гэсэн бичиг баримт авах болсон байна. Үүний зэрэгцээ Киргизстаны өмнөд нутгууд дахь узбек эзэдтэй жижиг бизнес, аж ахуйн нэгжүүд эрх баригчдын хэт их шалгалт, шахалттай тулж, түр зогсоох, цаашлаад бүр хаах тохиолдол ч гарах болжээ. Энэ байдал 2014 оны зунаас улам бүр газар авсныг Узбекистан улсын зүгээс Киргизстан улсын Ош хотоор дамжуулан авч, өмнөд хэсгийнхээ газны хэрэглээг хангадаг хийн хоолойг хаасантай холбож, олон улсын зөрчил, сөргөлдөөн угсаатны цөөнхүүдэд хэрхэн сөргөөр нөлөөлдөг болохыг харуулсан жишээ гэж үздэг байна (Connery 2000; Omelicheva 2010).

Киргизстан, Узбекистан улсуудын харилцаа, тэр дундаа нөөцийн олдцотой холбоотой асуудал дээр тийм ч сайнгүй байж ирсэн. Зөвлөлт Холбоот Улс задарснаас хойш

шинээр тусгаар тогтносон хоёр улс ус, эрчим хүчний хэрэгцээтэй холбоотойгоор зөрчилдөх болсон байна. Коннэри (2000)-ийн тодорхойлсноор “Киргизстан Узбекистаныг зайлшгүй шаардлагатай усны нөөцөөр хангадаг бол, Узбекистан нь Киргизстаны эрчим хүчний хэрэглээний эх үүсвэр болсон газраар хангадаг. Киргизстан улс жилдээ 50 тэрбум.м<sup>3</sup> усны нөөц цуглуулдаг ч түүнээс зөвхөн 12 тэрбум.м<sup>3</sup>-ийг л дотооддоо үлдээж ашигладаг байна. 1999 онд Киргизстанд маш бага хур тунадас орсны улмаас Узбекистан төдийгүй дотоодын хэрэгцээгээ хангах ч бололцоогүй болж байв. Үүний хариуд Узбекистаны зүгээс бүтэн өвлийн турш Киргизстан руу газ нийлүүлэлт хийлгүй зогсоосон. Түүний дараагийн зун нь Узбекистанд олон жилийн дундажтай харьцуулахад их хэмжээний хур тунадас орсон тул тэр жилдээ усны нөөцийн хувьд хамааралгүй болсноор Киргизстан руу газ нийлүүлэлгүй, Киргизстан улс дахин нэг хахир хатуу өвлийг газгүй, хүндхэн өнгөрөөжээ” (Connerу 2000).

Сүүлийн хэдэн арван жил угсаатны хурцадмал байдал үүссэн нь Төв Ази даяар шашны хэт даврагч урсгалууд орж ирсэнтэй холбоотой (Omelicheva 2010). Киргизийн Засгийн газраас эдгээр ярвигтай асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Ерөнхийлөгчийн “Төр, шашны нийгэмлэгүүдийн харилцааг зохицуулах тухай” (Connerу 2000) захирамжийн дагуу 1998 онд Шашны хэрэг эрхлэх комиссыг байгуулжээ. Тус байгууллагын үйл ажиллагааны нэгэн үндсэн чиглэл нь албан ёсны бүртгэлд хамрагдах шаардлагатай гэж үзсэн шашны байгууллагуудыг Хууль зүйн яаманд санал болгох явдал юм. Шашны байгууллагууд нь ТББ-уудтай адил нийгмийн байгууллын нэгэн хэлбэр тул Хууль зүйн яаманд бүртгэлтэй байх ёстой гэж үздэг байна. Тиймээс Шашны хэрэг эрхлэх комисс байгуулагдсанаар тэдгээр шашны байгууллагуудыг Хууль зүйн яаманд бүртгүүлэхээс өмнө тус байгууллагаас зөвшөөрөл авах ёстой болжээ. Одоогийн байдлаар нийт 33 шашны байгууллага Киргизстан улсын Хууль зүйн яаманд бүртгэлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Энэ талаар тус Комиссын дэд дарга “Засгийн газрын зүгээс шашнаас үүдэлтэй ямар нэгэн хүчирхийлэл үүсэх нөхцөлөөс урьдчилан сэргийлэхээр ажиллаж байна” хэмээн дурдсан (Connerу 2000). Шашны хэрэг эрхлэх комисс байгуулагдсан 1998 онд Киргизстан, Казахстан, Узбекистан улсууд шашны хэт даврагч үзэлтэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны тухай хэлэлцээрт гарын үсэг зурж баталжээ.

Эдгээрийг нэгтгэн дүгнэвээс, Киргизийн Бүгд Найрамдах Улсын үндэсний бодлогод нүүдлийн мал аж ахуй нь соёлын дүр төрхийг илэрхийлэх, орон нутгийн иргэдийн амьжиргаа, газар ашиглалт зэрэгт илт туссан байх авч түүнээс илүүтэй Исламын шашин, түүний нийгэм- улс төрийн үүргийн тухайд баримталж буй бодлого анхаарлын төвд байна. Тиймээс тус улсын тухайд шашин, нүүдлийн соёл хоёрыг тус тусад нь авч үзэх ёстой асуудал гэхээсээ илүүтэй төрийн зүгээс уламжлал, ёс заншилдаа хэр хэмжээний ач холбогдол өгч, тэдгээр нь хоорондоо хэрхэн харилцан уялдаж буй талаас нь тайлбарлах нь илүү оновчтой байна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ОХУ БА НҮҮДЛИЙН СОЁЛ

### 4.1. Алс Дорнодын жижиг үндэстнүүдийн соёл

Хүн амын үндсэн голлох хэсгийг нь түүхэн нүүдэлчин угсаатнууд бүрдүүлдэг Казахстан, Киргизстан улсуудтай харьцуулахад Оросын Холбооны Улс дахь нүүдлийн соёлын тухайд баримтлах төрийн бодлогыг уугуул буюу цөөнх бүлгүүдтэй хамааруулж авч үзэх шаардлагатай. Тус цөөнх Уугуул бүлгүүд нь ненец, эвэнк, хант, сами, чукча болон бусад бүлгүүд болох бол арай томхон коми, саха, буриадууд адил ангилалд хамаардаггүй байна (Diatchkova 2001; Sidorova 2019; Bougdaeva&Isaacs 2018). Цааны аж ахуй, ан агнуур, загасны аж ахуй эрхлэх байдал, мөн газарзүйн тодорхой бүсүүдэд аж төрөх бүлгүүд Уугуул иргэдийн үндсэн хэсгүүдийг бүрдүүлдэг ажээ (Fondahl et al. 2020).

Диачкова (2001) эдгээр Уугуул иргэдийн нөхцөлийг “улсын дундажтай харьцуулахад амьжиргааны түвшин доогуур, уугуул хэл нь мөхөхөд хүрсэн, олон угсаатнууд устаж мөхөж байгаа”-тай холбоотойгоор тун эгзэгтэй байна гэж үзсэн. Нэгэн цагт Оросын төр байгуулагдаж ахуйд эдгээр Уугуул иргэд Хаант Орос, дараа нь Зөвлөлтөд нэгдсэн билээ. Эдгээр угсаатны бүлгүүд түүхийн явцад янз янзын үр дагавар бүхий олон засаглалын нүүрийг үзэж, угсаатныг тодорхойлох, амьжиргаа залгуулах, улс төрийн оролцооны цогц тогтолцоог бүрэлдүүлэхэд өөр өөрсдийн хувь нэмрээ оруулжээ (Diatchkova 2001). Сидорова (2019) “Орос дахь Уугуул бүлгүүдийг хууль ёсны дагуу Уугуул гэж тодорхойлоход тухайн бүлгийн мөхөж устахад хэр ойрхон байгаа гэхээсээ илүүтэй суурьшмал иргэдтэй хэдий хэмжээний харилцаатай байгааг гол шалгуур болгон авч үздэг” гэжээ (Sidorova 2019; Slezkine 1994; Øverland 2009; Laruelle 2014).

Холбооны түвшний болоод бүсийн засаг захиргааны ихэнх байгууллагуудад Уугуул иргэдийн зохицуулах тусдаа байгууллага огт байдаггүй байна (Diatchkova 2001; Arakchaa&Sumina 1999). Ямартай ч Уугуул иргэдтэй холбоотой асуудалд 20 гаруй яамны газар, хороод оролцдог. Холбооны Зөвлөлөөс “Оросын Холбооны Улс дахь жижиг үндэстнүүдийн эрхийг хангах тухай” (1999), “Оросын Холбооны Улсын Умард нутгууд, Сибирь, Алс Дорнод дахь жижиг үндэстнүүдийн нийгэмлэгүүдийн зохион байгуулалтын үндсэн үзэл баримтлалын тухай” (2000) гэсэн хуулиудыг баталсан. Тус хуулиудыг алдаа дутагдалтай хэдий ч энэ төрлийн байгууллагын эрх зүйн суурь хангалттай болохуйц хэмээн мэргэжилтнүүд үздэг. Арктикийн Зөвлөл, Умард, Сибирь, Алс Дорнодын уугуул иргэдийн холбоо (RAIPON) зэрэг байгууллагууд дор дурдах олон тооны жижиг холбоодыг нэгтгэж, дотоодын болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх үүд хаалгыг нээжээ.

-Уугуул иргэдийн талцал

1980-аад оны сүүлээс **Перестройкийн** үеэс эхлэн Уугуул иргэд, тэднийг тодорхойлохтой холбоотой шинэ хандлага судлаач, идэвхтнүүдийн дунд гарч эхэлснээр Орос даяар Уугуул иргэдийн тухай их ярих болжээ. 1989 онд Ненецийн уугуул иргэдийн нийгэмлэг Ясавей байгуулагдав (Tysiachniouk et al. 2020). Түүний дараагаар 1990 онд Умард, Сибирь, Алс Дорнодын уугуул иргэдийн холбоо (RAIPON) байгуулагдаж, 1993 онд Оросын Холбооны Улсын буюу “Бүх Оросын холбоо” болж бүртгэгдсэн байна<sup>35</sup> (Sidorova 2019; Tysiachniouk et al. 2020). Тэр үеэс эхлэн Умард Сибирь Алс Дорнодын Холбоо нь Арктикийн Зөвлөлийн байнгын гишүүн, НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлд зөвлөх статустай оролцох болов. Тус байгууллага нь өнөө Оросын засгийн газартай ихээхэн хамтын ажиллагаатай үйл ажиллагаа явуулдаг. 2010 онд цааны аж ахуйг уламжлалт эдийн засаг болох талаас нь хадгалж хамгаалах зорилготой Цаатан иргэдийн холбоо (NAO Reindeer Herders' Union) нэртэй бас нэг уугуул иргэдийн холбоо байгуулагдав. Орос төдийгүй олон улсын цаатан иргэдийн нийгэмлэг, холбоодтой хамтын ажиллагаатай тус холбоо нь цаатан иргэдийн эдийн засгийн асуудалд зөвлөгөө өгөх, албан ёсны бичиг баримттай болоход тусламж дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг байна (Tysiachniouk et al. 2020; Osherenko 2001).

УСАДХ-ны бүрэлдэхүүнд зөвхөн хуулиар тогтоогдсон жижиг Уугуул бүлгүүд буюу 50,000 орчим хүн л багтдаг. Холбооны хуулийн дагуу Оросын Холбооны Улсын Засгийн газраас тогтоосон Уугуул бүлгүүдийн жагсаалтыг баримталдаг ажээ. Засгийн газраас 50,000-аас доош хүн амтай бүлгийг л Уугуул хэмээн тодорхойлдог эрх зүйн зохицуулалттай холбоотойгоор тус улсын Алс Умард дахь хүн ам олонтой бүлгүүд энэ ангилалд хамаарахгүй байдаг зэргээр олон улсын түвшинд ихээхэн маргаан дагуулсаар ирсэн. Хүн амын тоогоор ангилахаас гадна Орос улсын хувьд тодорхой угсаатны бүлгийг албан ёсоор Уугуул иргэдийн ангилалд хамааруулж тодорхойлохдоо амьдралын хэв маяг, аж ахуй, угсаатны шинжийг нь мөн шалгуур болгон авч үздэг.

Түүхээс харахад анх XIX зууны үеэс эхлэн Сибирийн нүүдэлчдийн статусыг тодорхойлж эхэлжээ (Sidorova 2019). Харь үндэстнүүдийн тухай тунхагт (Sidorova, 2019; Slocum 1998) харь үндэстнүүдийг суурьшмал, нүүдэлчин, тэнүүлчин гэж гурав ангилсан байдаг. Суурьшмал харь үндэстнүүдийг үндсэн хүн амын адил “иргэншсэн” хэмээн үздэг байсан тул эдлэх эрх, биелүүлэх үүрэг, төлөх татварын хэмжээ зэрэг нь адил байв. Түүнчлэн тус Захирамжийн дагуу нүүдэлчид ангийн арьс үсний алба (йасак) барихаас гадна орон нутгийн татвар төлдөг байсан бол, тэнүүлчин харь үндэстнүүд зөвхөн орон нутгийн татвар төлдөг байжээ. Нүүдэлчин, тэнүүлчин харь үндэстнүүдийн уламжлалт овгийн зохион байгуулалт нь төрийн захиргааны нэгэн шинэ хэлбэр болж орж иржээ (Slocum 1998).

Тус Захирамж нь харь үндэстнүүдийг тодорхойлохдоо зөвхөн хэдий хэр хэмжээнд суурьшмал байгааг харгалзахаар заасан боловч бодит байдал дээр хэл, шашин, мөн

---

<sup>35</sup> "Indigenous World 2019: Russia - IWGIA - International Work Group ...." 24 Apr. 2019, <https://www.iwgia.org/en/russia/3369-iw2019-russia?highlight=WyJuZW5ldHMlXQ==>.

угсаатны хувьд олонхтой хэр ойр байгааг харгалздаг байжээ. Энэхүү өргөн хүрээний тодорхойлолт нь Хаант Орос улсын доторх уугуул иргэдийн тухай асуудлыг хөндөх үндэс суурь нь болдог. Уг тогтоолд хагас уугуул иргэдийг орос бус угсаатны ангилалд оруулсан байна (Sidorova 2019). Энэ талаар Слокум (1998) хэл, шашин, угсаатны хувьд славян бус хүмүүс улс төрийн байгууллагын хувьд гаднын элементэд тооцогддог байв гэжээ (Slocum 1998).

Цаг хугацааг ухрааж харвал одоогийн Оросын Холбооны Улс нь Зөвлөлт Холбоот Улсын үеийн үндэстэн хоорондын шатлан захирах ёс болох томоохон үндэстнүүд нь төр улсаа байгуулах эрхтэй, харин жижиг угсаатнууд нь ястанд тооцогдож, адил хэмжээний эрх ямба эдлэх боломжгүй тогтолцоог давуулан хэрэгжүүлж байна. Энэ тухай Сидорова (2019)-ийн бичсэнээр тус тусын үндэстний Бүгд найрамдах улстай гучин гурван үндэстэн байгаа бол цаана нь 63 угсаатан нь тодорхой автономит улсгүй, бусад засаг захиргааны нэгжүүдэд аж төрж байна хэмээн бичжээ (Sidorova 2019; Slezkine 1994).

Цаашлаад Зөвлөлт засгийн үеийн эрх зүйн зохицуулалт нь “ ‘хоцрогдмол’ хойд нутгийн бүлгүүдийг коммунизмд хүрэх замаа олоход нь тусалж дэмжих зорилготой” байв (Slezkine 1994). Тиймээс Зөвлөлтийн үед ч тэр, одоогийн Оросын Холбооны Улсын Засгийн газар тэдгээр жижиг угсаатнуудыг устаж, мөхөхөөс аврах гэсэн үзэл санааг ухуулж байсан хэдий ч тэдний газар нутгийг колоничлосноо хэзээ ч албан ёсоор хүлээн зөвшөөрч байсангүй. Оросууд тэдгээр иргэдийг уугуул хэмээн үздэггүй, албан ёсоор тодорхойлогдгүй байсан тул Зөвлөлт/Оросын уугуул иргэдэд өгсөн автономи нь Зөвлөлт засаг, түүний үзэл суртлын бүтээгдэхүүн байсан буюу уугуул иргэд өөрсдөө тодорхой газар нутаг эзэмшиж авах хүсэл эрмэлзлийн үр дүн биш байв (Sidorova 2019; Øverland 2009).

Колтхард (2014) Уугуул иргэд болон төр хоорондын харилцааг засаглалын тогтолцоо тодорхойлдог гэж үзсэн байна. Уугуул иргэдийн өөрсдийн дуу хоолой улс төр, эрх зүйн засаглалын тогтолцоонд огт хүрдэггүй тул тэдний эрхийн тухай асуудлыг засгийн эрхэн дэх шийдвэр гаргагчид өөрсдийнхөөрөө тодорхойлох эрх мэдэлтэй байдаг. Түүнчлэн Уугуул иргэд гэж хэнийг, хэрхэн тодорхойлох тухай асуудал ч төрийн эрх мэдлийн хүрээнд шийдэгддэг (Sidorova 2019; Coulthard 2014) ажээ. Улс төр, эрх зүйн үүднээсээ тодорхой бүлгийг тухайн улсын засгийн газраас уугуул иргэд хэмээн тодорхойлдог тул хэнийг Уугуул иргэд гэж тодорхойлох нь засгийн газрын эрх байдаг аж. Умард Америкаас ялгаатай нь Оросын засгийн газар Уугуул иргэдийг Засгийн газраар хамгаалуулах шаардлагатай жижиг үндэстнүүд хэмээн үздэг (Pika 1999). Цөөн бус тоот уугуул иргэдийн хувьд “үндэстний цөөнх” орос бус угсаатнууд хэмээн тодорхойлогддог аж (Laguette 2014).

Оросын Холбооны Улсын Засгийн газраас хэд хэдэн хууль тогтоомжоор Уугуул иргэдийн амьдрах орчин, уламжлалт амьдралын хэв маягийн аль алиныг нь зохицуулж, хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлсэн төдийгүй Уугуул иргэдийн эрхтэй холбоотой гол гол хууль, дүрмүүдэд ч үүнийг тусгасан байдаг. Энэ нь Сибирийн Арктик дахь Уугуул

иргэдийн эрх зүйн статусыг бий болгоход чухал нөлөө үзүүлжээ (Koptseva 2014; Luzan 2011).

Амьтны ертөнцийн тухай (1995) хуулиар Уугуул иргэдэд амьжиргааны зорилгоор ан гөрөө хийх, нутаг дэвсгэрээ сонгох, хэзээ хаана, хэдий хэмжээний ан амьтан агнах тал дээр давуу эрх олгосон байдаг (Todyshev 2013). Түүнчлэн Уугуул иргэд Ойн тухай (2006) хуулийн хүрээнд хувийн болон ахуйн хэрэглээндээ ойгоос мод бэлтгэж, амьжиргаандаа ашиглах эрхтэй. Оросын Татварын тухай (2009) хуулиар Уугуул иргэдийг орлогын татвар, ялангуяа ‘уламжлалт аж ахуй’ (Todyshev 2013)-н хүрээнд тодорхой нутаг дэвсгэрт ан гөрөө хийх, байгалийн ургамал түүх зэрэг татвараас чөлөөлөгдөг. Түүнчлэн Уугуул иргэдийн нийгэмлэг, аж ахуйн нэгжүүд татварын хөнгөлөлт эдлэх боломжтой. Оросын Тэтгэврийн тухай (2001) хуульд Уугуул иргэдийн тэтгэвэр тогтоолгох насыг эрт тогтоох төдийгүй нийгмийн тэтгэмж олгохоор тогтоосон байдаг.

Уугуул иргэд, ялангуяа умардын Уугуул иргэдийн эрхийн тухай “Баталгаа... тухай” (1999) хууль (Fondahl et al. 2020; Pensii 2018; Todyshev 2013) тэргүүтэй Холбооны хуулиудыг баталсан. 2000 оны хуулиар хойд нутгийн уугуул иргэдийн гишүүд уламжлалт ахуйгаа эрхлэх зорилгоор “овгийн бүлгэм”-ийг байгуулж, газар (арав, хэдэн зуун мянган га) эзэмших эрхийг олж авчээ. 2001 оны хуулиар “Уламжлалт байгаль ашиглалтын нутаг дэвсгэр”-ийг бий болгох боломж бүрдсэнээр хойд нутгийн уугуул иргэд орон нутгийнхаа засаг захиргаанд өвөг дээдсийнхээ газар нутагт хууль ёсны дагуу уламжлалт ахуйгаа эрхэлж амьдрах тухай өргөдөл гаргах боломжтой болжээ. Иймэрхүү нутаг дэвсгэрийг зөвхөн уугуул иргэдийн байгуулсан овгийн бүлгүүд хүсэлт гарган албажуулж, тэргүүлэх боломжтой байна.

Фондал нар (2020) Уугуул иргэдийн эрх, ямбатай холбоотой эдгээр хууль дүрмүүд сүүлийн хорин жилийн хугацаанд хуучирсан (Fondahl et al. 2020; Balzer 2016; Murashko & Rohr 2019) хэдий ч, Уугуул иргэдийн хувьд энэ бүлэгт хамаарагдаж буй эрх зүйн хүрээн дэх давуу талаа сайн ашиглаж байгаа бөгөөд энэ тухайд нэлээд эерэг хандлагатай байдаг талаар өгүүлжээ (Ktjajkov 2010). Харин “Өөрчлөлт оруулах тухай” хууль (2020) батлагдсанаар уугуул иргэдийг албан ёсоор бүртгэлжүүлэх тухай асуудал яригдаж эхлэв (Fondahl et al. 2020). Тус хуульд ийм маягаар бүртгэлжүүлэх асуудлыг 2 жилийн хугацаанд албажуулахаар тусгажээ.

Тус хуулийг батлахаас өмнөх хэд хэдэн төслийг Оросын умард нутаг даяар оршин суух Уугуул иргэдийн холбоодтой хэлэлцэж, санал авахад тэд ихээхэн сөрөг хандлагатай хүлээж авсан төдийгүй хэд хэдэн агуулгыг шууд эсэргүүцсэн байна. Түүнчлэн энэ хуулийн агуулгын тухайд Оросын Холбооны парламентын түвшинд хэлэлцсэний дүнд хэд хэдэн санал, сайжруулалтыг нэмж оруулахаар болжээ. Тус хуулиар Уугуул иргэдийн нөхцөлийг дордуулах ёсгүй гэсэн саналууд ч байв (Sovershenstvovanie 2018). Фондал нар (2020) авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайн оноож тодорхойлсон боловч түүнээс бусад олон асуудлыг



шийдвэрлэх арга замуудыг ахин тодорхойлох шаардлагатай хэмээн үзжээ (Fondahl et al. 2020).

#### **4.2. Орос дахь нүүдлийн соёл: Уугуул иргэдийн амьжиргаа**

1990-ээд оны сүүл, 2000-аад оны эхээр Оросын засгийн газраас дэлхий нийтийн жишгээр Уугуул иргэдийн уламжлалт аж ахуй, амьдралын хэв маягийг хадгалж хамгаалах чиглэлээр хэд хэдэн чухал хуулийг баталсан. Тухайлбал, Үндсэн хууль (1993)-аар Уугуул иргэдийн газар, баялаг эзэмших эрхийг баталгаажуулжээ. 1999 онд ОХУ-ын Засгийн газраас Оросын Холбооны Улс дахь цөөн тоот уугуул иргэдийн эрхийг хамгаалах тухай холбооны хуулийг батлав. Эдгээрээс гадна Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1991), Үндэсний соёлын бие даасан байдлын тухай Холбооны хууль (1996), Хойд, Сибирь, Алс Дорнодын уугуул иргэдийн нийгэмлэгүүдийн ерөнхий зарчмын тухай Холбооны хууль (2000), Газрын тухай хууль (2001) зэрэг холбоотой бусад хуулиудыг дурдаж болно (Kryazhkov 1996; Murashko 2005; Xanthaki, 2004).

Эдгээр хуулиуд батлагдсанаар Уугуул иргэдийн уламжлалт аж ахуйгаа эрхлэх зорилгоор газар ашиглах, түүнд нүүрлэх аюул заналаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин бүрджээ. ОХУ-ын холбооны тогтолцооны дэд засгийн газрууд бүгд эдгээр хуулиудыг эх болгон тус тусын хуулиудыг боловсруулж баталсан байдаг (Tysiachniouk et al. 2020). Оросын ардчиллын оргил үе хэмээн үздэг 1990-ээд оны сүүл, 2000-аад оны эхээр батлагдсан дээрх хууль тогтоомжууд нь Оросын засгийн газраас Уугуул иргэдийн тухай баримталж байсан дэлхий нийтийн үзэл баримтлал, жишигтэй нийцүүлсний үр дүн хэмээн үзэж болно. Харин түүнээс хойш тус улсын төрөөс Гаднын агентлагуудын тухай хууль (2012)-ийн дагуу Уугуул иргэдийн нийгэмлэг, холбоод зэрэг гадаад улсуудаас санхүүжилт авсан төрийн бус байгууллагуудыг идэвхтэй дарангуйлж эхэлжээ (Tysiachniouk et al. 2020).

1990-ээд оны сүүлээс Хойд, Сибирь, Алс Дорнод дахь цөөн тоот хүн амын эрхийн тухай голлох хууль тогтоомжууд батлагдсан хэдий ч тэдгээрийг хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичгүүд дутмаг байжээ (Murashko 2005). 2009 онд хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглах газрын нөхөн төлбөрийг тооцох аргачлалыг баталсан. Ингэснээр нөхөн олговрын ил тод дүрэм журам бүхий зохицуулах нөхцөлийг бүрдүүлсэн төдийгүй хувийн гэрээ, албан бус харилцааны ач холбогдлыг бууруулж, аль аль талдаа илүү найдвартай болсон байна.

Өмнө нь нөхөн олговрыг газрын тосны компаниуд, цаатан иргэд хоорондоо харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтоодог байсан бөгөөд ингэхдээ цаатан иргэдийн туршлага, ур чадвараас ихээхэн хамаардаг байв. Харин улсаас тогтоох аргачлалаар цаатан иргэд өмнөх үеийнхтэй харьцуулахад харьцангуй өндөр хэмжээний нөхөн олговрыг газрын тосны компаниудаас авах болжээ. Түүнчлэн компаниуд цаатан иргэдээс нэмэлт хүсэлт, аливаа шаардлага тавих нөхцөлийг хаасан байдаг. Цаатан иргэдийн компаниудаас хүлээж авсан нөхөн олговрын нэлээд хэсэг нь тэдний физик дэд бүтцэд зарцуулагдсан тул цаан аж

ахуй эрхлэгч иргэд харьцангуй бие даасан байдалтай болоход нэлээд нөлөөлсөн байна. Газрын тосны компаниуд болон Уугуул иргэд хоорондын харилцаанд гарсан энэхүү өөрчлөлт нь үр ашгийг хуваах горимыг патернализмаас CCSR руу шилжүүлэх, мөн цааны аж ахуйг бүхэлд нь тогтвортой байлгахад хувь нэмэр оруулсан (Tysiachniouk et al. 2020).

2013-2015 оны хооронд улс даяар татвар бууруулсны зэрэгцээ малчин, цаатан иргэд харьцангуй бие даасан шинжтэй болж ирсэнтэй холбоотойгоор хүчний харьцаанд өөрчлөлт орсон байна. Цаатан иргэдтэй хийсэн ярилцлагуудаас харахад төр засгаас хэт их хамааралтай байхаас илүүтэй өөрөө өөрсдөдөө найдах нь зүйтэй хэмээн олон хүн хариулсан байна (Tysiachniouk et al. 2020). 2017 оноос хойш эдийн засгийн нөхцөл сайжирч, татварын хэмжээ хэвэндээ байж ирснээр орон нутгийн удирдлагууд цаатан иргэдийн санал хүсэлтийг илүүтэй сонсдог болжээ. Үр дүнд нь Уугуул иргэд нэлээд эрх мэдэлтэй бөгөөд албан ёсны хууль тогтоомж, дүрэм журмуудыг биелүүлэх тал дээр ихээхэн туршлагатай болжээ. Мал аж ахуйн нэгжүүд бэлчээр ашиглалттай холбоотой эрх нь зөрчигдсөн тохиолдолд шүүхэд хандахаа мэддэг болсон. Энэ мэт цаа бугатай холбоотой асуудлаар зөвхөн газрын тосны компаниудын эсрэг бус бусад үйлдвэр, төрийн эсрэг зарга үүсгэж байгаа нь анхаарал татаж байна. Бүр цаашлаад, цаатан иргэд орчин үеийн техник технологийн тусламжтайгаар бэлчээрийн газартаа хяналт шинжилгээ хийдэг болсон байна. Хүчний харьцаа өөрчлөгдөж, Уугуул иргэдийн илүү идэвхтэй болж буй нь патернализмаас CCSR загвар руу шилжихэд чухал ач холбогдолтой байв (Tysiachniouk et al. 2020).

Цаатан уугуул иргэдийн хувьд 1990-2012 хүртэл компаниудаас санхүүгийн дэмжлэг авах гол хэрэгсэл нь нийгэм, эдийн засгийн гэрээнүүд байв. 2012 оноос хойш цаа бугын бэлчээрийг газрын тос, дэд бүтцийн зориулалтаар ашигласан тохиолдолд цаатан иргэдэд нөхөн олговор олгох ажлыг албан ёсоор баталгаажуулжээ. Алдагдал, хохирлоо нөхөн төлүүлж эхэлснээр цаатан иргэд ч өөрсдийн аж ахуй, амьжиргаандаа чухал хэрэгтэй багаж, тоног төхөөрөмжийг авах болсон тул цааны аж ахуйг эдийн засгийн хувьд үр ашигтай, хөдөө аж ахуйн нэгэн чухал салбар болгон хөгжүүлэх боломж нээгджээ (Tysiachniouk et al. 2020). Эдийн засгийн тогтвортой байдал ч цаатан иргэдийг эрх баригчид болон компаниудаас хараат бус, харьцангуй бие даасан байдалтай болоход ч нөлөөлж байна. “Цаатан иргэд одоо хөлөө олсон тул аливаа тусламж дэмжлэг шаардлагагүй. Тэд өөрсдөө ч өөрсдөдөө л найддаг” гэснийг ч нэгэн цаатан иргэн санал нийлж, “Бид одоо хөлөө олсон. Цааны маань ч тоо толгой өслөө (Tysiachniouk et al. 2020). Цааны аж ахуй эрхлэгчид бие даан цаагаа маллаж чадна” гэжээ. Цаашлаад цаатан иргэд хувийн нисдэг тэргээрээ газрын тос гарсан газрын байршлыг тогтоож, мэдэгдэх байдлаар компаниудын үйл ажиллагааг хянах болжээ. Түүнчлэн өмнөх гэрээнүүдийн хэрэгжилтийн хүрээнд компаниудын гаргаж байсан зөрчлүүдийг ч олж илрүүлсэн байна (Kvale 2007; Tysiachniouk et al. 2020). Энэ мэтчилэн Уугуул иргэд компаниудаас хамаарал багатай болж, харьцангуй биеэ даасан шинжтэй болж байна.

Нүүдэлчин ахуй нь Оросын төрийн үндсэн ижилслийг бүрдүүлдэггүй хэдий ч тус улсад нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг олон тооны уугуул иргэд байдаг. Төрөөс эдгээр бүлгүүдийн тухайд хэрэгжүүлж буй бодлого нь өргөн цар хүрээтэй боловч Уугуул иргэдийн хүлээн зөвшөөрөгдөх байдал, газар ашиглалт, амьжиргаа, нийт оршин тогтнох асуудалд төрөөс үзүүлж буй томоохон оролцоог тусгаж өгсөн нь сүүлийн хоёр

## ТАВДУГААР БҮЛЭГ: ТУРК БА НҮҮДЛИЙН СОЁЛ

### 5.1. Төв Азиас ирсэн нүүдэл ба өнөөгийн цөөнхийн соёл

Өтөр (2009)-ийн өгүүлсэнчлэн туркүүдийн оюун санаа, дурсамжид “нүүдэлчин амьдрал юугаар ч орлуулшгүй утга учиртай” ажээ. Үүнийг дагаад “бэлчээрийн мал аж ахуйн амьдралын хэв маяг, түүний утга учир нь малчид, мал ахуйн амьдралын гол эх үүсвэр болсон бэлчээр юм”. Туркүүдийн дунд уламжлагдаж ирсэн олон зан үйл нь нүүдэлчин ахуйн энгийн үйл ажиллагаанд суурилж хөгжсөн байх ба тэдгээр нь дараа дараачийн туркүүдийн үест улам бүр утга төгөлдөржиж иржээ (Türkan 2008; Öter 2009).

Курд нүүдэлчдийн талаар хийгдсэн судалгаанд (Thevenin 2011) үндэслэн Туркийн зүүн өмнөд нутаг дахь бэлчээрийн мал аж ахуйг тосгонд төвлөсөн суурин бэлчээрийн мал аж ахуй, босоо болон хэвтээ нүүдэлтэй бэлчээрийн мал аж ахуй гэсэн хоёр хэлбэрт хуваан авч үзэх боломжтой. Энэ хоёроос гадна орон нутгийн шинжтэй, бүс нутагтаа эсвэл бүс нутаг хооронд, зарим тохиолдолд давхар нүүдэллэдэг отрын хэлбэр байж болох юм. Энэ хэлбэрийн нүүдэлчдийн онцлог нь улирлаас хамааран гэр бүлийн зарим гишүүд нь нүүдэллэж явдаг байна. Эдгээр хагас нүүдэлчдийн хувьд эх нутагтайгаа салшгүй холбоо хамааралтай хэдий ч жилийн дөрвөн улирал даган байнгын нутаг сэлгэн нүүдэллэж, гэрт амьдардаг нүүдэлчдээс ялгаатай нь байнгын амьдрах зориулалттай байшиндаа тосгонд өвөлждөг. Тэдний талаар судлах шаардлагатайг Тиевнин (2011) дурдсан байна. Харин Анатолий дахь бэлчээрийн мал аж ахуйн олон талт байдлыг Фродин (1944), Ялчин (1986) нар аль эрт судалжээ (Frödin 1944; Yalçın 1986). Курдүүдын тухайд Фродиний ангиллаар Анатолийн зүүн хойд хэсэгт тэрүүхэн тэндээ босоо, хөндлөн гулд оторлож нүүдэллэдэг нэг хэсэг овгууд, зүүн өмнөд хэсэгт холын зайнд нүүдэллэдэг нөгөө хэсэг овгууд байдаг аж (Thevenin 2011).

Курдүүдээс гадна бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг туркмен нүүдэлчид болох йөрүкүүд нь “Туркийн хамгийн эртний оршин суугчдын нэг” юм. Сальзман (1983)-ы Бейтс (1973)-аас эшилснээр тэд “одоо амьдарч буй газраа албан ёсоор эзэмших боломжтой. Яагаад гэвэл Төв Засгийн газраас хэт их хөдөлгөөнтэй хэмээн үзэж байсан өмнөх оршин суугчид болох туркменүүдийг суурьшуулах үүрэг хүлээсэн байна. Үр дүнд нь бүхий л байгууллага, уламжлалт улс төрийн удирдагчдаа алдсан йөрүкүүд Засгийн Газраас дэмжиж байсан нутгийн тариачдын ашиг сонирхолд нийцүүлж, дасан зохицох шаардлагатай болсон” (Thevenin 2011; Bates 2020; Salzman 1983). Йөрүкүүдийн дундаас ялангуяа Сарикэчилүүд сүүлийн жилүүдэд Туркийн улс төрчид, хэвлэл мэдээллийнхний анхаарлыг ихээхэн татаж байна. Hurriyet Daily News-ээс сүүлийн хоёр жилийн хугацаанд энэ овгийнхны уламжлалт ахуйгаа хадгалж авч үлдэхэд тулгамдаж буй асуудлыг хэд хэдэн удаа сурвалжилжээ (Cetin 2010; Ocaк 2010; Akatay 2011). Сарикэчилүүдийг “Анатолий дахь сүүлчийн туркмен нүүдэлчин овог”, “Төв Азиас нүүдэллэж ирсэн туркүүдийг төлөөлөх цорын ганц бүлэг” (Ocaк 2010) гэж үздэг байна. “Хүнс хөдөө аж ахуй, мал аж ахуйн яамыг байгуулах, чиг

үүргийг тодорхойлох тухай” (2001) хуулийг баталсны дүнд өдгөө сарикэчилүүд ойн сангийн нөөц бүхий нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрлөөр малаа бэлчээх болсноор уламжлалаа хадгалж хамгаалах нөхцөл боломж бүрджээ. Тэдний хувьд “Ус, ойн хуулиар хамгаалагдсан нутаг дэвсгэрт мал сүргээ бэлчээх” нь гол асуудал болдог байна. Түүнчлэн “ЮНЕСКО-ийн зүгээс сарикечили нарыг нэн даруй хамгаалалтад авахыг шаардана” гэдгийг дурдах нь зүйтэй.

Тэдний соёлыг хадгалж хамгаалах зорилгоор анх 2001 онд байгуулагдсан нүүдэлчин овгууд, туркмений эвсэл нь 2005 онд холбоо (*Toroslar Yörük Türkmen Federasyonu*) болж өргөжжээ. Өдгөө энэ холбоо нь Турк даяар нийт 420 салбар, нэг сая гаруй гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна (Ven Herpen 2011). Гиймээс сарикэчилүүдийн жишээ нь төрийн бодлогыг малчдын санал хүсэлттэй уялдуулж болохын нэгээхэн загвар болох юм (Salzman 1983). Өнөөгийн Турк улс дахь нүүдэлчдийн дундаас Туркийн газар нутаг дээрх цорын ганц уугуул нүүдэлчид болохын хувьд энэ бүлгийн улс төрийн жин, нөлөөнд үндэсний ижилслийн тухай асуудал зайлшгүй хөндөгддөг байна.

Тиевнин (2011) овгийн тогтолцоо нь нүүдэлчид, хагас нүүдэлчдийн мал аж ахуйн уламжлалыг хадгалаад зогсохгүй түүнийг улам бат бэх болгож байдаг гэж үзжээ. Өдгөө Анатолийд ч тэр, ийм байдлаар хадгалагдаж ирсэн бэлчээрийн мал аж ахуй нь бэлчээрийн өв болох бөгөөд үүнийг үнэлэх хэрэгтэй байна. Туркийн төрийн бодлогыг өргөн хүрээнд авч үзвэл, нүүдэлчдийн өв нь соёлын өвийн олон төрөл, хэлбэрийн нэгд зүй ёсоор тооцогдож, хүлээн зөвшөөрөгдсөн байртай байна.

## **5.2. Соёлын өвийн бодлого ба Исламын шашин**

Турк бол олон янзын түүх, соёлын уламжлал, угсаатны бүлгүүд, олон хэлбэрийн биет болон биет бус өвийн өлгий билээ. Түүх, эд өлгийн ийм арвин баялагтай тул Турк улс соёлын эд өлгийн зүйлсийн хууль бус худалдаа наймааны бай болж иржээ. Иймд соёлын өвийг үнэлэх, хадгалж хамгаалах, боловсронгуй болгож, олон нийтэд таниулан, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Соёл, аялал жуулчлалын яамыг байгуулах, чиг үүргийг тодорхойлох тухай” (2003) 4848 тоот хуулийг баталсан. Мөн тус хуулиар соёлын эд өлгийн дурсгалыг устгаж сүйтгэхээс урьдчилан сэргийлдэг байна. Энэ хуулиар соёлын эд өлгийн зүйлсийг хамгаалахын зэрэгцээ аялал жуулчлалыг дэмжиж, хөгжүүлэх зах зээлд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар бүхий л улсын эдийн засагт хувь нэмэр оруулах, энэ чиглэлд төрийн байгууллагууд болон аж ахуйн нэгжүүдийг татан оролцуулах зорилготой юм (Scott et al. 2013). Турк улсын Засгийн газраас соёлын өвийг хадгалж хамгаалах зорилгоор Засгийн газар “Байгаль, соёлын эд өлгийн хамгаалалтын тухай” (1983) 2863 тоот хуулийг баталсан нь өнөөдөр ч хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тус хууль нь байгаль, соёлын эд өлгийн талаарх ойлголтыг тайлбарлахын зэрэгцээ нийгэмд тэдгээр өвийг хадгалж, хамгаалахын ач холбогдлыг ухуулдаг ажээ. Эдгээр хуулиудад үндэслэн тус улсын төрөөс соёлын өвийн ач холбогдлыг зөв зүйтэй үнэлж буйг харж болох авч, нөгөө талаар

материаллаг өвд ихээхэн анхаарал хандуулж байгаагаас нүүдлийн соёлын өвийн хувьд хууль тогтоомжуудад чухам ямар байр суурь эзэлдгийг тодорхойлоход бэрхшээлтэй байна.

Соёлын эд өлгийн тухай анх 1869 оны Эртний эдлэлийн тухай акт (*Asar-i Atika Nizamnamesi*)-д тодорхойлж тайлбарласан нь одоогийн хамгаалах тогтолцооны үндэс суурь болжээ (Scott et al. 2013). Энэхүү журам нь 1973 онд Эртний эдлэлийн акт хэмээх хууль батлагдах хүртэл хүчинтэй байсан бөгөөд орчин үеийн Турк улс байгуулагдсанаас хойших анхны цогц зохицуулалт байв. Тус актад соёлын хөдлөх, үл хөдлөх бүхий л эд өлгийн зүйлс нь төрийн мэдэлд байхаар тодорхойлсон байна (Scott et al. 2013).

1973 оны Эртний эдлэлийн тухай актын VII Бүлэгт “Эртний олдвор, түүх, байгалийн дурсгалт зүйлийг хамгаалах, авах, хэний өмч, захиргаанаас үл хамааран шаардлагатай арга хэмжээг авах, хяналт тавих асуудлыг Үндэсний Боловсролын Яам тодорхойлж, шийдвэрлэнэ” хэмээн заажээ. Тодорхойлолт хийхдээ тухайн эд өлгийн зүйлийн холбогдох он цаг, уран сайхны онцлогийг олдсон газар оронтой нь хамтатган авч үздэг байна. Тухайн олдворыг үлгэр жишээ болохуйц, тодорхой он цагийг төлөөлж байгаа тохиолдолд хамгаалах шаардлагатай “соёлын эд өлөг”-өөр тодорхойлдог байна (Scott et al. 2013).

Юун түрүүнд тус эд өлгийн зүйл нь XIX зууны сүүлээс өмнөх үед бүтээгдсэн үл хөдлөх өв байх ёстой бөгөөд хэрвээ түүнээс хойших үед хамаарах бол ихээхэн өвөрмөц, онцлог шинжийг агуулсан байж хамгаалагдана. Хоёрдугаарт, тухайн үл хөдлөх өв нь Яамнаас тодорхойлсон хамгаалалтын бүсэд байрласан бөгөөд ховор, өвөрмөц өнгө төрхтэй байх ёстой аж. Хэрэв тухайн өв нь барилга байгууламж бол гаднах чимэглэл, материал, хэлбэр хэмжээ нь бүс нутаг, урлаг, гоо зүй, архитектор, түүх, археологийн талаасаа өвөрмөц байх ёстой бөгөөд хот суурингийн тусгай хамгаалалттай бүсийн тухайд барилга байгууламжийг хамтад нь авч үзнэ. Харин археологийн тусгай хамгаалалттай бүсийн тухайд археологийн шинжлэх ухааны үүднээс тайлбарлагдах мэдээлэл өгөхүйц, судалгаа шинжилгээ хийх боломжтой бөгөөд хүрээлэн буй орчин, газар зүйн өвөрмөц шинжийг агуулсан байх шаардлагатай байна. Түүхэн тусгай хамгаалалтын бүсийн хувьд судалгаа шинжилгээгээр түүхэн чухал үйл явдал болсон газар нутаг гэдгийг нь тогтоосон байх ёстой аж (Scott et al. 2013).

7,000 гаруй археологийн дурсгалт газартай өнөөгийн Бүгд Найрамдах Турк Улсад археологийн соёлын эд өлгийн зүйлтэй холбоотой хууль бус малтлага, тонож сүйтгэх, мөн хууль бус наймаа зэрэг ноцтой асуудлууд тулгамдсаар байна. “Байгаль, соёлын эд өлгийн хамгаалалтын тухай” (1983) хууль нь тулгамдаж буй олон асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх хэдий ч бусад олон асуудал мөн орхигджээ. Скотт нар (2014) “Даяаршлын энэ эрин үед соёлын өвийг хамгаалахад дан ганц улсын төр хангалтгүй болсон цаг. Энэ асуудлын үүднээс Туркийн одоо хэрэгжиж буй хууль тогтоомжид олон улсын хамгаалалтын тогтолцооны хүрээнд нэн даруй хяналт шинжилгээ хийх, түүнчлэн бусад олон улсын конвенциудад нэгдэх, одоогийн конвенциудыг соёрхон батлах, бусад хууль тогтоомжтой

нарийвчлан харьцуулах, дотоодын зохицуулалтыг сайжруулах шаардлага тулгараад байна” хэмээжээ (Scott et al. 2013).

-Исламын шашин, төр, нийгэм

Соёлын өвийн ангилал, хадгалалт хамгаалалтын тухай хуулиуд нь Туркийн түүхнээ Бүгд найрамдах улс тунхагласны дараах, эхэн үеийн цор ганц бодлого биш юм. Исламын шашны төр, нийгэмд эзлэх байр суурь Туркийн үндэсний үзлийн гол тулгуур багана болжээ. Исламын хууль төрийн бодлогоос тусдаа байх хандлагатай хэдий ч төрийн хуулиар сайн дэмжигдсэн байх ба Туркийн өдөр тутмын амьдралд хүртэл нэвчсэн байдаг. 1923 онд Үндэсний их ассамблейн гишүүдийн санаачилгаар Османы эзэнт гүрний Шашны яамыг Шашны хэрэг эрхлэх газар болгон шинэчлэн байгуулсан байна. Өнөө Үндсэн хууль (1982)-д зааснаар тус хэрэг эрхлэх газар нь Ерөнхий сайдын шууд удирдлага дор үйл ажиллагаа явуулдаг бөгөөд өдөр тутмын улс төрөөс харин ангид байдаг аж (Yilmaz 2005). Энэ талаар Үндсэн хуулийн 136-р зүйлд:

Ерөнхий захиргааны харьяа Шашны хэрэг эрхлэх газар нь алив улс төрийн үзэл санаанаас ангид, шашингүйн зарчмыг баримтлан, үндэсний эв нэгдэл, бүрэн бүтэн байдлыг эрхэмлэн хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ хэмээн заасан байна. Шашны хэрэг эрхлэх газар байгуулагдсанаас хойш төрийн зүгээс Исламын шашны бүхий л үйл ажиллагааг тус байгууллагын ивээл дор нэгтгэж оруулжээ. Үүний үр дүнд шашны институциуд улс төрийн хүнд сурталтай хутгалдаж, өөрийн эрх мэдэл нь буурчээ. Энэ талаар Шанкланд Бүгд найрамдах намын элитүүд “Бүгд найрамдах улс, түүний хил хязгаарыг бататгах хэтийн зорилгодоо бат итгэдэг. Энэ нь хэрэв шаардлагатай бол Сунни Исламыг коммунизмын эсрэг ард иргэдийн эв найрамдлыг бататгах хэрэгсэл болгож харахаас ч буцахгүй гэсэн үг юм” (Shankland 1999) хэмээн тайлбарлажээ. Их хэмжээний төсөвтэй, 80 мянга гаруй ажилтантай Шашны хэрэг эрхлэх газрыг байгуулсан явдал нь энэхүү Турк маягийн лацизмын ойлголтын үр дүн юм.

Туркийн Бүгд найрамдах улс хэдий шашингүй үзэлтэй байсан авч 1924 онд Шашны хэрэг эрхлэх газрын шашны дээд зөвлөл хэмээх Ижтихадын хороог байгуулжээ (Yilmaz 2005). Туркийн нийгэмд Исламын шашин ийн өргөн тархсан байдалд “төрөөс энэхүү хороог байгуулж, нийгэм-эрх зүйн бодит байдалд хариу үйлдэл үзүүлснээрээ ихээхэн дэвшилттэйгээр нөлөөлсөн” юм. Ылмаз (2005)-ын тодорхойлсноор “энэхүү төрийн байгууллагын статус зарим талаар ихээхэн тодорхойгүй” байна. Төрөөс Исламын хуулийг албан ёсоор хүлээн зөвшөөрөөгүй, түүнийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх нь гэмт хэрэгт тооцогддог ч Шашны хэрэг эрхлэх газрын шашны дээд зөвлөл нь албан бусаар Исламын шашны эрх зүйн тогтолцоонд үндэслэдэг. Энэ хороо нь өөрсдийн хөндөж гаргаж ирсэн асуудлын хүрээнд фатва гаргахыг эрмэлздэг бөгөөд итжихад хийх, тахайюр хэрэгжүүлж, нийгэм-эрх зүйн бодит байдалд хариу үйлдэл үзүүлдэг байна (Yilmaz 2005).

Шашны хэрэг эрхлэх газар (Diyanet)-аас 1995 онд *Орчин үеийн асуудлын/асуудлуудын тухай фатва* нэртэй фатва номлол бүхий ном гаргаж, түүнтэй ижил утгатай мэдээлэл, нийтлэлийг албан ёсны цахим хуудастаа нийтэлжээ<sup>36</sup>. Шашны хэрэг эрхлэх газрын шашны дээд зөвлөлөөс гаргасан энэ ном нь шашны хүрээг нийгмийн хүрээнд өргөжүүлж буйн нэгэн үзүүлэлт болох бөгөөд энэ нь Дияанэтийн зүгээс өмнө нь шашингүй төрд шүтлэг ихтэй албан хаагчдыг удирдах чиг үүргээр хангаж чадаагүйн үр дагавар байв. Ийнхүү олон нийтийн өдөр тутмын амьдралд тулгамдаж байсан асуудлуудыг фатвагаар дамжуулан шийдвэрлэх арга замыг номлож, чиг үүргийнхээ хүрээг өргөжүүлж эхэлжээ. Туркийн хүн амын гол шашин болох Исламын шашин давамгайлж буй явдал, түүнийг хэрэгжүүлэхэд төрийн болон дотоодын хууль тогтоомжийн үүрэг ролийг харгалзан үзэхэд үндсэрхэг үзлийг сурталчилж байна. Исламын шашныг дэмжиж, сурталчилж буйг үндэс угсаа, шашин шүтлэгийн цөөнхөд үзүүлэх дэмжлэг дутмаг буйгаас харж болно. Тэдгээр цөөнхүүд нь гол төлөв түүхэн нүүдэлчид байх бөгөөд ялангуяа төрийн ялгаварлан гадуурхал, уусгах бодлоготой нүүр тулсан курд, цыганууд байгаагаас харахад энэ нь чухал ач холбогдолтой асуудал юм.

#### -Цөөнхийн соёл, уусан ижилсэлт

Доктор Олгун Акбулут “Турк дахь цөөнхийн эрхийн тухай ойлголт нь улс төр дэх цөөнхийн оролцоо, цөөнхийн салан тусгаарлах эрхээр өөрийгөө тодорхойлохтой шууд холбогддог байна. Цөөнхийн тухай асуудал олон нийтэд сөхөгдсөн л бол салан тусгаарлах тухай асуудал үргэлж хөндөгддөг. Цөөнхийн эрхийн тухай асуудал нэгэнт л өөрийгөө тодорхойлох эрхтэй зохиомлоор холбогдсон тул “соёлын эрх”-ийн асуудлын гадна үлдэж, өдийг хүртэл эмзэг сэдэв хэвээр байгаа аж. Хэн нэгэн соёлын эрхийн тухай, түүнийг дэмжихтэй холбоотой асуудал хөндсөн тохиолдолд далдуур өөр нэг санаа агуулж байгаа гэсэн хардлага гарч болохыг үгүйсгэхгүй юм (Laws 2018; Akbulut 2010).

Үүний нэгэн том жишээ нь боловсролын систем юм. Өнөө цөөнх бүлгүүдийн дунд Туркийн боловсролын систем өөрсдийг нь уусган нэгтгэх зорилготой гэсэн ойлголт өргөн тархсан байдаг (Каяа 2009). Туркийн ижилсэл, үндэсний үзлийг үнэт зүйлийн үндэс суурь хэмээн сурталчилдаг бол цөөнхийн соёл, түүх, шашныг үл ойшоодог байна. Учир нь Туркийн Засгийн газраас армени, еврей, рум (грек)-уудыг л угсаатны цөөнх хэмээн тодорхойлж, тэднээс бусад цөөнх бүлгүүдэд сургууль нээхийг зөвшөөрдөггүй. Улсын сургуулиудад аль ч цөөнхийн хэл дээр сургалт явуулах, улсын, хувийн бүх сургуулиудад тэдгээр хэлийг сонгон судлах анги нээж, заах боломжгүй байдаг ажээ. Христ, Еврейн шашинтайгаас бусад бүх сурагчид шашны соёл, ёс суртахууны хичээлийг заавал судлах ёстой гэхчлэн ерөнхийдөө боловсролын системд цөөнх сурагчид ихээхэн ялгаварлан гадуурхалтад өртдөг. Энэ талаар Каяа (2009) “Тэд итгэл үнэмшил, шашин шүтлэгээ чөлөөтэй илэрхийлэх ёстой. Энэ нь олон улсын гэрээ, Туркийн Үндсэн хууль (1983)-ийн 24-

<sup>36</sup> "Diyanet İşleri Başkanlığı - e-Devlet Kapısı." 31 Oct. 2022, <https://www.turkiye.gov.tr/diyanet-isleri-baskanligi>.



р зүйлийн дагуу хориотой юм” гэж бичжээ. Бүр цаашлаад, Туркийн Үндэсний Боловсролын Яамнаас олон ургалч үзлийн үүднээс энэ мэтээр шүүмжилж буйгаас үл хамааран сурах бичиг, хичээлүүдийн агуулгад Исламаас бусад шашны талаар маш бага тусгасан байдаг аж. Түүгээр ч үл барам сургалтын хөтөлбөрт тусгагдаагүй бие засах, залбирах, сүмд очих зэрэг зан үйлүүдийг үйлдэхийг цөөнх сурагчдаас шаардсан тухай мэдээ ч байдаг (Кааа 2009).

Кааа (2009) мөн “эдгээр нь цөөнх бүлгүүдийн сурагчдыг ялгаварлан гадуурхах, дарамтлах, доромжлох явдлыг улам даамжруулах нөхцөлийг бүрдүүлж байна. Тэд үндэс угсаа, шашин шүтлэгээ ил гаргахаас эмээж, нуух явдал гаарсаар цаашдаа олон цөөнх бүлэг өөрсдийн өвөрмөц шинжээ алдах вий хэмээн зовниж байна” гэжээ. Түүнчлэн “Европын Холбооны зүгээс Туркийн элсэх явцын тайланд цөөнх, тэдэнтэй холбоотой асуудлууд, ялангуяа Туркийн Засгийн газраас албадлагаар нүүлгэн шилжүүлсэн, ялгаварлан гадуурхалтад хамгийн их өртсөн эмзэг бүлгүүд болох Курд, Цыгануудын тухай тусгаж байх ёстой” гэж үздэг (Кааа 2009). Энд Курд, Цыгануудын уламжлалт нүүдэлчин ард түмэн болох, мөн өнөө байгуулсан тодорхой улс байдаггүйтэй нь холбоотойгоор тэднийг илүүтэй ялгаварлан гадуурхах хандлагатай байдгийг дурдах нь зүйтэй.

2007 онд Европын Хүний эрхийн шүүхээс цөөнх Алевичүүдийн дэвшүүлэн тавьсан шашны соёл, ёс суртахууны хичээлийг заавал судлахтай холбоотой асуудлыг хэлэлцэн, сургалтын хөтөлбөрөөр сурч боловсрох эрхийг зөрчиж байна гэсэн утгатай шийдвэр гаргаснаа мэдэгдэв<sup>37</sup>. Түүний дараагаар Туркийн захиргааны шүүх эрх мэдлийн дээд байгууллага болох Төрийн зөвлөл мөн адил шийдвэр гаргажээ. Гэсэн хэдий ч Боловсролын сайд ЕХЭШ-ээс хянан шалгасан сургалтын хөтөлбөр шинэчлэгдсэн тул гарсан шийдвэрийг хүлээж авах боломжгүй бөгөөд Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангахын үүднээс тус хичээлийг заавал судлах хэвээр үлдээх талаар мэдэгдсэн. Засгийн газраас 2007 онд өргөн барьсан иргэний хуулийн төслийг цөөнх бүлгүүд, хүний эрхийн идэвхтнүүд, төрийн бус байгууллагууд, ЕХ ч дэмжсэн боловч зарим бүлгийн зүгээс тус төсөлд цөөнхийн эрхийн тухай тодорхой тусгаагүй байгааг сануулав<sup>38</sup>. Засгийн газраас 2007 оны 6 дугаар сард болсон сонгуулиас хойш өргөн барьсан иргэний хуулиа батлуулах тухайд юу ч хийсэнгүй (Кааа 2009). Энд 2002 оноос хойш хамгийн сүүлд 6771 дүгээр хуулийн заалтын дагуу 2017 онд нэмэлт, өөрчлөлт оруулсныг дурдах нь зүйтэй. Өмнөх бүлгүүдэд улс төр, эдийн засаг,

---

<sup>37</sup>CASE OF HASAN AND EYLEM ZENGİN v. TURKEY (2007), accessed from "HUDOC - The Council of Europe." <https://hudoc.echr.coe.int/eng>.

<sup>38</sup>See online article: Staff (2007) “Turkish constitution draft seen ready by end-Sept” <https://www.reuters.com/article/us-turkey-constitution/turkish-constitution-draft-seen-ready-by-end-sept-idUSL2780399520070827>; see also Commission of the European Communities (2007) *Turkey 2007 Progress Report*

иргэний, хүний эрхийн тухай дурдсан боловч цөөнхийн эрхийн талаар тодорхой заагаагүй байдаг.

Энэ бүгдээс дүгнэн үзэхэд, Турк улс соёлын өв, Исламын шашныг дэмжих тухай урт хугацааны бодлого, хуулиудыг амжилттай батлан хэрэгжүүлж байгаа боловч нүүдлийн өв соёл болон цөөнхийн эрхийг дэмжсэн жишээ төдийлөн ажиглагдсангүй. Нэг талаас соёлын өвийн тухай өргөн хүрээтэй хуулиудад нүүдэлчдийн ахуй, соёлыг зан үйлийн түвшинд хүлээн зөвшөөрч байна хэмээн үзэж болох ч, нөгөө талаас нүүдэлчдийн аж ахуй, бэлчээртэй холбоотой асуудлуудад тухайлсан хууль тогтоомж байхгүй байгаа нь ингэж үзэхэд төвөгтэй болгож байгаа юм. Түүнчлэн дан ганц цөөнхийн эрхийг хөндөж, түүгээрээ Турк дэх цөөнх бүлгүүдийн нүүдэлчин соёл, түүхийн асуудлыг төрийн асуудалтай холбож авч үзэх нь өөрөө учир дутагдалтай юм. Тэр ч үүднээсээ бусад улсуудтай харьцуулахад Бүгд Найрамдах Турк Улсын нийгэм-улс төрийн нөхцөл байдлыг судлах нь илүү адармаатай бөгөөд нүүдэлчдийн өмнө үүсэж буй хэрэгцээ шаардлага, үүрэг, ирээдүйн талаарх асуудлыг авч үзэхэд илүү их судалгаа шинжилгээ шаардлагатай болж байна.

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ: БНХАУ БА НҮҮДЛИЙН СОЁЛ

Тус бүлэгт бид Хятадын нийгэм, соёлын орон зай дахь “Нүүдлийн соёл” гэх ойлголт хэрхэн тайлбарлагдаж, бүтээгдэж байдаг тухай судлах болно. Учир нь БНХАУ-д Монгол үндэстний дийлэнх хэсэг оршин суудаг бөгөөд тус улсын 56 үндэстний нэгийг бүрдүүлдэг билээ. Үнэндээ зөвхөн Монгол үндэстэн ч бус Манж, Төвөд болон Шинжааны бүс дэх нүүдлийн соёлтой, эсвэл нүүдлийн соёлын улбаатай олон үндэстэн хамаарагддагийг бүгд мэднэ. Энэ утгаараа бид тус судалгааны бүтээлийн гол объект болсон “Нүүдлийн соёл” гэх ухагдахууны талаар тус улсын дотоод нийгэм, соёлд тэр тусмаа Засгийн газрын болон эрдэм шинжилгээний талбарт хэрхэн тайлбарлаж байдгийг судлахыг зорьсон юм. Учир нь Хятадын нийгэмд төрийн тогтолцоо болон засаглалын онцлогоос үүдэн “Нүүдлийн соёл” гэх ухагдахууныг бус, “Тал нутгийн соёл” гэх ойлголтыг хэдийнээ өргөн хэрэглэж заншжээ. Энэ байдлын гол шалтгаан нь үндэсний нэгтгэлийн бодлоготой шууд холбоотой ч энэ ажлыг зохион байгуулах гол урьдач нөхцөлд шинжлэх ухааны талбар оролцсон юм. Товчхондоо, Засгийн газрын болон шинжлэх ухааны талбарын харилцаа холбоон дээр тулгуурлан хэрхэн “төр-нийгэм”-ийг бүтээх тухай тасралтгүй оролдлого, үйл ажиллагааг харж болохоор нэг жишээ болсон гэсэн үг.

Энэ байдлыг хэрхэн өрнөснийг харуулахын тулд бид тус бүлгийн нэгдүгээр хэсэгт Хятадын эрдэм шинжилгээний талбар доторх зарим судлаачид “Нүүдлийн соёл”-ыг хэрхэн “Тал нутгийн соёл” болгож хувиргах, эсвэл энэ хоёр ойлголт ямар ялгаа зөрөөтэй болох тухай нотолгоо хийснийг авч үзнэ. Харин тус бүлгийн хоёрдугаар хэсэгт, энэхүү эрдэм шинжилгээний талбарын нотолгоо болгож, Хятадын Засгийн газар улс төрийн баримт бичиг дээрээ “Тал нутгийн соёл”, эсвэл “Бэлчээрийн нутаг” гэх үгийг ашиглаж байгаа тухай нотолгоонуудыг авч үзнэ. Мөн тэрчлэн Өвөр Монголд сүүлийн хэдэн жилд “тал нутгийн соёл” гэх нэрийн доор “борооны дараах мөөг шиг” олон арван соёлын арга хэмжээ зохион байгуулагдаж байгаа бөгөөд тэдгээрийн эдийн засаг болон улс төртэй холбогдсон зорилгуудыг авч үзнэ.

### **6.1. Эрдэм шинжилгээний талбар дахь “нүүдлийн соёл” ба “тал нутгийн соёл”**

-БНХАУ дахь бэлчээрийн тухай

Хятадын бэлчээрийн гэгдэх талбай нь 392.8 сая га бөгөөд нийт газар нутгийн 40.9 хувийг эзэлдэг. Мөн ургамлын экологийн төрөл, бэлчээрийн ландшафтын төрлөөр баялаг бөгөөд дэлхийд ховор гэгдэх өндөр чанартай тэжээлийн өвстэй. Энэхүү бэлчээрийн бүс нь Зүүн хойдын тэгш талаас Их Хянганы нурууг дамнан Монголын тэгш өндөрлөг, Ордосын өндөрлөг, Шар хөрст өндөрлөгөөр дамжин Хөх нуур-Төвөдийн өндөрлөгийн өмнөд зах хүртэл 4500 орчим километр үргэлжилдэг. Хойдоос урагшаа өргөргийн 31°-д байрлана. Жилийн хур тунадас 50 мм-ээс 2000 мм хүртэл, - 100 метрээс 8000 метр хүртэл өндөртэй, 5 төрлийн уур амьсгалтай. Бэлчээрийн байгаль, газарзүйн онцлогоос үл хамааран зөвхөн засаг захиргааны бүс нутгийн тархцын үүднээс авч үзвэл, Хятадын хамгийн том байгалийн бэлчээртэй муж (бүс) нь Төвөд, Өвөр Монгол, Шинжаан юм. Үүнд, Төвөдийн бэлчээрийн

талбай нь улсын бэлчээрийн 20.9%-ийг, Өвөр Монголын бэлчээрийн талбай нь улсын бэлчээрийн 20.06%-ийг, Шинжааны бэлчээрийн талбай нь 14.58%-ийг тус тус эзэлж байна. Том бэлчээрийн талбайтай бусад хойд мужуудад Хөх нуур, Ганьсу, Сычуань, Ниншя, Ляонин, Жилин, Хармөрөн гэх мэт мужууд мөн орно. Өмнө зүгийн өвслөг толгод, энгэрүүд нь гол төлөв Чинлин-Хуайхэ шугамын өмнөд хэсэгт (хойд өргөргийн 33° орчим) болон Гуандун, Гуанши дахь Хөх нуур-Төвөдийн өндөрлөгөөс зүүн тийш тархсан байдаг. Төрөл бүрийн бэлчээрийн байгаль, газарзүйн нөхцөл байдал эрс ялгаатай тул бэлчээрийн бүтээмж харилцан адилгүй байдаг. Өвөр Монгол бол улсын хамгийн том бэлчээрийн бүс, Шинжаан бол тус улсын хоёр дахь том бэлчээрийн бүс, Төвөд бол хамгийн том тэгш өндөрлөгийн бэлчээрийн бүс нутаг юм. Хөх нуур, Ганьсу, баруун хойд Сычуаны бэлчээрийн бүс нь тус улсын дөрөв, тав, зургаа дахь том бэлчээрийн бүс юм. Өргөргийн бүсчлэл, уртрагийн бүсчлэл, босоо бүсчлэл ба тодорхой газар зүйн байршил, хөрс, ургамалжилт, ус зүй болон бусад хүчин зүйлсийн нийлбэр нөлөөгөөр бүх төрлийн бэлчээрийг дэлхийн цаг уурын координатын тэнхлэгт тогтсон байр суурь эзэлдэг бөгөөд бусад экосистемтэй тодорхой байр сууриа хадгалж байдаг. Бэлчээрийн тал нь ихэвчлэн чийглэг ойн бүсээс хуурай цөлийн бүс рүү шилжих шилжилтийн дунд хэсэгт оршдог. Бэлчээрийн бүсийн нэг үзүүр нь ойн экосистем, нөгөө үзүүр нь хуурай (уулын) цөлийн экосистем. Бүлэг нь намгархаг, биологийн төрөл зүйлээр баялаг, нуга тал хээрт тархсан, элсэн цөлд ойр, хур тунадас багатай, хуурай уур амьсгалтай, өвсний бүлэг нам, сийрэг, төрөл зүйл нь нэг хэвийн, ихэвчлэн ган гачигт тэсвэртэй. жижиг бут сөөг, хуурай цөлөрхөг хээр, сөөгт хээр, чийглэг бэлчээр болон хуурай цөлийн бэлчээрийн хоорондох өргөн уудам нутагт ердийн бэлчээрт тархсан. Хятадын бэлчээрийн нөөцийн тархалт нь бүс нутгийн тодорхой орон зайн хэв шинж, онцлогтой бөгөөд үндсэндээ умард сэрүүн бүсийн бэлчээр, Чинхай-Төвөдийн уулын бэлчээр, өмнөд хэсгийн өвслөг уул, энгэр гэсэн гурван том бүсэд хуваагддаг. Мөн Хятадын бэлчээрийг зүүн хойд бэлчээрийн бүс, Мэннин Гань бэлчээрийн бүс, Шинжааны бэлчээрийн бүс, Хөх нуур-Төвөдийн өндөрлөгийн уулын бэлчээрийн бүс, өмнөд хэсгийн өвслөг уулын бэлчээрийн бүс гэж 5 том бүс болгон хуваасан эрдэмтэд ч бий. Умард сэрүүн бүсийн бэлчээрийг зүүн хойд тал, бэлчээрийн бүс, Мэннинган бэлчээрийн бүс, Шинжааны бэлчээрийн бүс гэж хуваана. Тодруулбал, зүүн хойд бэлчээр нь гол төлөв Жилин, Ляонин, ӨМӨЗО-ы зүүн хойд бүс нутгийг хамардаг. Түүний бэлчээрийн талбай нь улсын бэлчээрийн талбайн 2 орчим хувийг эзэлдэг бөгөөд зүүн хойд талын тэгш тал болон ойр орчмын толгодыг хамардаг. Түүнчлэн Хянган уул болон Чанбай нурууны уулархаг газрыг ч хамардаг. Мэннинган гэгдэх бэлчээрт гол төлөв Өвөр Монгол, Ганьсу мужуудын ихэнх хэсэг, Ниншя, хойд Хэбэй, хойд Шаньси, хойд Шэньси бэлчээрийн бүс нутаг багтаж, тус улсын бэлчээрийн 30 орчим хувийг эзэлдэг. Иньшань уулын хойд талын Өвөр Монголын өндөрлөг, Хэлан уулын зүүн талын Ордосын өндөрлөг, Шэньсигийн хойд хэсэг, Ганьсугийн зүүн өмнөд хэсгийн шар хөрстийн өндөрлөг зэрэг энэ бүс нутгийн бэлчээрийн бүсийг бүрдүүлдэг газрын хэв шинжийн гол онцлог нь өндөр тал юм. Үүнээс гадна энэ нутагт уулс, намхан толгод, тэгш тал, элсэрхэг газар байдаг бөгөөд тэдгээрт янз бүрийн төрлийн өвслөг ургамал тархсан байдаг. Шинжааны бэлчээрийн бүс нь эх орны баруун хойд хилд, хойд

талаараа Алтайн нуруу, Жунгар [Зүүнгар] Жэйшань уулс, өмнөд талаараа Кунлунь, Алтун нурууны хооронд оршдог нь тус улсын нийт нутгийн 22 гаруй хувийг эзэлдэг. Шинжааны бэлчээрийн тал нь эх газрын төвд байрладаг, хуурай, бороотой, эх газрын ердийн уур амьсгалтай, уулын бэлчээр зонхилдог. Чинхай-Төвөдийн өндөрлөгийн уулын хээрийн бүс нь Хятадын баруун өмнөд хэсэгт орших ба хойд талаараа Кунлунь уулс, Килян уулс, өмнөд талаараа Гималайн нуруу, баруун талаараа Памирын өндөрлөг хүртэл үргэлжилдэг. Сычуаны баруун өмнөд, баруун хойд, Юньнань мужийн баруун хойд хэсэг гэх мэт нь хятадын бэлчээрийн 32 гаруй хувийг эзэлдэг. Энэ бүсийн ургамалжилт нь тодорхой босоо тархалтын хэв маягтай. Хөндийн талбай нь бэлчээрт, ойн дээд хязгаар нь уулын бэлчээрийн болон уулын тундрын бүс юм. Хятадын өмнөд мужуудад өвслөг толгод, өвслөг энгэр, ойн бэлчээр бүхий том талбайнууд, түүнчлэн олон тооны тархай бутархай “гурван талт” бэлчээрүүд байдаг бөгөөд эдгээрийг хамтад нь өмнөд өвслөг толгод, өвслөг энгэр гэж нэрлэдэг. Эдгээр газар нутаг нь гол төлөв Хөх мөрний сав газрын өмнөд хэсэгт, тухайлбал, Сычуань (баруун талаараа Аба, Ганзи, Сяоляншаны зарим хэсгийг эс тооцвол), Юньнань (Дицинээс бусад), Гуйжоу, Хунань, Хубэй, Аньхуйн өмнөд хэсэг, Зянсугийн өмнөд хэсэг, Жэжян, Фүжянь, Тайвань, Гуандун, Хайнань, Гуанси гэх мэт янз бүрийн уулархаг бэлчээрүүд багтдаг. Ер нь Хятадад бэлчээрийн тал нутаг нь ихэвчлэн сэрүүн бүсийн бэлчээрүүд бөгөөд өргөн тархсан, олон төрөл байдаг. Байгалийн бэлчээрийн талбай зүүн хойд, баруун хойд болон Хөх нуур-Төвөдийн өндөрлөгт төвлөрч, хойд талын бэлчээрийн талбай нь тус улсын бэлчээрийн 80%-ийг эзэлдэг. Өмнө зүгийн бэлчээрийн нөөц нь гол төлөв өвслөг толгод, өвсний энгэр, сийрэг ойт бэлчээрүүд бөгөөд тус улсын бэлчээрийн 20 орчим хувийг л эзэлдэг.

-“Нүүдлийн соёл” ба “Тал нутгийн соёл”

Хятадын бэлчээрийн талбай нь тус улсын нийт нутаг дэвсгэрийн 40.9 хувийг эзэлдэг бөгөөд эдгээр нутагт нүүдлийн аж ахуй эрхэлдэг хүмүүс нь үндсэндээ Монгол, Төвөд зэрэг үндэстний цөөнх буюу “цөөн тоот үндэстэн”-үүд байдаг. Тэдний энэ нутаг дахь амьдралын хэв маягийг бид “Нүүдлийн соёл”-т хэмээн тодорхойлсоор ирсэн. Гэвч, Хятадын Засгийн газрын сүүлийн хагас зуун жилээс хойших олонх дискурсад энэ нь “Тал нутгийн соёл”-т гэх ойлголтоор солигдож, үүнд эрдэм шинжилгээний талбарынхан нотолгоог нь гаргаж өгсөн байдаг. Судалгааны эл хэсгийг “Энэ нь ямар учиртай юм бэ” гэсэн асуултад хариулт өгөхөд зориулж байна.

Дээрх асуултын хариулт нь 1949 оноос хойш эх газрын олон дүрвэгсэд сайн дурын үндсэн дээр, эсвэл Засгийн газрын “Хил хязгаарыг дэмжих” гэх нэрийн дор үндэстний цөөнхийн оршин суудаг хилийн бүс, эсвэл цөөнхөд ихээр шилжин суурьшсантай холбоотой бөгөөд энэ үйл явдал, бодлоготой холбоотой төр-нийгмийн олон үйл ажиллагаанд эдгээр нүүдэлчдийн газар нутаг нь эрт дээр үеэс Хятадын салшгүй хэсэг байсаар ирсэн гэдгийг нотлох шаардлага тулгарсан хэрэг юм. Энэ зорилгодоо хүрэхийн тулд зарим судлаачид эдгээр бэлчээрийг нүүдэлчдийн амьдрах газар биш, харин Хятадын бүх үндэстэн, тэр дундаа Хан буюу Хятад үндэстний хамтран эрхэлж буй “Бэлчээрийн аж ахуй”, “Тал нутгийн

соёл” гэж маргаж, түүнийгээ нотлох оролдлогуудыг хийх болжээ. Эдгээр эрдэмтдийн аргумент нь тал нутгийн соёл ба нүүдэлчдийн соёл нь тодорхой утга, цар хүрээний хувьд салшгүй холбоотой ч энэ хоёрын хооронд үл тоомсорлож боломгүй чанарын ялгаа байдаг гэсэнд оршино. Бэлчээрийн соёл бол бүс нутгийн соёлын төрөл, харин нүүдэлчдийн соёл нь эдийн засгийн соёлын нэг төрөл бөгөөд газарзүйн тархалтын үүднээс авч үзвэл тал нутгийн соёл нь талын нутаг дэвсгэрийн тархалттай үндсэндээ нийцэж байгаа бол, нүүдлийн соёл нь бүхэлдээ тариалангийн эсвэл Хятад соёлтой ижил биш, үүсэл, төлөвшил, үйл явц юм. Тал нутгийн соёл, нүүдэлчдийн соёл нэгэн зэрэг хөгжөөгүй бөгөөд бүтцийн онцлогийн үүднээс авч үзвэл тал нутгийн соёл нь нийлмэл соёл, харин нүүдлийн соёл нь нэг соёл гэж үзэх болсон байна.

Улмаар тэдгээр хятад эрдэмтэд тал нутгийн соёл, нүүдлийн соёл хоёрын уялдаа холбоог судлахын тулд юуны өмнө тал нутгийн соёл гэж юу вэ, нүүдлийн соёл гэж юу вэ гэдгийг нарийн тодорхойлох хэрэгтэй байна хэмээн үзжээ. Хэдийгээр энэ тодорхойлолтыг гаргаж, эрдэм шинжилгээний нийгэмлэгт өргөнөөр таниулна гэдэг амаргүй ч бидний хийх ёстой оролдлого гэгцгээж байв. Тэднийхээр тал нутгийн соёл гэгч нь байгаль экологийн өвөрмөц орчинд үе дамжин амьдарч ирсэн янз бүрийн угсаатны хүмүүсийн бүтээсэн соёл гэж үздэг. Энэ нь бэлчээрийн экологийн орчин, энэ орчинд амьдарч буй хүмүүсийн харилцан үйлчлэл, харилцан сонгон шалгаруулалтын үр дүн бөгөөд бэлчээрийн экологийн асар их хишиг хүртээд зогсохгүй, малчин ард түмний мэргэн ухааны олон талыг агуулсан, түүний дотор үйлдвэрлэлийн арга, амьдралын хэв маягаас бүрдсэн үнэт зүйлс, сэтгэлгээний арга барил, гоо зүй, шашны итгэл үнэмшил, ёс суртахууны мэдрэмж гэх мэт болно. Тал нутгийн соёл нь өвөрмөц онцлогтой, баялаг утга агуулгатай, өргөн нөлөө бүхий соёлын хэлбэр бөгөөд өнөөг хүртэл хүн төрөлхтний нийгмийн хамгийн чухал соёлын нэг хэлбэр гэж үзжээ. Мөн тэд нүүдэлчин овог аймгууд, нүүдэлчид, нүүдэлчин бүлгүүдийг багтаасан нүүдлийн үйлдвэрлэл эрхэлж, өвс усны шимээр аж төрж буй ард түмний бий болгосон соёлыг “нүүдлийн соёл” гэж нэрлэдэг. Үүний өвөрмөц онцлог нь нүүдэлчдийн үйлдвэрлэл өөрөө нүүдэлчин ахуйд оршдог. Нүүдэлчдийн үзэл санаа, итгэл үнэмшил, зан заншил, дадал зуршил, тэдгээрийн нийгмийн бүтэц, улс төрийн тогтолцоо, үнэт зүйлсийн тогтолцоо зэрэг нь нүүдэлчдийн үйлдвэрлэл, амьдралын хэв маягийн түүхэн тусгал, арга барил юм. Нүүдлийн соёл нь нүүдэлчдийн амьдралын хэв маяг, түүнд нийцсэн утга зохиол, урлаг, шашин шүтлэг, гүн ухаан, ёс заншил, дадал зуршил зэрэг тодорхой элементүүдийг багтаасан нүүдлийн үйлдвэрлэлийн үндсэн дээр бүрэлдэн тогтдог гэжээ.

Тэдний эдгээр тодорхойлолтоос харахад, тал нутгийн соёл, нүүдэлчдийн соёлын хооронд үнэхээр чухал, ижил төстэй зүйл байдгийг ойлгоход хэцүү биш бөгөөд тодорхой хүрээнд, тодорхой түүхэн цаг хугацааны дотор угсаатны өвөрмөц шинж чанартай байдаг мэт. Нүүдлийн соёл гэж нэрлэдэг, эсвэл тал нутгийн соёлыг нүүдэлчдийн соёлын товчлол гэж үздэг бөгөөд энэ нь тодорхой хүрээ, тодорхой үеэр тодорхойлогддог гэж үздэг. Гэтэл энэ тодорхой хүрээ, үеийг давж, зүгээр л тал нутгийн соёлыг нүүдлийн соёлтой адилтгаж, улмаар тал нутгийн соёл гэдэг ойлголтод эргэлзэж байгаа нь зайлшгүй логик, шинжлэх ухааны үндэслэл дутмаг байгааг харуулдаг. Яагаад гэвэл нэгэнт тодорхой хүрээнээс халиад

тал нутгийн соёл, нүүдэлчдийн соёл хоёр өөр төрлийн соёлын талбарт бүрэн захирагдаж байна. Эхнийх нь бүс нутгийн соёлын төрөлд хамаарах бөгөөд далайн соёл, голын соёл, ойн соёл гэсэн дараалалд багтаж байна. Харин сүүлийнх нь эдийн засгийн соёлын төрөлд захирагдах бөгөөд ан агнуурын соёл, түүн цуглуулах соёл болон газар тариалангийн соёл гэх мэт. Тал нутгийн соёл, нүүдэлчдийн соёлын янз бүрийн төрлийг тодруулах нь зөвхөн үзэл баримтлалыг тодорхойлохоос гадна, дотоод шинж чанараас нь тэдний ялгарах онцлог, гол ялгааг ойлгож авах хэрэгцээ юм.

Тал нутгийн соёл, нүүдэлчдийн соёл нь бүс нутгийн тархалтаас эхлээд хоорондоо асар олон ялгаа бүхий юм. Тал нутгийн соёл нь бэлчээрийн экологийн орчинд бий болж, бэлчээрийн нөөцийн тархалтаар дэлхий даяар тархдаг. Одоо бидний тодорхой мэдэж байгаа зүйл бол, бэлчээр гэх зүйл бүх тивд л байх бөгөөд бэлчээрийн талбай нь дэлхийн нийт газар нутгийн 1/5-аас илүү хувийг эзэлдэг. Тэдгээрийн хамгийн том нь зүүнээс баруун тийш 110° уртрагийг эзлэн оршдог Евроазийн тал нутаг бөгөөд Их Хянган нурууны зүүн талаас Европын Дунай мөрний адаг хүртэл 10 мянга гаруй бээрийн зайд үргэлжилдэг. Эдгээр бэлчээрийг уур амьсгал, ургамлын янз бүрийн нөхцөл байдлаас шалтгаалан ердийн бэлчээр, нугын бэлчээр, цөлийн бэлчээр, уулын нуга, намаг гэж хуваадаг. Эдгээр өөр өөр бүс нутаг, төрөл бүрийн бэлчээрт амьдарч буй хүмүүсийн бий болгосон бэлчээрийн соёлууд нь бүс нутгийн онцлогтой боловч тэдгээр нь бүгд бэлчээрийн байгаль экологийн орчинд үндэслэсэн, төрөлхийн холбоо, нэгдэлтэй байдаг.

Тал нутгийн соёл бэлчээрийн баялгийн хуваарилалтыг дагадаг бол, нүүдлийн соёлын тархалт өөр. Томас Ж. Барфилдийн “Нүүдэлчдийн сонголт” номд бичсэнээр, өнөөдөр дэлхий дээр нүүдэлчдийн таван том бүс нутаг байна гэжээ. Тэр нь: 1. Африк тивийг дамнан Сахарын цөлөөс Африкийн Их Рифтийн хөндий хүртэлх Зүүн Африкийн саванна. 2. Сахарын цөл ба Арабын цөл. 3. Газар дундын тэнгисийн эрэг нь Анатолийн өндөрлөг, Ираны өндөрлөгөөр дамжин Төв Азийн уулс хүрдэг. 4. Хар тэнгисээс Монгол хүртэл үргэлжилсэн Евразийн тал нутаг. 5. Төвөдийн өндөрлөг ба түүний зэргэлдээх уулархаг өндөрлөг газар гэх мэт. Зарим судлаачид нүүдэлчдийн соёлын тархалтын талаар өөр ангилал, хуваалт хийсэн бөгөөд бид энд нэг бүрчлэн эшлэхгүй. Эдгээр эрдэмтэд нүүдэлчдийн соёлын тархалтыг хэчнээн өөр өөр байдлаар хуваасан ч нэг зүйл дээр маш тууштай санал нэгдэж, тодруулбал, нүүдлийн соёлын бүс нутгийн тархалтыг бэлчээрийн нутаг дэвсгэрийн тархалттай бүрэн адилтгадаггүй, зарим нь бүр зөвхөн Европ тивийн хээрийн бүс бол нүүдэлчдийн соёлын жинхэнэ тархалтын бүс гэж боддог.

Дээр дурдсан тал нутгийн соёл, нүүдэлчдийн соёлын өөр өөр тархалтаас харахад тал нутгийн соёл нь бүс нутгийн соёл, нүүдлийн соёл нь эдийн засгийн соёлын хувьд чанарын олон ялгаа байгаа нь илэрхий байна. Бүс нутгийн соёл болох тал нутгийн соёл нь байгаль, газар зүйн нөхцөл, нүүдлийн соёл нь эдийн засгийн соёл болох үйлдвэрлэлийн арга хэлбэрт голлон суурилдаг.

Тал нутгийн соёл, нүүдэлчдийн соёлын үүсэл, бүрэлдэн бий болсон үеэс эхлэн тэдгээрийн хооронд ижил бус шинж тэмдэг илэрхий байна. Тал нутгийн соёлын гарал үүсэл, тэр дундаа тал нутгийн соёл үүссэн бүс нутаг, үүсэн бий болсон цаг хугацаа, хамгийн

эртний үйлдвэрлэлийн үндсэн ангилал, аж ахуй, соёлын хэлбэр гэх мэтийн талаар одоог хүртэл тусгайлсан судалгаа хийгдээгүй байгаа бололтой. Энэ тохиолдолд бидний дэвшүүлсэн үндсэн үзэл баримтлал (мөн зөвхөн таамаглал болгон ашиглах боломжтой) бол тал нутгийн соёл нь хоёр голын сав газрын соёл, эртний Египетийн соёл, эртний бүс нутгийн бусад соёлтой ижил урт түүхтэй юм. 700,000 орчим жилийн тэртээгээс эртний хүн төрөлхтөн амьдарч, цэцэглэн хөгжиж ирсэн хойд Хятадыг жишээ болгон авч үзье. Палеолитын сүүл, шинэ чулуун зэвсгийн эхэн үед Шинлонгвагийн соёл, Жаобаогу соёл, Хоншаны соёлоор төлөөлүүлсэн бэлчээрийн эхэн үеийн соёлууд энд дараалан гарч ирсэн бөгөөд үүнийг судлаачид Хятадын соёл иргэншлийн “үүрийн мандсан газар” хэмээн хүлээн зөвшөөрцгөөсөн юм.

Нүүдэлчдийн соёлын үүслийн тухай асуудал хэдийн эрдэмтдийн анхаарлыг ихээхэн татаж, эрчимтэй хэлэлцэгдэж байгаа бөгөөд үүнийг “ан агнуурын онол”, “хөдөө аж ахуй (мал аж ахуйн) онол”, “цаг уурын онол”, “хүн амын онол” гэсэн дөрвөн төлөөллийн үзэл бодолд нэгтгэн дүгнэж болно. Хожим нь энэ асуудлаар хийсэн судалгаа хэдийгээр хэтийн төлөвийн хувьд илүү шинэлэг байсан ч гол дэвшил нь зөвхөн “холимог эдийн засгийн онол” болон өөр өөр гарал үүслийн онол саналд харагдах болсон байна. Нүүдэлчдийн соёлын гарал үүслийн талаар өөр өөр ойлголттой байснаас эрдэм шинжилгээний хүрээнийхэн үүссэн цаг хугацааны талаар илүү сайн ойлголттой байв. Энэ асуудлын талаарх миний хувийн үзэл бодол бол нүүдэлчдийн соёлыг ан агнуур, эртний мал аж ахуй зэрэг эрт үеэс улбаатай гэж үздэг. Хэдийгээр бид эрт үеийн мал аж ахуйг нүүдлийн мал аж ахуй гэж үзэх боломжгүй ч гарал үүслийн хувьд нүүдлийн мал аж ахуй, мал аж ахуй хоёрыг нарийн ялгахад хэцүү байдаг.

Энэ үе нь ойролцоогоор МЭӨ 9000- 7000 оны хооронд бөгөөд үүсэх үе нь хүрэл зэвсгийн дунд, сүүл үе буюу МЭӨ 2000-150 оны хооронд байх ёстой. Нүүдэлчдийн соёлын гарал үүслийн тухай дээрх яриан дээр үндэслэн бид тал нутгийн соёл ба нүүдэлчдийн соёлын үүсэл, төлөвшил, хөгжлийн явц дахь уялдаа холбоо, ялгааг тусгайлан авч үзэхийн тулд харьцуулах арга хэрэглэн хичээж байна. Үүний тулд тал нутгийн соёлын хөгжлийн түүхэн үйл явцыг дараах түүхэн гурван үе шатанд хувааж, товч тайлбарлая. Үүнд:

1. Нэгдэх нь, Нүүдэлчдийн соёлын өмнөх үе. Энэ бол эрт дээр үеэс нүүдэлчдийн соёл бүрэлдэх үе хүртэлх хугацаа юм. Энэ үеийн тал нутгийн соёлын үндсэн шинж нь олон төрлийн соёл, өөрөөр хэлбэл, түүн цуглуулга, загас агнуур, ан агнуур, мал аж ахуй, газар тариалан зэрэг соёлууд ар араасаа үүсэж, харилцан шүтэлцээтэй байсан явдал юм. Талын төрөл, уур амьсгал, угсаатны бүлгүүд өөр өөр байдаг тул эдгээр эдийн засаг, соёлын төрлүүдийн үүсэл, оршин тогтнох, давамгайлах байдал нь харилцан адилгүй байдаг. Харин ерөнхийдөө энэ үеийн талын соёлд цуглуулга, ан агнуурын соёл зонхилох байр суурь эзэлсээр удаж байна.
2. Нүүдэлчдийн соёлын үе. Энэ бол нүүдлийн соёл бүрэлдэн тогтсон үеэс эхлэн уналтын үе хүртэлх бэлчээрийн соёлын цэцэглэн хөгжсөн үе юм. Энэ үеийн талын соёлын үндсэн шинж нь нүүдэлчдийн соёл зонхилох байр суурь



эзэлдэг. Талын соёл тархсан олон бүс нутагт ялангуяа Евроазийн тал хээрийн бүс нутагт талын соёл, нүүдэлчдийн соёл бүрэн нэгдмэл байдаг. Иймд энэ үеийн талын соёлын судалгааг нүүдэлчдийн соёл судлалтай бүрэн адилтгаж болно.

3. Нүүдэлчдийн соёлын дараах үе. Энэ бол талын соёлын шилжилтийн үе бөгөөд ойролцоогоор нүүдэлчдийн соёлын уналтаас эхэлдэг. Энэ үеийн талын соёлын үндсэн шинж чанар нь нүүдэлчдийн соёлын урт хугацааны ноёрхол задарч эхэлсэн явдал юм. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр нь соёлыг бий болгох хүчин зүйл болохын хувьд нөлөө, байр сууриа улам өргөжүүлж, талын соёл дахин хөгжлийн эхлэлийг тавьсан юм.

Бид талын соёл, нүүдэлчдийн соёлын дээр дурдсан түүхэн үе шатуудад харьцуулсан дүн шинжилгээ хийсний үндсэн дээр түүхийн янз бүрийн цаг үед талын соёл, нүүдэлчдийн соёлын харилцаа бүрэн нийцдэггүй байжээ гэсэн дүгнэлтийг хийсэн. Энэ үеийн тал нутгийн соёл нь нүүдэлчдийн соёлтой ямар нэгэн холбоотой бол зөвхөн малын үржүүлэг, үйлдвэрлэл явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой байдлын тухайд л юм. Нүүдэлчдийн соёл нь бэлчээрийн соёлд далд бөгөөд ил тод бус байдлаар оршиж байсан. Нүүдлийн соёл, тал нутгийн соёл, нүүдэлчдийн соёл зэрэг нь бараг давхцаж байв. Тиймээс бид тал нутгийн соёлыг цаг хугацаа, түүхэн нөхцөл байдлаас үл хамааран нүүдлийн соёл гэж зүгээр нэг нэрлэж болохгүй.

Дээр дурдсан тал нутгийн соёл, нүүдлийн соёлыг утга агуулга, тархалт, гарал үүсэл, хөгжлийн явцын харьцуулсан шинжилгээнээс үзэхэд эл хоёр нь барилгын шинж чанарын хувьд ч илэрхий ялгаатай байгааг харж болно. Тэр нь:

Нэгдүгээрт, талын соёл нь бүс нутгийн соёл, үндэсний соёлын нэгдэл юм. Бүс нутгийн соёлын хувьд бэлчээрийн соёл гэдэг нь анхдагч соёл, хоёрдогч соёл, симбиотик соёл зэрэг тодорхой бэлчээрийн нутаг дэвсгэрт ургаж, ургуулсан соёлыг хэлнэ. Энд бэлчээрийн тал нь байгалийн газарзүй, түүхэн газарзүйн ойлголт төдийгүй, бүх нийтийн өвөрмөц ач холбогдлыг агуулсан соёлын газарзүйн чухал ойлголт юм. Бүс нутгийн соёлын хувьд бэлчээрийн соёлоос, хоёр голын сав газрын соёл, Шар мөрний сав газрын соёл зэрэг бүс нутгийн бусад томоохон соёлоос ялгарах нэг чухал зүйл нь овог аймгуудын холбоотнууд хамтран бүтээн хөгжүүлж ирсэн олон үндэстний соёл юм. Нэг үндэстэн давамгайлсан үндэсний соёл гэхээсээ илүүтэй тал нутгийн соёл нь түүхэн цаг үе бүрд өөр өөр үндэсний хэлбэр, угсаатны соёлын хэв маягийг багтаан харуулжээ. Нүүдлийн соёл нь эдийн засгийн соёлын хувьд гол төлөв үйлдвэржсэн аж ахуй, үндэстний нэгдмэл байдал юм. Хэдийгээр нүүдэлчдийн үйлдвэрлэл нь бэлчээрийн нутаг дэвсгэрээс салшгүй шинж чанартай боловч бидний өмнө судалсанчлан нүүдэлчдийн соёл нь эдийн засгийн соёл болох бэлчээрийн соёлтой адил юм. Үүнд, үндсэн ялгаа байсаар байна.

Хоёрдугаарт, тал нутгийн соёл бол нүүдэлчдийн соёл, олон соёлын нэгдэл юм. Энэ соёл нь бэлчээрийн байгаль экологид суурилдаг бөгөөд бэлчээрийн байгаль экологийн орчинд эрт дээр үеэс цуглуулга, ан агнуур, нүүдлийн мал аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр зэрэг соёлын төрөл бүрийн хэлбэрүүд дараалан бий болсон. Эдгээр соёлын

хэлбэрүүд нь түүхийн янз бүрийн цаг үед бэлчээрийн соёлд өөр өөр өнцгөөс соёлын шинэ элемент, эрч хүчийг сэлбэн Ошингээж, бэлчээрийн соёлыг нүүдлийн соёл, газар тариалангийн соёл болон бусад соёл зэрэг олон үйлдвэрлэлийн аргад суурилсан олон соёлын цуглуулга болгожээ. Нүүдэлчдийн соёлыг эдийн засгийн соёл гэж бид туйлын цэвэршүүлж чадахгүй ч үнэндээ туйлаас цэвэр нүүдэлчдийн үйлдвэрлэл нь түүхэн нөхцөл байдалд нийцэхгүй. Гэхдээ бид эдийн засгийн соёлыг бусад эдийн засагтай харьцуулах боломжгүйг анхаарах хэрэгтэй. Энэ нэгдмэл байдал нь зөвхөн бүс нутгийн соёлд л бий болно.

Гуравдугаарт, тал нутгийн соёл бол орчин үеийн соёл, уламжлалт соёлын нэгдэл юм. Талын соёл нь өнө эртний соёлын өв, уламжлалтай бөгөөд үүнийгээ хадгалж, хөгжүүлэх үйл явцдаа орчин үеийн соёлын ашиг тустай бүхий л хүчин зүйлийг идэвхтэй шингээж, орчин үеийн шинж чанараа дотоод агуулгаас гадаад хэлбэр рүү тасралтгүй сайжруулж, хөл нийлүүлэн алхсаар байна. Тиймээс талын соёл нь уламжлалт соёл, орчин үеийн соёлын органик нэгдэл болсон юм. Орчин үеийн үйлдвэрлэлийн арга хэлбэрүүд аажмаар өөрчлөгдөж, төрөлжсөнөөр нүүдэлчдийн соёлын ердийн амьдралын хэв маяг өөрчлөгдөж, суурин, хагас суурин, хотжилтод шилжиж эхэлсэн. Хотын амьдрал бол урьдчилан таамаглаж байсан зүйл юм. Энэ тохиолдолд нүүдэлчдийн соёлд үзүүлэх нөлөө нь илэрхий бөгөөд түүний үндэс суурь, цөм болох нүүдэлчдийн үйлдвэрлэл, амьдралын хэв маягийн түүх дуусаж байна.

## **6.2. Хятад засгийн газар ба тал нутгийн наадмууд**

Нүүдэлчдийн соёлын тухайд өмнөх эрдэм шинжилгээний талбарынхны судалгааны үр дүнгээр нотолгоо болгож, Хятадын Засгийн газраас гаргасан бодлогын баримт бичигт үндсэндээ “Нүүдлийн соёл, аж ахуй” гэж ярихгүй, харин “Тал нутгийн соёл” гэж л ярих болсон. Тухайлбал, Хятадын Төрийн Зөвлөлийн 2011 онд нийтэлсэн “Бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой хөгжлийг ахиулах Төрийн Зөвлөлийн хэд хэдэн санал дүгнэлт”-д дараах байдлаар заасан нь:

“Талын бүс нь манай улсын эдийн засаг, нийгмийн ерөнхий хөгжилд стратегийн чухал байр суурь эзэлдэг. Хятадын Коммунист Намын Төв Хороо, Төрийн Зөвлөл мал аж ахуйн ажилд чухал ач холбогдол өгч, түүхэн янз бүрийн цаг үед бэлчээрийн ажилд чухал шийдвэр, зохицуулалт хийж, дэмжлэгээ тасралтгүй нэмэгдүүлсээр ирсэн. Бүх үндэстэн, угсаатны бүлгийн боловсон хүчин, олон түмний хамтын хүчин чармайлтаар бэлчээрийн мал аж ахуйн бүс нутаг эдийн засаг, нийгмийн хөгжилд томоохон амжилт гаргалаа. Гэсэн хэдий ч байгаль, газар зүй, түүх болон бусад шалтгааны улмаас бэлчээрийн мал аж ахуйн хөгжилд онцгой хүндрэл, бэрхшээл тулгарсаар байгаа бөгөөд буурай хөгжилтэй бүс нутгийн байдал үндсэндээ өөрчлөгдөөгүй, эдийн засаг, нийгмийн хөгжлийн сул зангилаа болсон байна” гэх мэтээр ярьсан байгаа юм.

Мөн тэд бэлчээрийн мал аж ахуйн эрүүл, эрчимтэй хөгжлийг дэмжих зорилгоор дараах саналуудыг дэвшүүлсэн байна:

1. Бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийг дэмжихийн ач холбогдлыг бүрэн ойлгох. Одоогийн байдлаар манай улсын бэлчээрийн бүс нутагт 13 мужийн (өөртөө засах муж) 268 бэлчээрийн мал аж ахуйн хагас бэлчээрийн хошуу (хошуу, хот) голчлон багтаж байгаа бөгөөд нийт газар нутгийн 40 гаруй хувийг бэлчээрийн бүс эзэлдэг. Тал нутаг бол манай орны хуурай газрын хамгийн том экосистем юм. Бэлчээрийн бүс нутаг нь томоохон гол мөрөн, усны хамгаалалтын бүсүүдийн өлгий нутаг бөгөөд экологийн байдал нь маш чухал юм. Бэлчээрийн мал аж ахуй нь эдийн засгийн хөгжлийн суурь салбар, малчдын орлогын гол эх үүсвэр, үндэсний мал аж ахуйн чухал салбар юм. Бэлчээрийн бүс нутаг нь ашигт малтмалын баялаг, усан цахилгаан станц, салхины эрчим хүч, нарны эрчим хүч болон бусад нөөцөөр баялаг бөгөөд аялал жуулчлалын нөөц мөн ихтэй нь эх орны минь стратегийн баялгийн чухал үргэлжлэл юм. Бэлчээрийн бүс нутаг нь гол төлөв хилийн бүс нутаг, үндэстний цөөнхийн бүс нутагт тархсан бөгөөд угсаатны эв нэгдэл, хилийн тогтвортой байдлыг хангах чухал үүргийг гүйцэтгэдэг. Бэлчээрийн эрүүл, эрчимтэй хөгжлийг дэмжих нь бэлчээрийн экологийн хамгаалалт, бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, үндэсний экологийн аюулгүй байдлын саад тотгорыг бий болгох зайлшгүй шаардлага бөгөөд бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийн хэлбэрийг өөрчилж, малчдын орлогыг нэмэгдүүлэх бодит сонголт юм. Бүс нутгийн хөгжлийн зөрүүг багасгаж, чинээлэг нийгмийг бүх талаар цогцоор нь бий болгох зорилтын зайлшгүй шаардлага нь бүх үндэстний ард түмэнд шинэчлэл, хөгжлийн үр шимийг хүртэх боломжийг олгох стратегийн арга хэмжээ юм.

2. Бэлчээрийн мал аж ахуйн эрүүл, эрчимтэй хөгжлийг түргэтгэх нь чухал бөгөөд яаралтай ажил юм. Шинэчлэл, нээлттэй байдал, ялангуяа барууны хөгжлийн стратеги хэрэгжсэнээс хойш бэлчээрийн экологийн бүтээн байгуулалтыг өргөн хүрээнд хийж, бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийн хэлбэрийг үе шаттайгаар өөрчилж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хурдыг ахиулсаар байна. Хурдацтай хөгжиж, малчдын амьжиргааны түвшин мэдэгдэхүйц дээшилж, хот хөдөөгийн өнгө үзэмжид таатай өөрчлөлт гарч, шинэ түүхийн эхлэл болж байна. Гэвч бэлчээрийн экологийн нийт доройтлыг үндсээр нь тогтоогоогүй, бэлчээрийн мал аж ахуйн өргөн хүрээтэй өсөлтийн хэв маяг тогтворгүй, бэлчээрийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, нийгмийн бүтээн байгуулалт өрийн дарамт ихтэй байгааг бид бас ухамсартайгаар ойлгох ёстой. Малчдын амьжиргааны түвшин ерөнхийдөө газар тариалангийн бүс нутгаас хоцорч байна. Бэлчээрийн мал аж ахуй бол манай улсын хувьд чинээлэг нийгмийг бүх талаар цогцлооход хэцүү цэг хэвээр байна. Хариуцлага, шуурхай байдлыг улам нэмэгдүүлж, бэлчээрийн мал аж ахуйн эдийн засаг, нийгмийг эрүүл, эрчимтэй хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, арга хэмжээг ерөнхийд нь болон стратегийн үүднээс авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3. Бэлчээрийн бүсийг хөгжүүлэх үндсэн бодлогыг цаашид тодорхой болгох. Бэлчээр нь мал аж ахуйг хөгжүүлэх чухал үйлдвэрлэлийн хэрэгсэл төдийгүй экологийн чухал үүргийг гүйцэтгэдэг. Газар тариалан, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнэмлэхүй хомсдолд орсон энэ үед үйлдвэрлэлийг эрэмбэлэхийн нөлөөгөөр бэлчээрийн үйлдвэрлэлийн чиг үүргийг чухалчилж, экологийн үйл ажиллагааг орхигдуулж, үр дүнд нь урт- бэлчээрийн хэт ачаалал, хүн, амьтан, өвс ургамлын хоорондын харилцааны тасралтгүй тэнцвэргүй байдал

нь бэлчээрийн экологийг даван туулахад хүндрэл учруулж байв. Бэлчээрийн экологийн “буянтай” эргэлтийг ухамсарлаж байж л бэлчээрийн мал аж ахуй тогтвортой хөгжих бат бөх суурийг тавьж, экологийн соёл иргэншлийг төлөвшүүлэх зайлшгүй хэрэгцээг хангаж чадна гэдгийг бид ухамсарлах ёстой. Манай улсын үндэсний иж бүрэн хүч чадал нэмэгдэж, газар тариалан, мал аж ахуйн иж бүрэн үйлдвэрлэлийн хүчин чадлыг тасралтгүй сайжруулснаар бид бэлчээрийн экологи, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын амьдрал хоорондын уялдаа холбоог илүү сайн зохицуулж чадсан билээ. Түүхэн шинэ нөхцөлд бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэх нь үйлдвэрлэл, экологийн органик уялдаа холбоог эн тэргүүнд тавих үндсэн бодлогыг бий болгож, эдийн засаг, нийгмийн эрүүл, хурдацтай хөгжлийн шинэ замыг асаах ёстой”<sup>39</sup> гэжээ.

Энэ байдлаас харахад төр, засгийн газрын холбогдох бүх дискурсад “нүүдлийн” гэх үг хэрэглэгдэхгүй болсон нь илэрхий байгаа юм. Тэрчлэн судлаачийн ажигласнаар бүх шатны засгийн газрууд төвлөрсөн бодлогын дагуу бэлчээрийн соёлын юм уу, тал нутгийн соёлын гэх нэрийн дор төрөл бүрийн нийгэм-соёлын арга хэмжээг зохион байгуулж ирсэн. ӨМӨЗО-ы олон улсын тал нутгийн соёлын анхдугаар наадам 2004 оны 8 дугаар сарын 6-аас 15-ны хооронд ӨМӨЗО-ы нийслэл Хөх хотод болж, дараа нь жил бүр зохион байгуулагддаг болов. Тогтмол болж байгаа эдгээр тал нутгийн соёлын наадам нь эрдэм шинжилгээний семинар, эртний уран бичлэг, уран зураг, загвар өмсөгчдийн уралдаан, хөрөнгө оруулалтын төслийн хурал болон бусад олон зүйлийг хамарсан үндэсний хэмжээний соёл, эдийн засаг худалдаа, аялал жуулчлал, спортын үйл ажиллагааг явуулж байгаа юм. 2022 он хүртэл ӨМӨЗО олон улсын 19 дэх удаагийн “Бэлчээрийн соёлын наадам”-ыг амжилттай зохион байгуулж, дотоод гадаадад бэлчээрийн соёлыг түгээн дэлгэрүүлэв. Иймээс ӨМӨЗО-ы засаг захиргааны бүх байгууллага Өвөр Монголын бэлчээрийн соёлын наадмаас үлгэр дуурайл авч, олон төрлийн соёлын арга хэмжээ зохион байгуулж байна. Хөх хотын Жаожүнгийн соёлын наадам, Бугат Лучэнгийн соёлын наадам, Баяннуурын Бортохойн соёлын наадам, Ордосын соёлын наадам болон Азийн урлагийн 11 дэх наадам, Алшаа дахь эко аялал жуулчлалын наадам, Цахрын соёлын наадам, Шилийн голын Юань гүрний соёлын наадам, Чифэн, Тунляод Хорчин урлагийн наадам, Хөлөнбуйрт Дагуур, Эвэнки, Орчон, Манжуурт “Гурван цөөнх”-ийн наадам зэрэг тал нутгийн соёлын наадам олноор зохион байгуулж байгаа юм. Хятадын шилдэг арван соёлын наадмын нэг болжээ .

Ордос хотод Чингис хаандаа хүндэтгэл үзүүлж, Монгол тахилгын соёлыг мэдэрч,

---

<sup>39</sup> Газар тариалангийн соёл иргэншил, нүүдэлчдийн соёл иргэншил нь дэлхийд алдартай түүхэн дэх хоёр том соёл иргэншил юм. Гэвч нүүдэлчдийн соёлын түүхэн баримт цөөн, нүүдэлчдийн түүхийг тариаланчид тэмдэглэж үлдээдэг тул тэдний өгүүлэмж нь ихэвчлэн өрөөсгөл, бие биенээ дорд үзсэн шинжтэй байдаг. Түүхийн анхны нүүр царайг гэмтээсэн хожмын үеийнхэн нүүдэлчдийн материаллаг болон оюун санааны амьдралын талаар олон хуурмаг төсөөлөлтэй байв. Сима Цяны зохиолуудад ч ийм нөхцөл байдал бий. Олон эрдэмтэд Хятадын соёлын онцлогийг авч үзэхдээ нүүдэлчдийн соёлыг бага, эсвэл огт авч үздэггүй. Орчин үеийн дээд боловсролын сурах бичиг болох “Хятадын соёлын оршил” сурах бичигт ч нүүдэлчдийн соёлын талаарх ойлголт хангалтгүй байгаа нь илт. Тухайлбал, тус тусдаа бүлгүүдийн бага сага хэсэгт л дурдагддаг бөгөөд түүхийн уламжлалт үзлээс бүрэн мултарсангүй.

Ордосын дуу, бүжиг үзэх нь Өвөр Монголд ирсэн хүмүүсийн заавал байх ёстой зүйл болжээ. Тэр дундаа Ордос монголчуудын түүх, ордны болон ардын соёл, ёс заншил, хувцасны соёлыг шингээсэн “Ордосын хурим” дуу бүжгийн жүжиг нь Ордос хотын сайхныг харуулсан дэлхийн соёлын брэнд болсон билээ. Мөн Хөлөнбуйр хотод болдог тал нутгийн соёлын олон тоглолт, арга хэмжээ нь Хятадын хамгийн үзэсгэлэнтэй гэгдэх бэлчээрийг илүү өвөрмөц болгож байна.

Ухай хот бол байгуулагдаад 30-хан жил болж байгаа уул уурхайн хот бөгөөд хэдийгээр түүх соёлын хуримтлалгүй ч уран бичлэгийг гоо сайхан болгон авч, бага, дунд сургуульд уран бичлэг, түүнийг урлагийн талаас нь эрчимтэй сурталчилж байна. “Хятадын уран бичлэгийн хот”- тэдний хотын брэнд болжээ.

ӨМӨЗО-ы 105 хошуу, дүүрэг ч мөн өөр өөрсдийн соёлын наадмыг зохион байгуулах болсон. Нутгийнхаа ёс заншлыг эхлэл болгож, наадам, монгол уртын дуу, Андай бүжгийн соёлын наадмуудыг зохион байгуулдаг болов. Өөр өөр шинж чанартай эдгээр соёлын цэнгүүн нь хөх тэнгэр, цагаан үүлэн дундах бэлчээрийн гайхамшигтай, өнгөлөг соёлыг харуулдаг. Өвөр Монголын Өөртөө Засах Орны бэлчээрийн соёлын тухай өөр нэг баримт бичгийг “Тал нутгийн соёлын аж үйлдвэрийг хөгжүүлэх үндсэн нөхцөл ба гол талбарууд” гэж нэрлэдэг бөгөөд энэ нь бэлчээрийн соёлыг соёлын аялал жуулчлал, театрын үзүүлбэр, радио, кино, хэвлэл, соёлын үзэсгэлэн болон бусад үзэсгэлэн, амралт зугаалга зэрэг зургаан салбарт эдийн засгийн ашигтай бүтээгдэхүүн болгодог. Гэх мөртөө нүүдлийн соёл, түүний экологийн ашиг тусыг огт дурддаггүй. Нүүдэлчид мал аж ахуйгаа хэрхэн түшиглэж, эдийн засгийн үр өгөөжөө хөгжүүлж, бэлчээрийн аборигенчуудын амьжиргааг дээшлүүлдэг талаар дурдаж болохгүй бололтой. Өвөр Монголын баялгийн давуу тал, зах зээлийн хэтийн төлөвийн дагуу дээр дурдсан зургаан том салбарыг хөгжүүлэх ёстой гэдэг. Тэдгээр нь:

1. Соёлын аялал жуулчлалыг өргөжүүлэх. Өвөр Монголын түүх соёл, угсаатны зан заншил, байгалийн үзэмж, бүтээгдэхүүн болон аялал жуулчлалын бусад нөөц нь байгальд эргэн ирж буй хүмүүсийн хувьд шинэлэг зүйл, өвөрмөц онцлог, гайхамшигийг эрэлхийлэх зэрэг орчин үеийн нийгмийн оюун санаа, соёлын хэрэгцээг хангаж, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх хэтийн төлөв өргөн хүрээнд байна. Сүүлийн жилүүдэд, тус бүс нутагт нямбай сайн бүтээн байгуулалт хийсний дараагаар “Хөлөнбуйр-Манжуурын бэлчээрийн ой”, “Галт уулын халуун рашаан” гэх мэт аялал жуулчлалын олон маршрутыг эхлүүлэв. Соёлын аялал жуулчлал нь Өвөр Монголын дээд аж үйлдвэрийн тулгуур салбар болж, өнгөрсөн онд тус бүс нутаг гадаад, дотоодоос 16 сая орчим жуулчин хүлээн авч, нийт орлого нь 14 тэрбум 500 сая юаньд хүрчээ. Цаашид бид аялал жуулчлалын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг улам эрчимжүүлж, аялал жуулчлалын нөөц баялгийн соёлын утгыг анхаарч, Өвөр Монголын үндэсний өвөрмөц соёлыг нэгтгэн уялдуулахын зэрэгцээ аялал жуулчлалын чанартай дөрвөн чиглэлийг бий болгоход анхаарч ажиллах ёстой. Жуулчдын аялал, аялал жуулчлал, байр, хоол хүнс, худалдаа, үзвэр үйлчилгээ гэх мэт төрөл бүрийн чиглэлд бид бүс нутгийн соёлын онцлог, мэдрэмжийг шингээсэн томоохон, шинэ төслүүдийг эхлүүлэхийг хичээх болно. ӨМӨЗО-ы аялал жуулчлалыг хөгжүүлэх бас нэг гол зүйл бол аялал жуулчлалын бараа бүтээгдэхүүнийг түргэн шуурхай хөгжүүлж, аялал

